



АЛТАИСТИКА, ТҮРКОЛОГИЯ, МОҢҒОЛИСТИКА

Халықаралық ғылыми журнал

АЛТАИСТИКА, ТҮРКОЛОГИЯ, МОНГОЛИСТИКА

Международный научный журнал

ALTAISTICS, TURCOLOGY, MONGOLISTICS

International Scientific journal

2020

Nº 4



АЛТАИСТИКА, ТҮРКОЛОГИЯ, МОНГОЛИСТИКА

ХАЛЫҚАРАЛЫҚ ҒЫЛЫМИ ЖУРНАЛ



АЛТАИСТИКА, ТҮРКОЛОГИЯ, МОНГОЛИСТИКА

МЕЖДУНАРОДНЫЙ НАУЧНЫЙ ЖУРНАЛ



ALTAISTICS, TURCOLOGY, MONGOLISTICS

INTERNATIONAL SCIENTIFIC JOURNAL

2020/4

АЛТАИСТИКА, ТҮРКОЛОГИЯ, МОҢҒОЛИСТИКА

Халықаралық ғылыми журнал / №4, 2020

Редакцияның мекен-жайы:

Тәуелсіздік даңғылы, 57, Бейбітшілік пен келісім сарайы, 7-қабат, Нұр-Сұлтан,
010000, Қазақстан Республикасы, тел.: +7 (7172) 744785
e-mail: napilbaz@gmail.com, aasem-dariya72@mail.ru

*Журнал Қазақстан Республикасы Ақпарат және коммуникациялар министрлігінде
4 маусым 2018 жылы тіркеліп, №17132-Ж куәлік берілген.*

*Меншік иесі: Халықаралық Түркі академиясы,
Алтаистика, түркология, моңғолистика ассоциациясы (АТАМ)*

2018 жылдан бастап шыға бастаған журнал жылына 4 рет жарияланады.

Бас редактор

Қыдырәлі Дархан Қуандықұлы - т.ғ.д., профессор, ҚР ҰҒА академигі

Редакциялық алқа

Ахметов Әділ Құрманжанұлы – ф.ғ.д., профессор (Қазақстан); **Берталан Агнеш** - филология докторы, профессор (Мажарстан); **Габибейли Иса** – ӘР ҰҒА академигі, ф.ғ.д., профессор (Әзербайжан); **Дыбо Анна Владимировна** - ф.ғ.д., профессор, РҒА корр.-мүшесі (Ресей); **Жолдасбеков Мырзатай** – ф.ғ.д., профессор, ҚР ҰҒА академигі (Қазақстан); **Келлнер-Хейнкеле Барбара** - филология докторы, профессор (Германия); **Кожоғлу Тимур** – филология докторы, профессор (АҚШ); **Конкобаев Кадыралы** – ф.ғ.д., профессор (Қырғызстан); **Көмеков Болат Ешмұхамбетұлы** - т.ғ.д., профессор, ҚР ҰҒА академигі (Қазақстан); **Минуллин Ким Мугаллимович** - ф.ғ.д., профессор (Татарстан); **Түймебаев Жансейіт Қансейітұлы** - ф.ғ.д., профессор (Қазақстан); **Чулуун Сампилдондовын** - т.ғ.д., профессор (Моңғолия); **Хисамитдинова Фирдаус Гильмитдиновна** - ф.ғ.д., профессор (Башқұртстан)

Редакциялық кеңес

Бабаяров Ғайбулла Боллиевич – т.ғ.д. (Өзбекстан); **Бира Шагдарын** - т.ғ.д., профессор, МҒА академигі (Моңғолия); **Бутанаев Виктор Яковлевич** - т.ғ.д., профессор (Хакасия); **Васильев Дмитрий Дмитриевич** - т.ғ.к., профессор, РЖҒА корр.-мүшесі (Ресей); **Ержиласун Ахмет Бижан** – филология докторы, профессор (Түркия); **Иваныч Мари** - доктор, профессор (Мажарстан); **Кузьмина Евгения Николаевна** - ф.ғ.д., профессор (Ресей); **Кызласов Игорь Леонидович** – т.ғ.д., профессор (Ресей); **Попова Ирина Федоровна** – т.ғ.д., профессор (Ресей); **Райхл Карл** - филология докторы, профессор (Германия); **Солонгод Хурибаатар** - ғылым докторы, профессор (Германия); **Тажибаева Сәуле Жаксылықбаевна** - ф.ғ.д., профессор (Қазақстан); **Худяков Юлий Сергеевич** – т.ғ.д., профессор (Ресей); **Цэвээндорж Дамдинсүрэнгийн** - т.ғ.д., профессор, МҒА академигі (Моңғолия); **Чой Хан Ву** - филология докторы, профессор (Корея); **Шамильоглу Юлай** - филология докторы, профессор (АҚШ); **Янковский Генрик** - филология докторы, профессор (Польша)

Жауапты редакторлар

Абаева Әсем-Дария Әскербекқызы – ф.ғ.к.; **Базылхан Нәпіл** – ф.ғ.к.; **Козырев Тимур Анатольевич** – ф.ғ.к.; **Тойшанұлы Акеділ** – ф.ғ.к.

Компьютерде беттеген

А. Скакова

© Халықаралық Түркі академиясы, 2020

© Алтаистика, түркология, моңғолистика
ассоциациясы - АТАМ, 2020

© “Ғылым” баспасы, 2020

АЛТАИСТИКА, ТЮРКОЛОГИЯ, МОНГОЛИСТИКА

Международный научный журнал / №4, 2020

Адрес редакции:

пр.Тәуелсіздік, 57, Дворец мира и согласия, 7-этаж, Нур-Султан,
010000, Республика Казахстан, тел.: +7 (7172) 744785
e-mail: napilbaz@gmail.com, aasem-dariya72@mail.ru

*Журнал зарегистрирован в Министерстве информации и коммуникации Республики Казахстан
от 4 июня 2018 года, выдано свидетельство №17132-Ж.*

*Собственник: Международная Тюркская академия,
Ассоциация алтаистики, тюркологии, монголистики (АТАМ)*

Журнал издается с 2018 года с периодичностью четыре раза в год.

Главный редактор

Кыдырали Дархан Куандыкулы - д.и.н., профессор, академик НАН РК

Редакционная коллегия

Ахметов Адил Курманжанович – д.ф.н., профессор (Казахстан); **Берталан Агнеш** - доктор филологии, профессор (Венгрия); **Габибейли Иса** – д.ф.н., профессор, академик НАНА (Азербайджан); **Дыбо Анна Владимировна** - д.ф.н., профессор, член-корр. РАН (Россия); **Жолдасбеков Мырзатай** – д.ф.н., профессор, академик НАН РК (Казахстан); **Келлнер-Хейнкеле Барбара** - доктор филологии, профессор (Германия); **Кожаоглу Тимур** – доктор филологии, профессор (США); **Конкобаев Кадыралы** – д.ф.н., профессор (Кыргызстан); **Кумеков Болат Ешмухамбетович** - д.и.н., профессор, академик НАН РК (Казахстан); **Минуллин Ким Мугаллимович** - д.ф.н., профессор (Татарстан); **Туймебаев Жансейит Кансейитович** - д.ф.н., профессор (Казахстан); **Чулуун Сампилдондовын** - д.и.н., профессор (Монголия), **Хисамитдинова Фирдаус Гильмитдинована** - д.ф.н., профессор (Башкортостан)

Редакционный совет

Бабаяров Гайбулла Боллиевич – д.и.н. (Узбекистан); **Бира Шагдарын** - д.и.н., профессор, академик АН МНР (Монголия); **Бутанаев Виктор Яковлевич** - д.и.н., профессор (Хакасия); **Васильев Дмитрий Дмитриевич** - к.и.н., профессор, член-корр. РАН (Россия); **Ержиласун Ахмет Бижан** – доктор филологии, профессор (Турция); **Иваныч Мари** - доктор, профессор (Венгрия); **Кузьмина Евгения Николаевна** - д.ф.н., профессор (Россия); **Кызласов Игорь Леонидович** – д.и.н., профессор (Россия); **Попова Ирина Федоровна** – д.и.н., профессор (Россия); **Райхл Карл** – доктор филологии, профессор (Германия); **Солонгод Хурцбаатар** – доктор наук, профессор (Германия); **Тажибаева Сауле Жаксылыкбаевна** - д.ф.н., профессор (Казахстан); **Худяков Юлий Сергеевич** – д.и.н., профессор (Россия); **Цэвэндорж Дамдинсүрэнгийн** - д.и.н., профессор, академик АН МНР (Монголия); **Чой Хан Ву** – доктор филологии, профессор (Корея); **Шамильоглу Юлай** – доктор филологии, профессор (США); **Янковский Генрик** – доктор филологии, профессор (Польша)

Ответственные редакторы

Абаева Асем-Дария Аскербековна – к.ф.н.; **Базылхан Напил** – к.ф.н.; **Козырев Тимур Анатольевич** – к.ф.н.; **Тойшанулы Акедил** – к.ф.н.

Компьютерная верстка
Скаковой А.

© Международная Тюркская академия, 2020
© Ассоциация алтаистики, тюркологии, монголистики -АТАМ, 2020
© Издательство “Гылым”, 2020

ALTAISTICS, TURCOLOGY, MONGOLISTICS

International Scientific Journal / №4, 2020

Editorial office address:

Tauelsizdik street 57, Palace of Peace and Reconciliation, 7th Floor, Nur-Sultan, 010000, Republic of Kazakhstan
Tel: +7 (7172) 744785
E-mail: napilbaz@gmail.com, aasem-dariya72@mail.ru

This journal registered on the Ministry of Information and Communication of the Republic of Kazakhstan on **June 4, 2018** and issued the certificate №7132-Ж.

Ownership: International Turkic Academy,
Association for Altaistics, Turkology, Mongolistics (ATAM)
The journal has been published since 2018, 4 issues a year.

Editor-in-Chief:

Darkhan Kydyrali - PH.D in History, Professor, Academician of National Academy of Sciences of the Republic of Kazakhstan

Editorial Board:

Adil Ahmetov - PH.D in Philology, Professor (Kazakhstan); **Anna Dybo** - PH.D in Philology, Professor, Corresponding member of Russian Academy of Sciences (Russia); **Barbara Kellner-Heinkele** - PH.D in Philology, Professor (Germany); **Birtalan Agnes** - PH.D in Philology, Professor (Hungary); **Bolat Komekov** - PH.D in Philology, Professor, Academician of National Academy of Sciences of the Republic of Kazakhstan (Kazakhstan); **Chuluun Sampildondovin** - PH.D in History, Professor (Mongolia); **Firdaus Khisamitdinova** - PH.D in Philology, Professor, (Bashkortostan); **Isa Gabibbeili** - PH.D in Philology, Professor, member of National Academy of Science of the Republic of Azerbaijan (Azerbaijan); **Kim Minullin** - PH.D in Philology, Professor (Tatarstan); **Konkobaev Kadyrali** - PH.D in Philology, Professor (Kyrgyzstan); **Myrzatai Zholdasbekov** - PH.D in Philology, Professor, member of National Academy of Sciences of the Republic of Kazakhstan (Kazakhstan); **Timur Kocaoglu** - Doctor of Philology, Professor, (USA); **Zhanseyit Tuymebaev** - PH.D in Philology, Professor (Kazakhstan)

Editorial Council:

Ahmet Bican Ercilasun - Doctor of Philology, Professor (Turkey); **Bira Shagdaryn** - PH.D in History, Professor, member of National Academy of Sciences of Mongolia (Mongolia); **Choi Khan Wu** - PH.D in Philology, Professor (Korea); **Dimitry Vasilyev** - PH.D in History, Professor, Corresponding member of Russian Academy of Natural Sciences (Russia); **Gaybolla Babayrov** - PH.D in History, (Uzbekistan); **Henryk Jankowski** - Doctor of Philology, Professor (Poland); **Igor Kyzylasov** - PH.D in History, Professor (Russia); **Irina Popova** - PH.D in History, Professor (Russia); **Karl Reichl** - Doctor of Philology, Professor (Germany); **Mary Ivanic** - Doctor, Professor (Hungary); **Saule Tazhibaeva** - PH.D in Philology, Professor (Kazakhstan); **Solonggod Hurcabaatar** - PH.D in History, Professor (Germany); **Tsevendorzh Damdinsurengiyn** - PH.D in History, member of National Academy of Sciences of Mongolia (Mongolia); **Uli Schamiloglu** - Doctor of Philology, Professor (USA); **Viktor Butanayev** - PH.D in History, Professor (Russia); **Yevgenia Kuzmina** - PH.D in Philology, Professor (Russia); **Yuliy Khudyakov** - PH.D in History, Professor (Russia);

Managing Editors

Akedil Toishanulu – Candidate of Philological Sciences; **Asem-Darya Abaeva** – Candidate of Philosophy Sciences; **Napil Bazylkhan** – Candidate of Philological Sciences; **Timur Kozyrov** – Candidate of Philological Sciences.

Designer

A. Skakova

© International Turkic Academy, 2020
© Association for Altaistics, Turkology,
Mongolistics – ATAM, 2020
© “Gylym” publishing house, 2020

МАЗМУНЫ CONTENTS

Қыдырәлі Д. <i>Алғысөз</i>	6
----------------------------------	---

АРХЕОЛОГИЯ ARCHEOLOGY

Г. Батболд

<i>Пүгү аймагт холбогдох археологийн шинэ сурвалжууд</i>	7
--	---

Д. Баярсайхан

<i>Улиастай дахь эртний хотын туурь</i>	31
---	----

ТАРИХ ЖӘНЕ ДЕРЕКТАНУ HISTORY AND HISTORICAL SOURCE

Н.А. Атыгаев, У.Канай

<i>Река Сырдарья в историко-географической литературе XV-XIX вв</i>	51
---	----

Я.В. Пилипчук

<i>Обломки Крымского ханства: борьба Гиреев и Ногайцев против Российской империи после 1783 г.</i>	81
--	----

Б. Баясгалан

Моңғолиядагы сауат ашу науқаны: 1936-1945 жж.

<i>Жетістіктер, қиындықтар, тәжірибелер</i>	95
---	----

ЭТНОГРАФИЯ ETHNOGRAPHY

Г. Бямбарагчаа

<i>Монгол дахь угсаатан судлалын ухааны түүхэн тойм: дэг ба хөгжил</i>	110
--	-----

Н. Батболд

<i>Угсаа залгамжилсан засаг ноёдыг засаг дарга болгосон нь</i>	120
--	-----

АЛҒЫСӨЗ

«Алтаистика, түркология, моңғолистика» халықаралық ғылыми журналының 2020 жылғы №4 санында моңғол археологтары Г. Батболдының «Пүгү тайпасына қатысты археологиялық жаңа деректер», Д. Баярсайханның «Улиастайдағы ежелгі қала орны» атты тың ғылыми зерттеулері жарияланып отыр.

Сонымен қатар, тарихшылар Н.А.Атығаев, Ө.Қанайдың «Сырдария өзені туралы XV-XIX ғасырлардағы тарихи-географиялық әдебиеттерде», Я.В. Пилипчуктің «Қырым хандығының сынықтары: Керей әулеті мен ноғайлардың Ресей империясына қарсы 1783 жылдан кейінгі күрестері», Б.Баясгаланның «Сауат ашу ұлттық науқаны: 1936-1945 жж. бағыттары, нәтижелері, тәжірибелері және сабақтары», этнограф ғалымдар Г. Бямбагчааның «Моңғолиядағы этнография ғылымының тарихнамасы: дамуы мен мектептері», Н. Батболд «Мұрагерлік засаг нояндарын әкім басшы еткендігі» атты ғылыми тұрғыдан күрделі де қызықты зерттеулері жарияланды.

Журналға тың материалдар мен соңы мақалалар күтеміз!

Құрметпен,
Дархан Қыдырәлі
Бас редактор

АРХЕОЛОГИЯ ARCHEOLOGY

МРНТИ 30.41.91

УДК 902. 2. 01.

ПҮГҮ АЙМАГТ ХОЛБОГДОХ АРХЕОЛОГИЙН ШИНЭ СУРВАЛЖУУД

Баатад Гончигийн Батболд

Монгол улсын ШУА-ийн

Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор

E-mail: bataad_boldoo@yahoo.com

Товчлол: Энэхүү судалгааг Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Шороон Довын газар доорхи бунхангаас олсон бичгийн эх сурвалж, археологийн олдворууд дээр үндэслэн хийсэн болно. Энэхүү дурсгалт газрын археологийн малтлага нь Монголын түүхийг өөр өнцгөөс харах боломжийг бидэнд олгож байна. Хятад, түрэг хэл дээр бичигдсэн хоёр эх сурвалж олдсон бөгөөд эдгээр нь Хятадын түүхийн түүхэнд урьд өмнө бичигдэж байгаагүй зарим мэдээллийг агуулсан байдаг. Эдгээр хоёр бичээс нь Хятадын түүхэн дэх түүхэн мэдээллийг тоймлох үндсэн эх сурвалж болж байна. Жишээлбэл, эдгээр нь өнөөгийн Монголын нутаг дэвсгэрт МЭ 630-680 оны хооронд тохиолдсон зарим түүхэн үйл явдлыг эдгээр нотолгоог орхисон хүмүүс, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчдийн өнцгөөс харах боломжийг олгодог.

Монгол улсын түүх судлалд Ти-лэ холбооны Пу-гу овгийн түүх мартагдаад удаж байна. Энэ номонд би Пу-гу овог нь Өвөр Азийн бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчдийн бүлгүүдийн улс төрд идэвхтэй оролцож, заримдаа тэд голлох үүрэг гүйцэтгэж байсан гэдгийг харуулахыг хичээсэн. Энэ овог хожмын Түрэгийн улстай маш ойр дотно харилцаатай байсан бөгөөд тэднийг хоорондоо гэр бүлтэй холбоотой холбоотон байсныг нотлох баримт байж болох юм. Уйгурын эзэнт гүрэн байгуулагдахад тэд хуучин харилцаагаа сэргээж, гэр бүлийн холбоотнууд болжээ. Улс төрийн тэргүүлэх байр суурь эзэлж буй Өвөр Азийн бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчдийн хоёр овгийн хоорондох гэрлэлтийн холбоо нь эртний дундад зууны нүүдэлчин овог аймгуудын улс төрийн нөхцөл байдал эрх баригч овгоос хүртэл гэрлэлтийн холбоо байгуулахыг үргэлж шаарддаг болохыг харуулж байна. Энэхүү заншил нь нүүдэлчдийн улс төрд томоохон сэдэл болсон бололтой.

Түлхүүр үгс: Пу-гу овог, Шороон Довын бунхан, эртний түрэг, хятад бичгийн эх сурвалж, археологийн олдворууд

ҒТАМР 30.41.91

ӘОЖ 902. 2. 01.

ПУГУ ТАЙПАСЫНА ҚАТЫСТЫ АРХЕОЛОГИЯЛЫҚ ЖАҢА ДЕРЕКТЕР

Баатад Гончигийн Батболд

Моңғолия Ғылым академиясы

Археология институтының ғылыми қызметкері, доктор

E-mail: bataad_boldoo@yahoo.com

Түйін: Моңғолия мен Ресейдің бірлескен зерттеу тобы: 2009 жылы Моңғолияның Төв аймағы Заамар сұмынында «Шороон Дов» кешенінде археологиялық қазба зерттеулері жүргізген болаты және аталмыш аймақтағы қорғандар қытайлық емес, түрктік екенін көрестеді.

Осы мақала «Шороон Дов» жерасты кесенесінен табылған археологиялық олжаларға негізделген. Бұл ескерткіштің археологиялық қазылуы бізге Моңғолия тарихына басқа көзқараспен қарауға мүмкіндік береді. Қытайлық және түркі тілдеріндегі екі жазбаша дереккөздер табылды. Бұл екі жазба мәтіндер қытай жылнамаларындағы тарихи мәліметтерді шолудың негізгі дереккөздеріне айналды. Мысалы, олар біздің дәуіріміздің 630-680 жж. аралығында қазіргі Моңғолия территориясында болған кейбір тарихи оқиғаларды көшпенділер тұрғысынан көруге мүмкіндік береді.

Моңғолия тарихнамасында Ти-ле конфедерациясының Пу-гу тайпасының тарихы бұрыннан ұмыт болып келген еді. Бұл мақалада Пу-гу тайпасының Орталық Азиял көшпелілердің саясатына белсенді қатысқанын және кейде олар жетекші рөл атқарғанын көрсетуге бағытталды. Бұл тайпа кейінгі Түрк мемлекетімен өте тығыз қарым-қатынаста болған және олардың бір-бірімен некеге тұру арқылы байланыстырылған одақтас екендіктерін дәлелдеуі мүмкін сияқты. Ұйғыр империясы құрылған кезде олар бұрынғы қарым-қатынастарын қалпына келтірді. Саяси жетекші позициядағы Орталық Азиялық көшпелілерінің екі руы арасындағы отбасылық одақ, қудандалық көрсеткендей, ерте орта ғасырлардағы көшпелі тайпалардың саяси жағдайлары әрқашан билеуші рудан да отбасылық одақ құруды талап етеді. Бұл әдет-ғұрып көшпелі саясатта үлкен түрткі болған сияқты.

Кілт сөздер: Пу-гу тайпасы, «Шороон Дов» кесенесі, көне түрк, қытай жазба деректері, археологиялық табылымдар

IRSTI 30.41.91

UDC 902. 2. 01.

ARCHAEOLOGY RELATED TO PU-GU AIMAG NEW SOURCES

Baatad Gonchigiin Batbold

Mongolian Academy of Sciences
Researcher at the Institute of Archeology, Ph.D.
E-mail: bataad_boldoo@yahoo.com

Abstract: The present research is based on written sources and archaeological findings that found from the Shoroon Dov Underground mausoleum in Zaamar Soum, Tuv aimag. The archaeological excavation of this monument gives us the possibility to look at the history of Mongolia from a different point of view. There were found two written sources in Chinese and Turkic languages that bear some information which has ever written in any Chinese historical accounts. These two inscriptions become the primary sources for the review of historical information in Chinese annals. For example, they give the possibilities to see some historical events that occurred in the territory of today's Mongolia between 630 and 680 AD from the angle of those who have left these evidences, the pastoral nomads.

In the historiography of Mongolia, the history of the Pu-gu tribe of the Tie-le confederation has long been forgotten. In this book, I tried to show that the Pu-gu tribe actively participated in politics of Inner Asian pastoral nomadic groups and sometimes they have played leading role. This tribe had a very close relationship with the Later Turkic State and it seems that the evidence can tell that they were allies which were connected to each other with intermarriage. When the Uighur Empire was established, they recovered their former relationship and became marital allies. Marital alliance between two clans of the Inner Asian pastoral nomads in political leading position shows that political circumstances of the nomadic tribes of the Early Middle Ages always required even the ruling clan to form marital alliance. This custom seems to have been a big motivation in nomadic politics.


Key words. Pu-gu tribe, Shoroon Dov mausoleum, ancient Turkic, chinese written sources, archaeological findings

2009 онд Монгол-Оросын хамтарсан судалгааны баг Төв аймгийн Заамар сумын Шороон Дов хэмээх бунхант булшийг малтан судласнаар энэ бүс нутгийн шороон овоолго бүхий бунхант булшнууд Хятаны биш Түрэгийн үеийнх болох нь тогтоогдсон юм.


Заамарын Шороон Дов бунхант булш болон бүс нутгийн хил залгаа Булган аймгийн Баяннуур сумын нутаг дахь, Хятаны үеийн Улаан Хэрэм хэмээх эртний хотын тууриас хойш 1 км орчим зайд байрлах Майхан уулын Шороон Бумбагар-1 хэмээх дурсгалыг 2011 онд малтан судалсан байдаг. Хоорондоо ижил төстэй эдгээр дурсгалууд нь Туул голын зүүн болон баруун талд 13 км зайтай оршиж буй тул ямар нэгэн сэжмээр нэг овог төрлийнхний дурсгал байж болох юм хэмээн таамаглаж байна. Хэдийгээр хоорондоо арав гаруй километр зайтай ч нүүдэлчин аймгийнхны хувьд энэ нь ойрхон барааны газар болох юм. Тиймээс хоёр дурсгалыг ойр төрлийн хүмүүст зориулсан байх магадлал их байна. Тал нутгийн нүүдэлчин аймгууд өөрсдийн эзэмшил газар нутагтай тул аймгийн тэргүүн, язгууртныхаа булшийг нутгийн гүн дэх эрхэм газраа оршоох нь зүйн ёсны байсан хэмээн хэлж болно. Дээрх хоёр дурсгал нэгэн цаг үеийнх хэмээх таамагийг маань батлахуйц баримт нь О.Намнандоржийн 1957 онд Баяннуур сумын Улаан хэрэм эртний хотын турь орчмоос илэрүүлэн судалгааны эргэлтэнд оруулсан Тан улсын үеийн хятад бичээс юм.

Заамарын Шороон Дов. Төв аймгийн Заамар сумын төвөөс өмнө зүгт 22 км-т, Туул голын зүүн дэнж дээр, Төмст уулын зүүн тал, Агит уулын баруун биед нэгэн жижиг толгой дээр, 4,2 метр өндөр шороон овгор оршино. Үүнийг нутгийнхан Шороон Дов хэмээнэ. Нүүдэлчин монголчууд өөрсдийн бэлчээрийн бүс нутаг, тойрон хүрээлэх газраа нэрлэхдээ тухайн газрын хэлбэр онцлогт тохируулдаг. Өөрөөр хэлбэл үүнтэй ижилсэх ойролцоо дурсгалуудыг Шороон Бумбагар, Шороон Дов, Олон Дов, Гурван Дов гэх мэт нэрлэдэг бол хэрэм бүхий газруудыг Дөрвөлжин, Хэрэм, Хүрээ гэх мэтээр тухайн байгууламжийн хэлбэр, зориулалтаар нь нэрлэж буй нь ажиглагддаг. Тиймээс Шороон Дов хэмээх нэрээс харахад уулын толгой дээр бэсрэг шороон овоолго дов байгаа нь ингэж нэрлэхэд хүргэжээ. Шороон Дов нь сууриараа дугриг дээш шувтан /конус/ хэлбэртэй бөгөөд түүний суурийн голч нь 30 метр орчим юм. Шороон Довыг үйлдэхдээ шаврыг 15-20 см зузаантайгаар үелүүлэн дэлдсэн байна. Шороон Довыг тойрсон дөрвөлжин шороон далантай бөгөөд баруун, зүүн тал нь 110 м, хойд, урд тал нь 90 метр хэмжээтэй. Шороон далан он цагийн уртад элэгдэн эвдэрч зарим хэсэгтээ мэдэгдэхгүй шахам болжээ. Үлдсэн далангийн одоогийн өргөн 2-3 м, өндөр нь 20-50 см орчим байна. Шороон Довын өмнө зүгт далангийн үүд байгаа бололтой түүний өргөн 8 метр байна [1,17-31].

Шороон Довоос залгуулаад баруун өмнө зүгт бунхан руу орох үүдэнд 20 гаруй метр урттай, 3 метр орчим өргөнтэй 0.2-0.5 м орчим өндөртэй гүвгэр шороон дараас мэдэгдэнэ. (Зураг 1, 2) Бунханы үүдэвч нь задгай байдалаар 10.8 м үргэлжлээд газар доогуур хөндийлөн ухаж гаргасан хонгилтой. Хонгилд бунхан хүртэл гурван гэгээвч (tian jing - 天井) гаргаж өгсөн байна. Үүдэвчний нийт урт 23 метр байна. Бунхан нь гол өрөө болон үүдэвчний хоёр хананд тус бүр нэг, хоёр тахилын хөмөгтэй юм. Тус бунхны тоон үзүүлэлтийг хойно хүснэгтлэн өгүүлэх тул түүнээс харж болно.




Зураг 1. Заамарын Шороон Дов дэвсгэр зураг



Зураг 2. Заамарын Шороон Довын бунхны дэвсгэр ба зүсэлтийн зураг. Зохиогчийн зураг

Заамарын Шороон Дов дурсгалын малтлагаар булшны бичээс, булшинд дагуулсан олон төрлийн модон болон шавар хүүхэлдэй гарчээ. Модон хүүхэлдэйн дунд зөвхөн цээж нүүрийг дүрслээд гадуур нь хувцас өмсүүлсэн хүүхэлдэй нилээд хувийг эзэлж байна. Бунханд модон тавиур байсан бололтой. Бунхны дээвэр нурахад модон тавиур маш ихээр эвдэрч бараг зомгол болсон байв. Уг бунханд модон хүүхэлдэйн дунд адуу, тэмээ, толгой нь хөдөлдөг оньстой луу, хүн нүүртэй шувуу биет (галбинга) зэрэг нилээд содон хийцтэй хүүхэлдэй гарсныг дурдаж болно (Зураг 3).

Туг байж болохуйц томоохон улаан давууг баруун хөмөгт тавьсан байв. Тус хөмөгт жижиг модон жааз байсан бөгөөд бид уг модон эдлэлийг тугийн суурь байж болох юм хэмээн үзлээ. Уг модон эдлэл нь өндөр нь 53 см, өргөн 43 см дээд хөндлөвчийн хоёр үзүүр, мөн хоёр талын баганын дээд үзүүрийг хараар будсан байв. Хөмөгт 10 см орчим нарийн савхан модны үзүүрт гурван хэл бүхий улаан тугуудыг мөн туг бололтой савх модыг хар хөх өнгийн давуугаар боон босгож тавьсан байсан юм. Майхан уулын Шороон Бумбагарын ханын зургаас харахад дээрх жижиг модон жааз нь тугийн суурийн жижигрүүлсэн төлөөлөл байна. (Зураг 4) Тугтай холбоотойгоор өгүүлэхэд Заамарын Шороон Довоос илэрсэн даавуун эдлэлийн дотор торгон эдлэл дээр ирвэсийн зураг будгаар үйлдсэн хэсэг илэрсэн юм. Энэхүү даавуу нь ирвэсийн зураг бүхий туг байв уу гэдэг нь нэгэн хаалттай сонирхолтой асуулт болон үлдэж байна. (Зураг 5, 6, 7, 8)




Зураг 3. Заамар сум Шороон Довоос илэрсэн олдвор. А.Очир нарын нийтэлсэнээр




Зураг 4. Заамарын Шороон Дов, баруун хөмгөөс илэрч буй хар, улаан туг



Зураг 5.
Баяннуурын Шороон Бумбагар-1



Зураг 6 . Заамарын Шороон Дов,
улаан, хар тугууд



Зураг 7. Заамарын Шороон Дов,
тугийн суурь



Зураг 8. Заамарын Шороон Довоос илэрсэн торгон эдлэл дээр дүрслэсэн ирвэс



Майхан уулын Шороон Бумбагар-1 дурсгал өмнө илэрсэн Заамарын Пүгү Итү-гийн бунхантай ижил төрлийн дурсгал учир судлаачид он цагийг нь ойролцоогоор VII зууны II хагаст байх хэмээн урьдчилан үзсэн байна [2, 227]. Учир нь дотроос нь гарсан олдвор хэрэглэгдэхүүн, архитектурын онцлог зэрэг нь Заамарын Шороон Дов дурсгалтай ойролцоо дурсгал гэдгийг тодорхой илтгэж байна. Гэвч VII зууны II хагас хэмээн баримжаалах нь нилээд бүрхэг он цаг болно. Итү-гийн бичээс НТ 657-678 оны орчимд хамаарах тул энэ цаг хугацаанаас хойш уу, эсвэл өмнө үү гэдэг нь нилээд сонирхол татаж байна. Өмнөх, аль эсвэл хожуу цаг үеийн дурсгал хэмээн үзвэл мөн л тойм төдий он цаг гарахаар байгаа юм.

Шороон Дов хэмээх дурсгал нь илрээд арав гаруй жил болж байна. Тиймээс уг бичээсийн судлагдсан байдлыг бүрнээр нь илтгэх боломжгүй юм. Дурсгалыг анх илрэхэд хэвлэл мэдээллийн хурал хийж олон нийтэд танилцуулсан юм. Энэ үеэр “Уйгурын өв соёл” олон улсын эрдэм шинжилгээний хурал болж таарсан билээ. Тийм учраас бидний баг уг хурлын зочдод зориулж миний бие он цагийг нь бичээсээс уншин тогтоож урьдчилсан байдлаар ямар түүхэн үйл явдлуудтай холбогдох талаар цухас дуулгасан юм. Энэхүү хуралд зориулж Nomadic [3, 5] сонинд дээрх бунхантай булш болон булшны бичээсийн талаар товч мэдээлэл нийтлүүлсний дараа БНХАУ-ын судлаач Ян Фүсюэ (Yang Fu xue - 杨富学) утга үсгийн буюу утга үсгийн ертөнцөд танилцуулсан байдаг. Ян Фүсюэ жаахан яарсан уу эхний 17 мөр буюу бичээсийн гол хэсгийг эхний ээлжинд хэвлэн Хятад болон хятад хэлээр судалгаа хийдэг ертөнцөд анх нийтлүүлжээ. Эхний 17 мөр гол мэдээлэл нь байсан ба мөн судлаачдаас нь түрүүлж зөвшөөрөлгүй нийтэлж буй тул хожмын уршигийг тооцсон бололтой байна. Нээлтийн шинжтэй зүйл учир асар хурдтай эхний ээлжийн уншлагыг ийнхүү танилцуулжээ. Түүнчлэн Энэхүү өгүүллээ “Тан улсын үеийн Пүгү аймгийн язгууртны үе залгамжлалыг нягтлах нь” гэсэн нэртэйгээр 2012 оны эхний улиралд “Баруун хязгаар судлал” буюу 西域研究 хэмээх сэтгүүлд хэвлүүлсэн байдаг [4]. Энэхүү өгүүллэд Тан улсын ямар ч сурвалж бичигт тэмдэглэгдээгүй, Пүгү аймгийн Гэлэн Баянгийн хүү Сифү болон ач хүү Итү-гийн мэдээлэлд тулгуурлан Пүгү аймгийн есөн үеийн тэргүүнийг он дарааллын дагуу ойролцоогоор жагсаан харуулсан юм. Бүрэн эхээр нь 2010 гэхэд аль хэдийн уншчихсан байсан ч алдарт Вэн ү сэтгүүлд өгсөн нь хэвлэгдэх дугаараа хүлээж байсан бөгөөд Ян овогт шавь болох Жао Жин-гийн хамт бичсэн “Пүгү аймаг болон Тангийн харилцааг нягтлах нь” гэсэн өгүүлэл ханзны ертөнцөд хамгийн анх хэвлэгдсэн бүтээл болж байна. Энэ өгүүллийн эш татсан зохиолоос харахад Ян Фүсюэ “Тан улсын үеийн Пүгү аймгийн язгууртны үе залгамжлалыг нягтлах нь” гэсэн өгүүллээсээ эш татсан байх бөгөөд хэвлэгдэхийг нь хүлээж байгаа гэсэн байна [5].

2010 онд бидний хамтран ажилласан ОХУ-ын Алс Дорнод, Түвд судлалын хүрээлэнгийнхэн “Курган Шороон Дов и его место в общей системе археологических памятников тюркской эпохи Центральной Азии” [6, 254-257]

өгүүлэлдээ уг булшны малтлага судалгаа болон бичээсийн талаар танилцуулсан нь орос хэлээр хэвлэгдсэн анхны бүтээл болсон юм. Үүний дараагаар бидний багт ажиллаж байсан антропологич А.И.Бураев “Заамарын бунхант булшнаас илэрсэн шавар хүүхэлдэйн антропологийн хэв шинж” [76 600-607] гэсэн илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд энэхүү бунханд буй хүүхэлдэйн хийц нь Тан улсын бунхнаас илэрдэг хүүхэлдэйг бодвол илүү умард буюу монголжуу хэв төрхтэй байна. Өөрөөр хэлбэл нүүдэлчид суурин иргэдийн булшинд хүүхэлдэй дагуулах соёлыг дуурайж өөрсөдтэйгээ адил төрхтэй хүүхэлдэй хийж дагуулсан байж болох юм гэсэн санал дэвшүүлсэн байна.

2010 онд Түркийн Истанбул хотноо болсон “Ötüken'den Istanbul'a Türkiyenin 1290 Yılı (720-2010)” хэмээх хуралд Түркийн судлаач Cengiz Alyılmaz “Zanabazar Güzel Sanatlar Müzesindeki Türk Eserleri” [7, 87-109] хэмээх илтгэл хэлэлцүүлсэн байна. Тус илтгэлдээ Занабазарын музейд хадгалуулсан тус бичээсийн гэрэл зураг, бунхнаас илэрсэн олдворуудын хадгалагдаж буй байдал мөн бусад дурсгалуудыг танилцуулснаар Түркийн болон олон улсын түрэг судлаачдын сонорт уг дурсгалын тухай мэдээ хүрсэн юм.

Заамарын Шороон Довыг малтахад хоёр давхар авс бүхий бунхан байсан нь аль хэдийнээ тоногдсон байсан бөгөөд ямар нэгэн хүний ясны үлдэгдэл илрээгүй, авсан дотор бага зэрэг гал түлсэн ором болон шатсан ясны багахан хэсэг байв. Үүнээс харахад хоёроос гурван таамаг дэвшүүлж болохоор байна.

Булшийг тонох үед шарил зөөгдөж гээгдсэн.

Талийгаачийг оршоогоогүй хоосон булш байж болох.

Энэхүү бунхан үйлдэх гар урчууд ирэхэд талийгаачийг аль хэдийн тал нутгийн ёсоор хөдөөлүүлсэн байсан. Тиймээс хоосон булш үйлдсэн.

Гуравдугаар таамгийг батлах зүйл нь Баяннуур сумын Майхан уулын Шороон Бумбагар мөн тоногдоогүй хэрнээ хоосон булш мэт байдалтай байсан. Хоёр булшнаас багахан хэмжээний шатсан ясны хэм гарсныг судлаачид чандар хэмээн үзсэн байдаг. Үүнийг тодруулах шаардлагатай хэмээн үзэж Баяннуурын дурсгалыг малтан судласан судлаач доктор (Ph.D) дэд профессор Л.Эрдэнэболдод хүсэлт гаргахад шатсан ясны дээж авчирч өгсөн болно. Уг шатсан ясны дээжийг ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн судлаач Ц.Амгалантөгс уг шатсан ясны хэмийг үзэж судлаад 80% мал, амьтаны яс, 20% нь тодорхойгүй буюу ямар нэгэн хүн, амьтны ясны мэдээлэл агуулаагүй, хангалтгүй дээж байна гэсэн дүгнэлт гаргасан бол судлаач Б.Эрдэнэ хүний яс биш мал, амьтаны яс байж болох бөгөөд чөмөгний ясны хэмээс харахад жижиг биетэй буюу малаар бол бог малын хурга, ишигний яс бололтой гэсэн дүгнэлт гаргасан юм. Тиймээс уг бунхант булшны авснаас илэрсэн шатсан ясыг цаашид нарийвчилсан кримналистк шинжээчээр лавшруулан тодорхойлуулвал илүү сонирхолтой үр дүн гарч болох юм.

Шороон Довын булшны бичээс: 1-р хөшөөний бичээс буюу тагны бичээс:

大唐金
微都督
僕固府
君墓志

Их Тан улсын Жиньвэй дүдү Пүгү фү Жүн-гийн булшны бичээс

2-р хөшөөний буюу эх бичээсийн орчуулга: Нэг тулгаж харах

Их Тан улсын Баруун этгээдийн гавишгай харуулын их жанжин Жин вэй жоу-гийн дүдү, шанжү гуо, Лин жоу сянь-ий кайгуо гүн, Пүгү фү Жүн булшны бичээс хийгээд оришил

Талийгаачийн нэр Итүшо-е Алтан уулын хүмүүн. Теле-гийн тусгай аймаг болой. Угтаа Ши нью-д суурь тавигдаж, алтан өнгөт оргилууд үргэлжлэн тархай бутархай салаа мөчир [мэт аймгууд]-ийг цуглуулан [захирч] хязгаар нутаг төвлөн, баатар хэмээн өргөмжлөгдөж, өнөр өтгөн, хүчирхэг аймаг болгов. Луут хот-ыг алгасан [алслан], ихэд цэцэглэн мандсан басхүү Риди (Миди) хэмээх хүмүүн төрсөн нь ачлалд үнэнч, Хань улсын ордонд зургийг нь дээдэлж, өдрөөс өдөрт хүчээ өгөв. [Түүнд] бүдүүлгүүдийн нутгаас татвар хураах хэргийг даатгав. Түүх судраас хичнээн хайвч түүнтэй эгнэх хүмүүн буй гэж үү?

[Талийгаачийн - орч] Өвөг Гэлэн Баян, хаант төрийн [Тан улсын - орч] Зүүний зэвсэгт харуулын их жанжин, Жин вэй жоу-гийн Дүдү бөлгөө. Эцэг Си фү, Жин вэй жоу-гийн Дүдү-г залгамжилжээ. Түүнчилэн санах сэрэх нь хурц сэргэлэн. Эрт соёл [хааны ач буян]-д хандан дагаар ирж, завишааныг эрэн бараалхахыг хүсч, ганц биеэр гайхалтай итгэлт хүн болсон бус. Түшмэл-ийн хувиар үнэнхүү сүсэглэн, бишрэн дээдлэх чин санаа нь угаас өөрөө мэдээд, духаа газарт хүргэн сөгдөн мөргөмүй. Гүнтэн хар багаасаа баатарлаг гавишгай тул морь унах, харвах намнахад амархан суралцав. Нум татах нь онцгой сайн агаад хонь унах насандаа нум сайн харваж, сум эгцлэхдээ (харвахдаа-орч) онцгой авьяастай тул гарамгай харваачийн шагнал хүртэж байв. Эцгийгээ нас барсны дараа (хүү нь-орч) тус аймгийн дуду залгамжилж, аймгаа ерөнхийлөн захирав. Хуандийн эрдмийг дээдлэн дагаж, эрэгцүүлэн бодож, харцаа дотогш хандуулан, чин сэтгэлээ зориулж, чигч журмыг сахив. Санамсаргүй [байтал] Хэлу зарлигт тэрслэн самуун явж, дураар явж, хязгаар нутгийн хэрэг явдал удаан хугацаанд хаагдах болов. Үүний тул [хуанди-гийн] зарлигаар олон цэрэг илгээж, нохой хонь мэт олныг дарж чадав. Гүнтэн үүнд түрүүлэн хөдөлж, шууд даран сөнөөж, хулгайн хүрээг дайран гишгэчиж, зовлон зүдүүргүйгээр туг хиурыг нь булаах арга бодлогыг зохиож, даруй [дайсны] тугийг нь сугалав. Гавьяа зүтгэлийг нь тэмдэг нь тэмдэглэн, байлдааны гавьяаг өгүүлсэнд эзний хайрыг хүлээсэн өв тэгш түшмэлийн ёсоор хандав.

Зарлигаар ю-у вэй ланцзян (баруун этгээдийн зэвсэгт харуулын ланцзян-右武衛郎將) цол шагнав. Залгуулаад хуцзюнь (護軍) цол хүртээж, басхүү Линьчжун сян-ий зайго-цзы өргөмжлөв. Удалгүй цзо-у-вэй да цзянцзюнь (зүүн этгээдийн зэвсэгт харуулын их жанжин) цол шагнав.

Линьдэ-гийн 2-р он (665 он)-д хүрч ирээд, эзэн хааны сүйх тэргийг дагалдан Дайюе ууланд одож, умард хилийг эргэхээр явахад нь дагалдан явав. Хааныг аялан явахад нь саад гараагүй бөлгөө. Тэгээд энэхүү цусан гавьяаны хариу төлөөсөнд эзэн хааны тахилгын ёслолд биеэр оролцох хүндлэл хүлээв. Хашаар чимэглэсэн хувцас өмсөх болов. Хэргэм тушаал нь сувд амандаа зуух хэрийн эрхэм бөлгөө. Хэдийгээр зузаан хайр хишиг хүртээж, сүр хүч нь бадарч байвч, сэтгэлээ бат болгож, улам бүр хичээх ажгуу. Бас дорно зүгт Мохэ-г цохиж, өрнө зүг Төвдийг төвшигтгөхөд цөм үнэнчээр зүтгэв. Муу харгисыг даран сөнөөж, гавьяа зүтгэл ихэд илэрсэн тул урьд хождын гавьяа их болой. Залгалдаагаар баруун этгээдийн гавишгай харуулын их жанжин цол шагнав. Мөн урьдын дуду дээр нэмж, шан-чжуга хэргэм, Линьчжун сянь-ий кайго гүн (улс нээсэн гүн) цол, идэх хот нэг мянган өрхийг шагнав. Хэргэм зэргийг нь удаа дараалан нэмэн олгож, өндөр тушаалд тохоон томилсноор тэрхүү эсгий болон арьсан хувцас [өмсөгч]-ийн нутаг газраас даван гарав. Ёслолын [залаат] малгай өмсөгчдийн жагсаалд багтах болов. Гэтэл тусч, улс орон гэгээрэв. Хэдүйн эзэмшил газар (茅土)-ын ёсоор өргөмжилсөнд хурдан ирж, хаан эзэнд бараалхав. Басхүү “тоорын цэцгийн цацаг (柳花之綬)”-ийг хүртсэн нь үнэхээр өндөр албан тушаал болой.

Эрэлхэг зориг нь төмөр чулууны хатуутай зүйрлэмээр. Хэрхэн салхи хийгээд шүүдэр лүгээ адил унах дорой хөвгүүн хэмээн сэтгэх билээ. Арайхийн үг хэлээд, гэгээн өдөр харанхуй шөнө болж үүрд эгэн одов.

Ифэн-гийн 3-р (678)-оны 2-р сарын 29-ний өдөр өвчин тусч, өөрийн аймагтаа нас эцэслэв. Нас сүүдэр 44 бөлгөө.

Тэнгэрийн хөвгүүн удаан энэлэн гишүүдаж, зарлигаар чаосань дайфу шоудушоушичжэ (албан тушаалын нэр) бөгөөд Тяньшань цзюнь (Тэнгэр уулын цзюнь- цзюнь нь засаг захиргааны нэгжийн нэр)-ий кайго гүн Цю Чжао (麴昭) цзяньху (албан тушаалын нэр)-г зарж, эмгэнэл илэрхийлэн тахилга үйлдүүлж, бэлэвсрэлд өргөх эд 300 ширхэг, хэмэрлиг дээл, алтан чимэгт бүс, нум сум, саадаг, (эмээлийн) гөлөм тус тус нэгийг хайрлав. Ер түүний оршуулгын ёслолыг үйлдүүлж, зарлигаар албанаас гаргуулж хөшөө босгуулав. Даруй тэр жил буюу жилийн дарааллаар (歲次) шар барс жил (678)-оны 8-р сарын хөхөгчин тахиа сар шинэтгэл 18-ны хар барс өдөр хээтэй торгонд боож, чулуугаар дарж үүрд оршуулсан нь угийн ёс заншлын дагуу үйлдсэн нь болой.

Үхэл амьдралын зааг хол

Уйтгар гуниг, нэр алдар бүгдээр

Манан будан мэт гүн тогтжээ

Нарсан авсанд эмгэнэн боохуйяа

Намрын салхи энэлэн үлээж
Гагцхүү таана өвсний хонхонд шингэн гуниглана

Цилян уул-ын дүр тархийг дуурайн үйлдсэнд
Уйтгараа даран байж өчил өчмүй
Эрдмийг үгүүлж, гавьяаг илэрхийлж
Ийнхүү бичиг үйлдэн өгүүлсүгэй

Баруунтаа Цун уул сүндэрлэж
Хойд зүгт Пухай-д тулмуй
Нутгийн салхи үргэлж үлээвч, баатар эр энд буй
Навчсыг сумны үзүүр цоолж
Цэцэгс өнгөтэй болжээ.
Үр ач нь элбэг хангалуун байхыг эрмэлзсэнд
Өвөг дээдсээ залгамжлан, өчүүхэн ч хувиралтгүй бөлгөө.
Үсээ боож, ёсыг дагахаар ирээд
Бүсэлхийдээ саадаг зүүж, эзэн хааныг хамгаалав.

Их эрдмээ энэ мэт тархаасанд
Хүмүүс бүгд үүнийг зөвшөөрөн хүлээх бөлгөө
Чин сэтгэлээ өргөхүйеэ бүх зүйл ижилсэж
Үнэнчээр зүтгэхээс өөр санаагүй
Аюул тулгарах үед журмыг сахих тул
Үнэхээр зориг шийдэмгий билээ.
Дагасан хот тосгодыг гэгээрүүлж


Хэргэм зэрэг хүртээн, албан тушаалд
Цэргийг дагалдан туг хиураа өргөсөнд
Жанжнаар томилогдож, тавцанд гарав (түшмэдийн зэрэгт багтав)
Цог заль бадран, гэрэлтэн түгэхүйеэ
Яруу алдрыг нь бахдан харууштай яа.
Гэгээн эзнийг дээдлэх цагтай учрах үед
Нам гүм шөнөөр гэнэт нас барав. (Аглаг буйд булшны нүх рүүгээ гэнэт
буцан одов.)

Эрэлхэг зориг нь хааш одов?
Эгэлгүй сайхан төрхийг нь бултаар санамуй.
Тогоруун толгодод агишин зуур оршуулсанд
Жи тянь-ны газраас эхлэн ул мөр үгүй [Г.Б.]
Сар шингэхүй гэрэл гэгээгүй болж
Үүл гарахуйяа аяндаа харанхуй болов.
Шувууд гуниглах нь хээрийн галуунаас илүү цуурайтаж
Хязгаарын хүмүүсээс Ян Мэн боомт [Г.Б.] хүртэлх иргэд энэлэн шаналмуй.


Удам угсаа нь өнөр олон, төв шударга байж, үл сөнөхийн (тасрахын орч.) тул

Хар чулуунд тэмдэглэн, үүрд хадгалуулав [1, 100-102].

Бичээсийн хэв маяг, булшны эзний түүх зэргээс харахад Пүгү аймгийн тэргүүн Итү-гийн хойдохын ажлыг Тан улсын төрөөс ихэд чухалчлан анхаарсан нь харагдаж байна. Булшны бичээсийн бичлэгийн арга, хийц, дэг зэргээс харахад Тан улсын хааны ордны дэргэдэх хойдохын ажлын албанд хийсэн зүйл гэдэг нь төвөггүй мэдэгдэнэ. Бичээсийн Хятад эхийг хавсралтаас үзнэ үү.



Заамарын 1-р бичээс буюу
таг бичээс



Заамарын 2-р бичээс
буюу эх бичээс

Мартагдсан Пүгү аймаг. Манай Түрэг, Уйгур судлал өнгөрсөн зуунаас өнөөг хүртэл тасралтгүй үргэлжилсээр байгаа билээ. Түрэг, Уйгурын хант улсын угсаатны бүрдэл болж явсан Теле-д холбогдох Заамарын бунханта булшийг малтан судлах хүртэл Теле-гийн түүх археологийн биет баримтгүй өдий хүрсэн билээ. Ялангуяа НТ 645-682 оны төрийн түүхийн талаарх зарим нэг өгүүллийг эс тооцвол энэ үе манай улсын судалгааны хүрээнд орхигдоод байсан хэмээн үзэж болно. Энэ үеийн түүх нь Монголын түүхийн нилээд эдрээтэй үе бөгөөд түрэг, монгол угсааны олон овог аймаг хоорондоо ширүүн өрсөлдөөнтэй бие биеэ халж төр улсаа байгуулж байсан бөгөөд тийм улс төрийн тэмцлээс болж хүч мөхөсдсөн бүлэг нь өмнөд хөршийн төр Тан улсыг түшиж байжээ. Энэ түүхэн үйл явдалын талаар ахмад түүхч А.Амар өөрийн бүтээлдээ тусгасан байдаг [9, 57-59]. Судлаач Б.Батсүрэн судалгааны материал болон сурвалжид тулгуурлан Түрэг, Теле-гийн түүхэн үүрэг, Тан улсаас нүүдэлчдийн эсрэг явуулж байсан бодлого зэргийн талаар судлаачдын үзлийг тоймлон өөрийн саналыг тусгасан байна [10, 33-43]. Заамарын Шороон Дов хэмээх дурсгалыг малтан судалснаар дундад эртний улс төрийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж байсан Теле аймгуудын бүрэлдэхүүнд явсан Пүгү хэмээх аймгийн тухай 774 утга үсэг бүхий түүхийн шинэ бичгийн

сурвалж илэрсэн юм. Өмнөх судалгааны бүтээлүүд болон Теле-гийн түүхэнд уг бунхны эзэн болох Итү-гийн үйл хэрэг бүрхэг байсныг өмнө дурдсан бөгөөд Түрэг, Уйгурын түүхэнд Пүгү хэмээх аймгийн талаарх мэдээлэл хомс, ямар шалтгаанаас нь тодорхойгүй мартагдан хоцорсон байна. Дундад эртний түүхийн судалгаанд нэр нь дурдагдах төдий тэмдэглэгдэн орж байсан Пүгү аймаг нь Монголын түүхийн тавцнаа Жужаны хаант улс, Түрэгийн хаант улс, Сеяньто-гийн хаант улс, хожуу Түрэгийн хаант улс, Уйгурын хаант улсын түүхэнд ихээхэн үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд улс төрийн тодорхойгүй шалтгаанаар хятад хэлээрх түүхийн сурвалжаас зарим мэдээ баримт нь арилсан баларсан байна. Өөрөөр хэлбэл, бидний нягтлан буй Заамарын бичээст өгүүлж буй Пүгү аймгийн тэргүүн, НТ 635-678 оны хооронд амьдарч байсан Итү-гийн талаарх мэдээ сэлтийг Тан улсын сурвалжид тэмдэглээгүй байна. Зарим нэг улс төрийн зүтгэлтний түүхэн мэдээ дарагдан үгүй болсон ч Пүгү хэмээх аймгийнхаа нэрээр цухас түүхэн үйл явдалд оролцож байснаас нь сэргээн харах боломжтой байгаа юм.

Теле-гийн бүрэлдэхүүн дэх Пүгү аймгийн талаарх мэдээ Хятадын “Бэй Ши”-гийн 99-р бүлэг Теле-гийн хэсэг (《北史》卷99《铁勒传》) -т:

铁勒之先，匈奴之苗裔也，种类最多，自西海之东，依山据谷往往不绝。独洛河北，有仆骨、同罗、韦纥、拔也古、覆罗，并号俟斤，蒙陈、吐如纥、斯结、浑、斛薛等诸姓，胜兵可二万……虽姓氏各别，总谓为铁勒。并无君长，分属东、西两突厥，居无恒所，随水草流移。人性凶忍，善于骑射，贪婪尤甚，以抄掠为生，近西边者，颇为艺植，多牛而少马。自突厥有国，东西征讨，皆资其用，以制北荒……其俗大抵与突厥同。

Теле-гийн уг эх Хүннүгийн хойчис. Төрөл аймаг олон. Өрнөд тэнгисээс дорнод, уул хөндий түшиж нааш цааш явах нь тасралтгүй. Туул голын ард Пүгү (Pugu), Тонгра (Tong lu), Уйгур (Wei he), Баегү (Ba ye gu), Фүлюо (Fu luo) иркин цол [зүүдэг]. Мэнчэнь (Meng chen), Түрүгэ (Tu ru ge), Сыже (Si jie), Хунь (Hun), Хусюэ (Hu xue) зэрэг бусад овог [аймаг бий]. Шилдэг цэрэг хоёр түм гаруй... Овог төрөл бүгд өөр [боловч] ерөнхийд нь Теле [гэнэ]. [Бүгдийг хамарсан] тэргүүнгүй, зүүн, баруун хоёр Түрэгийн хооронд тогтсон газаргүй, өвс ус дагаж нүүж амьдардаг. Хүн ард нь эрэмгий зоригтой, морь унаж нумаар харвахад гавишгай, ховдог шунахай гэж онцгой, ойролцоох баруун хязгаарынхныг булаан дээрэмдэж амьдардаг... үхэр ихтэй, адуу цөөн. Түрэг улсын харьяат [буюу тэднийг] зүүн баруун луу аян дайнд ашигладаг... Ёс заншил нь ихэнх нь Түрэгтэй адил.

Энэхүү мэдээнд Теле-гийн Пүгү аймаг хамгийн эхэнд бичигдсэн байгаа нь анхаарал татаж буй бөгөөд тухайн үед хүчирхэг, бусад дундаа нэртэй байснаас нь эхлэн бичсэн болов уу хэмээн таамаглаж байна. Мөн энэ нь тэдний зан суртахуун, аж ахуйн онцлог, ёс заншлын талаар дурдсан үнэ цэнэтэй мэдээлэл юм. Пүгү аймаг, ер нь Теле аймгуудыг ховдог шунахай, урваж шарвахыг юман чинээ боддоггүй, мориор бол сургаж болдоггүй эмнэг шиг хэмэ-

эн зүйрлэсэн байдаг [11]. Зөвхөн Пүгү аймгийн түүхэн үйл явдлаас харахад улс төрийн хувьд тогтворгүй, аймаг дотроо хуваагдан нааш цааш нүүж буй үйл явдал зэрэг нь тэдний язгууртнуудыг улс төрийн хувьд тогтворгүй, ховдог шунхайг гэж тодорхойлоход хүргэсэн болов уу хэмээн үзэж байна.

НТ 604 онд Түрэгийн хаант улс үймж теле аймгууд дүрвэн Сүй улсыг түшсэн талаар Хятадын Сүй улсын түүхэнд тэмдэглэсэн хэсэгт:

(隋仁寿)三年, 有铁勒思结、伏利具、浑、斛萨、阿拔、仆骨等十余部, 尽背达头, 请来降附, 达头众大溃, 西奔吐谷浑, 晟送染干, 安置于磧口, 事毕归朝。

Сүй улсын Рэнь шоу-гийн 3-р (НТ 604) онд Теле-гийн Сыже (Si jie), Фү-лижү (Fu li ju), Хунь (Hun), Хуса (hu sa), Аба (A ba), Пүгү (Pu gu) зэрэг арав гаруй аймгийн тэргүүн Датоу-гаас дүрвэж, [Сүй улс] төрд найр тавин орсон. Датоу-гийн иргэдийг Дакүй (Da kui), баруун талаар Түгүхунь-тай (Tu gu hun) хиллүүлж Чикоу (qi kou – 磧口) ¹-д суулгав.

Энэхүү мэдээнд Пүгү аймаг зургаад бичигдсэн байх бөгөөд хожмын Хуйхэ, Тонгра зэрэг хүчирхэг теле аймгуудын нэр огт дурдагдаагүй, тоог нь нийт арав гаран хэмээгээд орхисон байна. Магадгүй энэ үймээнээр Хуйхэ, Тонгра аймгууд зүүн Түрэгт зүтгээд үлдсэн, дагаар ороогүй учир нэр нь тэмдэглэгдээгүй байж болох юм. Гэвч энэ мэдээнд Пүгү аймаг арав гаруй аймгаас нэр нь тэмдэглэгдсэн зургаан аймгийн зургаад тэмдэглэгдсэн байгааг ажиглаж болно. Хятад түүхэн сурвалжид аливаа аймаг улсыг тэмдэглэхдээ заавал баримталдаг дэг жаяг байгаагүй байж болох ч өөрсөддөө чухал гэж үзсэн ямар нэгэн онцлогоор нь жагсаан бичдэг байсан хэмээн үзэж байна. Энэхүү таамгийг нотлохуйц мэдээ Хуучин Тан улсын түүх хэмээх сурвалжид байна.

Хуучин Тан улсын сударт, Теле аймгуудыг тэмдэглэсэн хэсэгт 旧唐书卷二百一十二列传第一百四十九 《北狄》-д

“铁勒, 本匈奴别种。自突厥强盛, 铁勒诸郡分散, 众渐寡弱。至武德初, 有薛延陀、契苾、回纥、都播、骨利干、多览葛、仆骨、拔野古、同罗、浑部、思结、斛薛、奚结、阿跌、白 等, 散在磧北。”

“Теле-гийн уг нь Хүннүгийн нөгөө төрөл, түрэгүүд хүчирхэгжин гарч ирснээр Теле-гийн аймгууд таран бутарч ард олон сульдан доройтов. Үдэ-гийн эхээр (НТ 618) Сеяньто, Циби, Хуйхэ, Дүбо, Гүлигань, Доланьгэ, Пүгү, Баегү, Тонгра, Хуньбү, Сыже, Хүсе, Сиже, Аде, Байси говийн араар тархан суудаг.”

Теле-гийн талаарх тус мэдээнд бидний сурвалжлан буй Пүгү аймаг долоо-дугаарт тэмдэглэгдсэн байгааг ажиглаж болохоор байна. Энэ нь мэдээж Зүүн Түрэгийн хаант улс бутран унасан үе буюу НТ 630-аад оноос хойших мэдээ юм. Энд хамгийн эхэнд Сеяньто-г тэмдэглэсэн байгаа зэргээс харахад Сеяньто-гийн хаант улс байгуулагдсанаас хойш юм уу, ямар ч байсан Сеяньто-гийн ноёрхлын үед нь тэмдэглэсэн мэдээ гэдэг нь харагдаж байна. Тиймээс Хятадын түүх бичлэгт аймаг улсуудыг жагсаан тэмдэглэхдээ ямар нэгэн улс төр, үзэл суртлаар бус, нөлөө бүхий хүчирхэг аймгаас нь уруудуулан бичдэг байж

болох зүй тогтол ажиглагдаж байна. Он цагийн хувьд адилгүй дээрх гурван мэдээнээс харахад анхандаа Пүгү аймаг Теле-гийн бүлэгт нилээд хүчирхэг нь байсан байж болохоор байгаа бөгөөд НТ 604 онд Сүй улсыг түшин ирсэн аймгуудын дунд 6-рт жагссан нь магадгүй дагаж ирсэн иргэдийн олон цөөнөөр жагсаасан байж болохоор зүй тогтол ч харагдаж байгаа юм.

Сүй улсын түүхийн Теле-гийн тэмдэглэлд:

”Туул голын орчмын теле аймгуудын талаар тэмдэглэсэн хэсэгт “*Туулын хойд талд Пүгү, Тонгра, Уйгур (wei he) зэрэг аймгууд 20000 цэрэгтэй*” хэмээн тэмдэглэсэн байна. Тиймээс Сүй улсын үед Теле нар нийлээд л хорь гаруй мянган цэрэгтэй байсныг харж болох бөгөөд бидний сурвалжлан буй Пүгү аймаг эхэнд бичигдсэн байна. Тиймээс эхэн үедээ тэд бусад теле нараа тэргүүлдэг байжээ хэмээн үзэж болохоор байна.

НТ 630 онд Зүүн Түрэгийн хаант улс мөхөж Тан улсын эрхшээлд ороход түрэг болон теле аймгууд байлцсан бөгөөд энэхүү дагасан аймгуудын мэдээнд Пүгү аймаг 122 өрх 673 хүн ам тоолуулсан байдаг. Хүн амын тухай энэ мэдээнд тулгуурлаад БНХАУ-ын судлаач энэ үед Пүгү аймаг хүчний хувьд өчүүхэн байжээ хэмээн дүгнэсэн байдаг [12]. Гэвч бидний үзэж буйгаар Зүүн Түрэгийн хаант улс мөхсөний дараа Пүгү, Тонгра, Хуйхэ зэрэг Теле-гийн аймгууд Сеяньто-гийн Инань-ийг хаан ширээнд залсан байдаг. Тиймээс энэ үед Пүгү аймаг хоёр хуваагдсан байсан нь илт бөгөөд 122 өрх, 673 хүн ам гэдэг нь тэр үеийн Пүгү аймгийн дотоод зохион байгуулалтыг сэргээн харж болохуйц мэдээ хэмээн үзэж байна. Учир нь тухайн үед Пүгү-д Сэбиг элтэбир (eltäbir) Гэлэнбаян, Уйгурт элтэбир Түмидү зэрэг теле аймгийн тэргүүнүүд байсан нь харагдах боловч эдгээрийн удирдлага доор 100 гаруй өрх бүхий хүрээтэй төстэй байж болох аймгийн дотоод нэгжүүдийг толгойлдог язгууртнууд байсан бололтой. Тиймээс Тан улсад дагаар орсон Пүгү аймгийн 122 өрх, 673 хүн ам гэдэг нь харьцангуй цөөн хүн ам байгаа юм. Энэ үеийн түүхэнд говийн өмнө болон говийн ард өрнөж буй үйл явдалд хоёуланд нь Пүгү аймаг гарч буй учир мөн үед эл аймаг хуваагдсан бөгөөд дээрх хүн ам, өрхийн тоо нь нэгэн язгууртнаар толгойлуулан нүүж ирсэн нэгэн хүрээнийх л болов уу хэмээн үзэж байна.

Үүнээс хойших түүхэн үйл явдалд Пүгү аймаг хуваагдсан хэвээр байсныг нотлох нэгэн баримт нь Сеяньто-гийн хаант улс мөхсөнөөс хойш говийн арыг 24 жоу, говийн өмнөдийг 24 жоу болгон засаг захиргааны тойргийн зохион байгуулалтад оруулахад хоёуланд нь Пүгү аймаг байсан нь үүнийг нотолж буй юм. Говийн арыг Янрань дүдү буюу Доланьгэ аймагт мэдүүлсэн бол говийн урд талыг Ханьхай дүдү буюу Хуйхэ аймагт захируулсан байдаг. Үүнтэй холбоотойгоор анхаарахгүй орхиж болохгүй нэгэн асуудал нь говийн арын фү, жоу-г Доланьгэ аймагт ерөнхийлөн хамруулж буй нь үнэхээр гайхалтай. Учир нь теле аймгуудын дунд тийм ч хүчтэй бус Доланьгэ аймагт говийн арыг мэдүүлж буй нь Тан улсын нүүдэлчдийг нүүдэлчдээр нь харгалзуулах нарийн аргын илрэл гэж үзэж болно. Мөн нөгөөтээгүүр Теле-гийн

дунд онцгойрдог Хуйхэ, Пүгү, Тонгра зэрэгт говийн арыг мэдүүлбэл маш хурдтай тусгаарлах талтай байсан учир болгоомжлон хүч багатай аймгаар бусад аймгуудыг харгалзуулдаг байжээ.

Энэ үеийн түүхэн мэдээнд Пүгү аймаг хоёр тал руу маш хурдтай шилжиж буй нь анхандаа нэг байсан Пүгү аймгийнхан хоёр хуваагдаж Тан болон Түрэг, хожим Уйгурт аль алинд нь нэгэн зэрэг үйлчилж байсан гэж хэлж болохоор байна. Учир нь Баяннуурын Шороон Бумбагар булш бидний үе хүртэл хадгалагдан ирсэн бөгөөд булш үйлдсэнээс хойш хэн нэгэн тонох гэж оролдоод цооногтоо дарагдсан шинжтэй (бас хүнээр тахил өргөсөн ч байж болох юм). Хожим зуугаад жилийн дараа Итү-д зориулан Заамарын Шороон Довд мөнгөн аягаар тахил өргөсөн зэргээс харахад энэ бүс нутгаа орхилгүй бусдын тугийн дор үр хойч нь байж л байсан гэх дүр зураг харагдаж байгаа юм.

НТ 645 онд Сеяньто-гийн Инань хаан нас эцэслэж ерөнхийдөө Теле-гийн аймгууд Тан улсад шурган орсон байдаг. Энэ үед теле аймгуудыг 6 фү, 7 жоу болгосон байдаг. Үүнд, Хуйхэ (Уйгур) аймгийн тэргүүн Күл Элтэбир Түмидү (回纥胡禄侯利发吐迷度) Ханьхай дүдү фү (瀚海都督府), Пүгү аймгийн тэргүүн Сэбиг Элтэбир Гэлэнбаян (仆骨婆匐侯利发歌滥拔延) Жиньвэй дүдү фү (金微都督府), Доланьгэ аймгийн тэргүүн Мо чижин (多滥葛末侯斤) Янрань дүдү фү (燕然都督府), Баегү аймгийн тэргүүн Чур Их Элтэбир (拔野古屈利大侯利发) Юйлинь дүдү фү (幽陵都督府), Тонгра аймгийн тэргүүн Их Элтэбир Шижян чур (同罗大侯利发时健啜) Гүйлинь дүдү фү (龟林都督府), Сыже аймагт Лүшань дүдү фү (卢山都督府) гэх зэргээр зургаан дүдү фү болсон бол Хунь (浑) аймаг Гаолань жоу (皋兰州), Жеши (解薛) аймаг Гаочүэ жоу (高阙州), Сиже (奚结) аймаг Жилү жоу (鸡鹿州), Аде (阿跌) аймаг Житянь жоу (鸡田州), Чишүнь (契苾) аймаг Үйши жоу (榆溪州), Сыжебе (思结别) аймаг Дайлин жоу (蹄林州), Байси (白霫) аймаг Жи Янь жоу (真颜州) гэх мэт тойргийн зохион байгуулалтад тус тус орсон байдаг. Эдгээр 6 фү, 7 жоу-г Ханьхай фү буюу Уйгурт ерөнхийлөн хамруулсан гэдэг. Зарим сурвалжид Янрань фү буюу Доланьгэ аймагт мэдүүлсэн хэмээх зөрөөтэй мэдээ байдаг. Теле аймгуудын бослого хөдөлгөөн зэрэг түүхэн үйл явдлаас харж байхад эхэндээ Янрань фү буюу Доланьгэ аймаг ерөнхийлөн хамаарч байгаад хэсэг хугацааны дараа Хуйхэ-д шилжсэн байдаг [13, 43-44]. Ийнхүү Пүгү аймаг Жиньвэй дүдү фү хэмээх нэртэйгээр Тан улсын умардын нэгэн тойрог болж аймгийн тэргүүн Гэлэнбаянгаар тэргүүлүүлэн нутагтаа өөртөө засах аймаг болсон түүхтэй.

НТ 659 онд Пүгү, Тонгра, Баегү, Сыже зэрэг дөрвөн аймаг Тан улсын эсрэг бослого дэгдээсэн бөгөөд үүнийг дагаад өнөөгийн Монгол улсын нутагт байсан Теле-гийн аймгууд татагдан оролцсоноор нилээд газар авсан байдаг. НТ 660 онд Тан улсын зүгээс Зүүний харуулын их жанжин Жэнь Рэнтай (左卫大将军郑仁泰)-гаар тэргүүлүүлсэн цэргийг дээрх дөрвөн аймаг руу илгээж гурван удаа их тулаан хийж ялсан боловч аймгийн тэргүүн нарыг барьж

чадаагүй байдаг [14]. Энэхүү бослого хөдөлгөөнийг Тан улсыг түшсэнээс хойших нилээд газар авсан томоохон бослого хэмээн тэмдэглэснийг харахад багахан бослого байнга гардаг байсныг илтгэж буй юм. Энэхүү үйл явдал Итү Пүгү аймгийн тэргүүн болсны хоёр дахь жилд болсон нь зарим нэгэн бүрхэгдүүлсэн асуултын хариулт болж байна. Уг бослого хөдөлгөөн хэдий ялагдлаар дууссан ч түүнээс хойш тасралтгүй хөдөлгөөн өрнөж байсан талаар сурвалжууд тэмдэглэсэн байдаг. НТ 661 онд бослого ахин идэвхижиж Хуйхэ аймгийн тэргүүн Бисүдү (bi su du - 比粟毒) татагдан оролцож Пүгү аймагтай хамтрах болжээ. Бослогод Пүгү аймгийн Итү голлох үүрэгтэй оролцож байсан байна. Зүүний харуулын их жанжин Жэнь Рэнтай Теле-гийн цэргийн яамнаас Янрань-ий дүхү буюу Доланьгэ аймгийн Лю Шэнли-гээр (燕然都护刘审礼) ахлуулсан теле цэрэг, Зүүний тулааны хамгаалах жанжин Сюэ Рэнгүй, Зүүний жанжин Сүн Рэнши зэрэг жанждыг илгээсэн байдаг. Энэ бослогод Доланьгэ аймаг татагдан оролцсон нь Тан улсын төрөөс явуулсан, нүүдэлчдийг нүүдэлчдээр нь даруулах гол бодлогын нэг хэрэгжилт гэж хэлж болно. Хятадын судлаач Сюэ Зүнжэн (Xue Zong zheng - 薛宗正), бослого хөдөлгөөнд дөрвөн алдартай жанжин илгээсэн нь энэ үеийн бослого хөдөлгөөн маш хурцадсан байсныг харуулж байна гэж тэмдэглэжээ [15]. Энэ үеэр Хуйхэ-гийн тэргүүн Порун, Бисүдү нар Пүгү болон Тонгра-гийн цэргийг аван Тан улсын умард хил хязгаар руу халдаж байсан бөгөөд энэ удаагийн довтолгооныг няцаасан ч ялалт байгуулж чадаагүй байдаг. Тан улсын Жэн Рэнтай-гийн цэрэг Теле нарыг нэхэн хөөсөн тухай дэд жанжин Ян Жи (yang zhi - 杨志) “хулгай нар аглаг зэлүүд талд ойрхон оромжтой, Жэнь Рэнтай жанжны арван дөрвөн мянган цэрэг хуяг дуулганд баглагдсан тул, зам хөөхөд хүндрэлтэй. Теле нар өндөр даваа, сүрлэг уулс, ус мөрөн гатлан ор сураггүй алга болсон. Тариа хүнс хомсдож нэхэж буй цэрэг нэгтгэл, хамгаалагч нар өлсөж үхэн их цас, хүйтнийг давахын тулд жад дуулгаа хаяж морьдоо алж хүнсэнд хэрэглэн цэрэг сарнин бутарч хүний махаар хооллох шахан байж найман зуун хүн үлдэв” [16] хэмээжээ. Үүнээс харахад хятад цэрэг ухарсан Теле-гийн цэргийг нэхэн хөөж говиос арагш гарч сүйрсэн талаар өгүүлсэн бөгөөд нүүдэлчдийн хөдөлгөөнт цэрэг хүч давамгай дайсантайгаа тулалгүй тэднийг дагуулж нутгийн гүнд авчран сарниулах тактик хэрэглэдэг байсан нь харагдаж байна.

Хожуу Түрэгийн хаант улс байгуулагдахын өмнө буюу Итү-гийн тэргүүллийн төгсгөл үед түүний залгамжлагч Имин (678-686) эцгийн үйлийг үргэлжлүүлэн Тан улсын бодлогыг эсэргүүцэх хөдөлгөөн явуулсаар байсан юм. Энэ үед говийн урд талд Түрэгийн Элтэриш Кутлуг (682 онд) Түрэгийн хаант улсыг ахин байгуулсан байдаг. Энэ их үймээнээр Хуйхэ буюу Уйгур аймаг Тан улсыг түшиж Пүгү, Тонгра аймаг Түрэгийг түшсэн хэмээн хятад хэлээрх сурвалж заадаг. Энэ үеийн түүхийг хятад хэлээрх сурвалж тайлбарлахдаа говийн ард их ган болж арга буюу Хуйхэ аймаг тэргүүтэй теле нар Тан

улс руу дүрвэж Пүгү тэргүүтэй Теле нар хожуу Түрэгийн хаант улсыг түшсэн хэмээн маш тойм төдий дүрсэлсэн байдаг. Энэ үеийн түүхэн үйл явдлыг дагалдан гарсан нэгэн түүхэн үйл явдал нь Тан улстай нийлж Пүгү аймгийн бослогыг даралцаж байсан Долангэ аймгаас урьдын өшийг авч ихээр хядсан байдаг. Үүнийг дүрслэхдээ Жиньвэй-гээс явахад мал сүрэг эзгүйрч хөндлөн явах хүнгүй, дуудах нэргүй болсон байлаа. Дээрх ган гачгийг гурван жил үргэлжилсэн гэх бөгөөд эргэн тойрон улаан газар, өвс усгүй болж хонь, үхэр үхсэн. Тоольё гэвэл үлийн оготно гэжээ [17]. Гэвч Түрэг Теле-гийн холбоо удалгүй сарнисан бөгөөд магадгүй тал нутгийг цаашид хэн нь захирах тухайд эрх мэдлийн тэмцэл тэдний хооронд өрнөсөн байж болох юм. Энэхүү өрсөлдөөнийг ашиглан Теле-гийн аймгуудад Тан улсын зүгээс дэмжлэг үзүүлэхээ мэдэгдэж элч илгээн харилцаж байсан бололтой. Тан улсын хувьд Түрэгийн тусгаар тогтнол болон Түрэг, Теле-гийн хамтарсан эвсэл мэдээж ашиггүй байсан нь тодорхой юм. Мөн энэ хүчний эсрэг их багаар байнга цэрэглэж байсан байх бөгөөд Тан улсыг түшсэн нүүдэлчид болох Түрэг, Теле, Сеяньто-гийн аймгуудыг урвахаас сэргийлж байсан байдаг. Уйгур аймгийн цэрэгтэй Пүгү, Тонгра аймаг нэгдэн Түрэгийн эсрэг хөдөлсөн бөгөөд уг дайнд Теле аймгууд ялагдан бүгд урагш Тан улс руу шурган орсон байдаг. Энэ үед Пүгү аймгийг Илэгэ (yī le gē - 曳勒歌) тэргүүлж байжээ. Энэ үеийн түүхийг Билгэ хааны хөшөөний зүүн талын 38-р мөрөнд “*Теле нар ард иргэдээ аван Табгачийг дагав*” хэмээн энэ үйл явдалд халаглан бичсэн байдаг. Түрэгийн хаант улс байгуулагдах үеийн хятад хэлээрх сурвалжийн цухас мэдээ ийм боловч Түрэг хэлээрх сурвалж болох Тоньюкукийн бичээсээс харахад Тонгра аймаг анхнаасаа Түрэг Пүгүтэй эвсээгүй байсан мэт мэдээ байдаг. Тоньюкукийн бичээсийн 8-р мөрөнд “*(Миний сонссоноор) [тэр хаан] Табгач руу Кунь сэнгүнийг илгээв. Кидан руу Тонгра Сэмийг илгээв.*” гэж гарч буй нь Тонгра аймаг эхэндээ Пүгү аймгийг дагалгүй Уйгурын хамт Пүгү болон Түрэгийг эсэргүүцэж байсан гэлтэй байна.

НТ 716 онд Тан улсыг түшсэн Хуйхэ, Тонгра, Хүн, Байегу, Пүгү хэмээх таван аймгийн цэргийг нэгтгэн “Тэнгэрийн цэрэг” нэртэй томоохон нэгтгэл болгосон байдаг. Тайван цагт заасан нутагтаа сууж байхаар зохион байгуулалтад орсон байна. Тан улсаас умардын таван аймгийн цэргийг хөдөлгөж умар зүгт Түрэг, зүүн тийш Хятан, баруун тийш Басмылыг дайлахаар гурван замаар цэрэг хөдөлгөсөн боловч умард замын цэрэг ялагдаж бүтэлгүйтсэн байдаг. Говийн ард гарсан нүүдэлчдийн армид Тан улсын цэрэг ирж нийлэлгүй буцсан байдаг. Дайны ажиллагаа бүтэлгүйтэж нүүдэлчдийн армийг зүгээр л золионд гаргасанд умардаас хамгаалах алба Хуйхэ тэргүүт таван аймгийн эсэргүүцэлтэй тулгарсан. Энэ үед Ганьсу, Хөх нуурын орчмын нутагт умард талаараа Түрэгийн хавчлага, өмнөд талаараа Төвдийн халдлагад байнга өртсөөр Телегийн ард түмэн туйлдаж Тан улсын умардын хэрэг эрхлэх Ван Жүнь хуань (wáng jūn huān - 王君煥) жанжныг хороож теле нар дийлэнх нь Түрэгийн хаант улсыг түшсэн [18, 60-61] байдаг. Энэ үед Пүгү аймгийг

Шаомо (shao mo - 勺磨) тэргүүлж байсан бөгөөд тал нутагт Түрэгийн хаант улс мөхөх хүртэл говийн хойноо үлдсэн байдаг.

Хожуу Түрэгийн хаант улсын сүүл үед Түрэгийн Ашинагийн язгууртнуудын хооронд хаан ширээний төлөө тэмцэл өрнөж байх үед Пүгү аймгийн тэргүүн Или Чур Бэг (yì lì chūo bó - 乙李啜拔) байжээ. Пүгү тэргүүт теле аймаг Түрэгийн Ирань хааны хүү Тэнгри хааны талыг дэмжин баруун гарынхантай тэмцэж байсан байна. Кутлуг Пофү (Сэбиг) хатан, Ирань хааны бага хатан, Тэнгри хааны гүнж нар баруун гарынханд дийлдэж өмнөд газар руу шахагдан дүрвэцгээсэн байна. 744 онд Озмыш хаан Ашинагийн язгууртнуудыг хүйс тэмтэрч эрхийг авсан ч Уйгур, Карлукийн холбоо Ашина Шир-ийг довтолж Бэйтинг эзэлжээ. Ингээд Уйгурын тэргүүн өөрийгөө Күлүг Пэйло хаанд өргөмжлөөд Түрэгийн сүүлчийн хаан болох Цагаан Хөмсөгт хааныг устгаж Түрэгийн хуучин газар нутгийг хамарсан Уйгурын хаант улс байгуулсан байна. Хожуу Түрэгийн хаант улсад хүчээ өгч байсан Пүгү аймаг Уйгурын хаант улс байгуулагдахад тал нутагт үлдээгүй нь нилээд сонирхолтой асуудал юм.

НТ 756 онд Ань Лүшань-ий бослого хэмээх томоохон хөдөлгөөн Тан улсад өрнөсөнтэйгээр холбоотойгоор Пүгү аймгийн тэргүүн Пүгү Хуайэнь Уйгур улсад ирж цэргийн тусламж авсан байдаг. Худ ураг бололцон хоёр охиноо хатан болгон өгсөн нь Тан улсын түүхэнд *Гэрэлт Энхийн Хатан* (光亲可敦 - Guang qing Ke dun) хэмээх цолыг хүртжээ [19]. Тан улсын түүхэнд Пүгү аймгийн Пүгү Хуайэнь-ий угсааны гурван охин Уйгурын хатан сэнтийд зарларч байсан ажээ. Пүгү-гийн гурван охин дараалан Уйгурын Яглахар овгийн хатан сэнтийд суусан нь алтан ургийнхны байр солигдох нэгэн шалтгаан болсон хэмээн үзэж болно. Уйгурын хаант улсын язгуурын Яглахар, Аде овгийн суурийг үргэлжлүүлэн эзэлснээр Пүгү аймаг нь Уйгурын гурав дахь их язгуурын аймаг болсон юм. Уйгурын хаант улс мөхөхөд Уйгурын зон олны нүүсэн хэсэг нь хоёр томоохон хуваагдсаны нэг нь Тан улсыг түшсэн бол нөгөө бүлэг нь Пүгү аймгийн тэргүүн Пүгү Жүн (Huihu Pugu Jun - 回鹘仆固俊)-ийг даган Бэйтинг түшиглэн Турфаны хөндийд Гаочангийн Уйгурын хаант улсыг НТ 866 онд байгуулсан юм. Энэ нь Пүгү аймгийн Пүгү Хуайэнь-ий хойч буюу хожим Чингис хаанд дагаар орсон уйгуруудын өвөг билээ.

Монгол улсын Төв аймгийн Заамар сумаас илэрсэн Шороон Дов хэмээх дурсгалаас илэрсэн бичгийн сурвалжууд, археологийн малтлагаас илэрсэн зарим олдворуудад тулгуурлан бичлээ. Уг дурсгалыг малтан судалснаар Монголын дундад эртний түүхийг шинэ хэрэглэгдэхүүнээр нэхэн харах бололцоог олгосон юм. Уг дурсгалаас дэлхийн хаана ч, ямар ч түүхэнд тэмдэглэгдээгүй, түрэг болон хятад хэл бичгээрх сурвалж илэрсэн нь хятад хэлээр буй түүхэн мэдээнүүдэд томоохон үнэлэлт дүгнэлт өгөхүйц эх хэрэглэгдэхүүн болж өгсөн юм. Тухайлбал Зүүн Түрэгийн хаант улс мөхөж Хожуу Түрэгийн хаант улс ахин байгуулагдсан үе буюу НТ 630-680 оны хооронд өнөөгийн Монгол нутагт болж өрнөсөн түүхэн үйл явдлуудыг нүүдэлчдийн өөрсдийх нь баримтаар, тэдний өнцгөөс харах бололцоо олгосон юм.

Манай түүхийн судалгаанд түүхэн энэ үеийн телегийн Пүгү хэмээх аймаг мартагдан хоцорсон байна. Пүгү аймаг тухайн түүхэн үйл явц, нүүдэлчдийн улс төрд идэвхтэй оролцож дундад эрт үеийн улс төрийн тавцанд зарим үед тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байсныг тодруулсан юм. Энэ аймаг нь Хожуу Түрэгийн хаант улстай нилээд ойр харилцаатай байсан бөгөөд худ худгайн холбоотон байсан байж болохуйц баримтууд тодорч байна. Мөн Уйгурын хаант улс байгуулагдахад урьдын харилцаагаа сэргээж худ ураг барилдаж байжээ. Дундад эртний нүүдэлчдийн улс төрд тэргүүлэх байр сууринд байсан аймагтай худ ураг бололцон хүчээ нийлүүлж байгаагаас харахад тухайн нүүдэлчдийн төрийг тэргүүлж буй алтан ургийнхан ч хүчирхэг аймагтай ураглах, давхар ураглах эрмэлзэл их байсан бололтой. Энэ нь ч нүүдэлчдийн улс төрийн томоохон хөдөлгөх хүч, нөөц болдог байсан биз.

Уг дурсгал илрэхээс өмнө судалгааны бүтээлүүдэд Түрэг, Уйгурын түүхэнд Пүгү хэмээх аймаг тийм ч хүчирхэг аймаг бус телегийн есөн аймаг дунд нэр нь дурдагдах төдий явсаар өдий хүрсэн байдаг. Мөн энэ үеийн түүхэн газарзүйн баримжаа тэдний шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор хоорондоо нилээд зөрүүтэй саналууд байсан билээ. Уг дурсгал илэрсэнээр тэдний түүхэн газарзүйн баримжаа тэдний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой болох нь тогтоогдсон юм.

Шинэ хэрэглэгдэхүүнүүд нь тухайн үеийн аймгийн тэргүүнээр ахлуулсан өөртөө засах маягийн аймгийн зохион байгуулалт, мөн үеийн аймгийн дотоод зохион байгуулалтыг сэргээн харах тулгуур сурвалж болсон юм. Бас тэр үеийн түүхэн газарзүйн асуудлыг цоо шинээр авч үзэхүйц хэрэглэгдэхүүн, дундад эртний үеийн түүхэнд холбогдох археологийн дурсгалуудыг тайлбарлах гол тулгуур болж өгсөн юм. Үүнээс гадна, Зүүн Түрэгийн хаант улсаас хожуу Түрэгийн хаант улсын үед улс төрийн цол нэр идэвхитэй хэрэглэгдэж аймгийн тэргүүн нар зүүж байсан Сэбиг хэмээх цолыг нэхэн сэргээж гаргасан нь дундад эртний улс төрийн зохион байгуулалт, улс төрийн цолын судалгаанд шинэхэн хувь нэмэр болж байна.

Заамарын Шороон Довоос илэрсэн, тахилын аяганы ёроолд сийлсэн тамгыг бусад сурвалжийн баримттай харгуулан тухайн үеийн аймгийн дотоод зохион байгуулалтыг тодруулсан болно. Уг савны ёроолд сийлсэн нэмэлт бүхий онгин тамга нь тухайн аймгийн дотор нэг тамганаас салаалсан үүсмэл тамга бүхий төрлийнхний төлөөлөл хэмээн үзлээ.

Пүгү аймаг нь Хожуу Түрэг, Уйгурын хаант улс байгуулагдах үйл явдалд хүч хавсарч явсан аймаг юм. Мөн Уйгур буюу Хуйхэ аймагтай эртнээс худ худгайн холбоотон болж явсан бөгөөд Уйгурын хаант улс мөхөхөд Уйгурын зарим аймгуудыг тэргүүлэн баруун тийш шилжиж Гаочангийн Уйгурын хаант улсыг байгуулж тал нутгийн улс төрийн уламжлалыг шилжүүлэн авсан байна. Түүхийн явцад дунд улс төрийн шалтгаанаар зарим тохиолдолд тал нутгийн өндөрлөгөөс шахагдах, өөр хоорондоо эвдрэлцэн аймаг дотроо хагаралдах, хуваагдан нүүх тохиолдол ч байжээ. Х зууны эхээр тал нутагт хятан

нар товойн гарч ирсэн түүхэн үйл явцад тус аймгийнхнаас оролцон явсан бөгөөд Хятаны Елюй овогтой худ бололцсон нь тал нутгийн төр ёсны уламжлалыг тасалдуулаагүй өртөөлөн залгамжилсныг илтгэнэ. Өөрөөр хэлбэл ойролцоо цаг үед Пүгү аймгийн тэргүүлэх хэсэг Гаочангийн хаант улс байгуулсан бол Пүгү аймгийн нөгөө хэсэг буюу өнөөгийн Монгол улсын зүүн хэсэгт оршин сууж байсан нь Хятан улсын худ болсон байна.

Хятан нар өнөөгийн Монгол улсын нутагт цөмрөн орж Хэрлэн, Туул, Орхоны хөндийг эзлэн авахдаа хуучин Уйгурын Хятан хотыг түшиглэн Жэнжоуг байгуулсан зэрэг нь санамсаргүй тохиолдол бус, хуучин Уйгурын холбооны аймгууд Хятаны холбоонд оролцон явсны илрэл хэмээн үзэж байна. Хятан нар Монгол нутагт цөмрөөд Туулын хөндийд гол хотуудаа цогцлоосон нь Хүннүгээс хойших талын нүүдэлчдийн бүхий л төрт улсуудын хувьд тал нутгийг хяналтандаа байлгах чухал түшиц газар байж гэдгийг давхар нотолж байна. Энэ бүс нутаг нь Монгол нутгийн төв буюу Хангай, Хэнтий хэмээх хоёр нурууны завсар газар бөгөөд Орхон, Туул, Сэлэнгийн бэлчир газрын уулзвар учир нүүдэлчдийн улс төр, эдийн засагт хамгийн ашигтай газар байсан учир энэ л газрыг эзэлсэн нь тал нутгийг ноёрхох эрх хүртдэг байжээ.

Пүгү аймгийн түүхээс үзэхэд тал нутагт худ худгай буюу худ ураг барилдсан аймгууд шууд холбоотон болдог байсан уламжлал хүчтэй байсан нь харагдах бөгөөд үүнийг лавшруулан үзүүштэй сэдэв гэж хэлж болно.

Пүгү аймгийн талаарх судалгааг эцэст нь дүгнэж хэлэхэд Түрэг, Уйгур, Хятан нартай холбоолон тал нутгийн улс төрд идэвхтэй оролцож байсан аймаг бөгөөд тэд тал нутагт шинэ хүчин гарч ирэхэд хүч хавсарч явж байсан бол зарим үед тухайн төр унахад ч нөлөөлж чаддаг хүчирхэг аймаг байжээ.

НОМЗҮЙ

[1] Очир А., Данилов В.С., Эрдэнэболд Л., Цэрэндорж Ц. Эртний нүүдэлчдийн бунхант булшны малтлага судалгаа. -УБ., 2013. 17-31.

[2] Очир А., Эрдэнэболд Л., Харжаубай С., Жантегин Х.. Эртний нүүдэлчдийн бунхант булшны малтлага судалгаа. -УБ., 2013. 227.

[3] New Archaeological Findings of the Early Nomads, *Nomadic Monthly Newspaper* No. 81, 2009, p. 5.

[4] 杨富学. 唐代仆固部世系考——以蒙古国新出仆固氏墓志铭为中心. 西域研究. 2012年1期

[5] 赵靖, 杨富学. 仆固部与唐朝关系. 新疆大学学报 (哲学人文社会科学版). 2011年. 11月

[6] Данилов С.В., Бураев А.И., Саганов Б.В., Очир А., Эрдэнэболд Л., Батболд Г.. Курган Шороон дов и его место в общей системе археологических памятников тюркской эпохи Центральной Азии. Древние культуры Монголии и Байкальской Сибири. -Улан-Удэ, 2010. 254-257.

- [7] Бураев А.И. С культуры Танского времени из кургана Шороон Дов в центральной Монголии. 中国北方及蒙古、贝加尔、西伯利亚地区古代文化. (中). 内蒙古博物馆. 2015年. 600-607页
- [8] Cengiz Alyılmaz. Zanabazar Güzel Sanatlar Müzesindeki Türk Eserleri. Ötüken'den İstanbul'a Türkiyenin 1290 Yılı (720-2010) sempozyumu. istanbul. 2011. 87-109.
- [9] Амар А. Монголын товч түүх. -УБ., 1989. 57-59.
- [10] Батсүрэн Б. Түрэг, Тэлэ нарын 630-680/690 оны төрийн түүхийн асуудалд. //Түүхийн судлал//. Том. XXXV, fasc. 4. - УБ., 2004. 33-43.
- [11] 赵靖, 杨福学. 仆固部与唐朝关系考. 新疆大学学报. 2011年11月. Vol. 39, №. 6.
- [12] 薛宗正. 仆固部的兴趣及其与突厥、回鹘的关系. 西域研究. 2000年, 第3期. 10页.
- [13] 王世丽. 安北与单于都护府-唐代北部边疆民族问题研究. 云南 2006. 43-44
- [14] 《册府元龟》卷986, 外臣部, 征讨五
- [15] 薛宗正. 仆固部的兴趣及其与突厥、回鹘的关系. 西域研究. 2000年, 第3期. 11页
- [16] 《册府元龟》, 卷445, 将帅部, 无谋。
- [17] 《全唐文》卷209, 《为乔补阌论突厥表》。
- [18] 王田田. 唐与回纥和亲研究. 邢台学院学报. 2007年3月53页
- [19] 杨圣敏. 回纥史. 广西师范大学出版社. 2008年. 60-61

REFERENCES

- [1] Ochir A., Danilov V.S., Jerdjenjebold L., Cjerjendorzh C. Jertnij nydjelchdijn bunhant bulshny maltlaga sudalgaa. -UB., 2013. 17-31.
- [2] Ochir A., Jerdjenjebold L., Harzhaubaj S., Zhantegin H.. Jertnij nydjelchdijn bunhant bulshny maltlaga sudalgaa. -UB., 2013. 227.
- [3] New Archaeological Findings of the Early Nomads, Nomadic Monthly Newspaper No. 81, 2009, p. 5.
- [4] 杨富学. 唐代仆固部世系考——以蒙古国新出仆固氏墓志铭为中心. 西域研究. 2012年1期
- [5] 赵靖, 杨富学. 仆固部与唐朝关系. 新疆大学学报 (哲学人文社会科学版). 2011年. 11月
- [6] Danilov S.V., Buraev A.I., Saganov B.V., Ochir A., Jerdjenjebold L., Batbold G.. Kurgan Shoroon dov i ego mesto v obshhej sisteme arheologicheskikh pamjatnikov tjurkskoj jepohi Central'noj Azii. Drevnie kul'tury Mongolii i Bajkal'skoj Sibiri. -Ulan-Udje, 2010. 254-257.

- [7] Buraev A.I. S kul'tury Tanskogo vremeni iz kurgana Shoroon Dov v central'noj Mongolii. 中国北方及蒙古、贝加尔、西伯利亚地区古代文化. (中). 内蒙古博物馆. 2015年. 600-607页
- [8] Cengiz Alyılmaz. Zanabazar Güzel Sanatlar Müzesindeki Türk Eserleri. Ötüken'den İstanbul'a Türkiye'nin 1290 Yılı (720-2010) sempozyumu. istanbul. 2011. 87-109.
- [9] Amar A. Mongolyn товч түүх. -UB., 1989. 57-59.
- [10] Batsyrjen B. Түрјег, Тјелје naryn 630-680/690 ony төrijн түүhјjn asuudald. //Түүhјjn судlal//. Tom. XXXV, fasc. 4. - UB., 2004. 33-43.
- [11] 赵靖, 杨福学. 仆固部与唐朝关系考. 新疆大学学报. 2011年11月. Vol. 39, №. 6.
- [12] 薛宗正. 仆固部的兴趣及其与突厥、回鹘的关系. 西域研究. 2000年, 第3期. 10页.
- [13] 王世丽. 安北与单于都护府-唐代北部边疆民族问题研究. 云南. 2006. 43-44
- [14] 《册府元龟》卷986, 外臣部, 征讨五
- [15] 薛宗正. 仆固部的兴趣及其与突厥、回鹘的关系. 西域研究. 2000年, 第3期. 11页
- [16] 《册府元龟》, 卷445, 将帅部, 无谋。
- [17] 《全唐文》卷209, 《为乔补厔论突厥表》。
- [18] 王田田. 唐与回纥和亲研究. 邢台学院学报. 2007年3月53页
- [19] 杨圣敏. 回纥史. 广西师范大学出版社. 2008年. 60-61

МРНТИ 03.41.91

УДК 902.904. 2. 4. 01.

УЛИАСТАЙ ДАХЬ ЭРТНИЙ ХОТЫН ТУУРЬ**Д. Баярсайхан**

Улаанбаатарын Их сургуулийн Төрийн захиргаа,
Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн
эрхлэгч, түүхийн ухааны доктор (Ph.D), профессор
E-mail: bayraahistory@gmail.com

Хураангуй: Монгол улсын нутаг дахь хот суурины түүхнээ өөрийн гэсэн балрашгүй ул мөрийг үлдээсэн, өнөө бидний үе хүртэл суурьшлын уламжлалаа хадгалан ирсэн цөөн хэдэн хотын нэг нь Улиастай хот болно. Улиастай хот орчмоор хийсэн хайгуул судалгааны үр дүнд Хүннү гүрний үед холбогдохуйц нэгэн хотын туурийг илрүүлсэн болно. Энэ тухай өгүүлэх болно.

Түлхүүр үг: Улиастай, Хуучин хотын туурь, Сангийн хот, Хүннү гүрэн, Жао Синь, Чигэстэй гол.

IRSTI 03.41.91

UDC 902.904. 2. 4. 01.

ANCIENT CITY REMAINS IN ULIASTAI**D. Bayarsaikhan**

Department of public administration and humanity,
Ulaanbaatar state university, Mongolia.
Doctor of historical science (Ph.D), professor
E-mail: bayraahistory@gmail.com

Abstract: I have tried to state about the origin of the Uliastai city. To consider Sangiin Hot which was established in 1733 as the origin of Uliastai city cannot match with nowadays research. According to the research and other sources, it can be seen that Uliastai city of nowadays could exist at the riverside of the Chigestei River, on the back side of Khangai Mountain range in Xiongnu era. Also there are some facts which stated that Chinese scientist, monk Chani Chuni traveled via Ulias villa in 1225. Another fact is stated that authorities of Zasagt Khans build

their palaces here. According to these facts it can be considered Uliastai city has the ancient origin, but Manchus founded their Sangiin City based on this villa.

Keywords: Uliastai, Ancient city, City of Finance, The Xiongnu Empire, Zhao Xin, Chigistei river.

МРНТИ 03.41.91

УДК 902.904. 2. 4. 01.

ОСТАНКИ ДРЕВНЕГО ГОРОДА УЛИАСТАЙ

Д. Баярсайхан

Ph.D, профессор, кафедра государственного управления
и гуманитарных наук, Улан-Баторский государственный университет,
Монголия.

E-mail: bayraahistory@gmail.com

Аннотация: Статья посвящена происхождению города Улиастай. Согласно современным исследованиям руины древнего города Сангийн Хот, основанного в 1733 году были найдены в окрестностях города Улиастай. По утверждению исследователей, в хуннский период, город Улиастай был расположен на берегу реки Чигестей, на обратной стороне хребта Хангай. Также есть некоторые факты, свидетельствующие о том, что китайский ученый, монах Чани Чуни путешествовал через поместье Улиас в 1225 году. Утверждается также, что Засагт ханы построили здесь свои дворцы. По этим фактам можно считать, что город имеет древнее происхождение, но маньчжуры основали свой город Сангийн Хот на базе этого поместья.

Ключевые слова: Улиастай, древний город, город финансов, Империя Сунну, Чжао Синь, река Чигистей.

Бидний өвөг дээдэс сонгодог мал аж ахуйд тулгуурласан нүүдлийн амьдралын хэвшлийг бий болгон хэдэн зууны турш амьдарч ирсэн хэдий ч төр улсыг байгуулан, хот сууринийг цогцлоож ирсэн ард түмэн билээ. Монгол улсын нутаг дахь хот суурины түүхнээ өөрийн гэсэн балрашгүй ул мөрийг үлдээсэн, өнөө бидний үе хүртэл суурьшлын уламжлалаа хадгалан ирсэн цөөн хэдэн хотын нэгэн нь Улиастай хот болно.

Хайгуул судлагааны ажлын явцад эртний хотын үлдэгдэл илрүүлсэн бөгөөд тэрхүү хотын туурь нь мэдэгдэм төдий байхын дээр, уг хотын туурь дээр

1733 онд Манж Чин гүрний эрх баригсад Сангийн хотыг байгуулан “Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн жанжны газар”-ыг төвлөрүүлсэн тул урьд өмнөх судалгаанд мэдэгдэдгүй байжээ.

1. Туурийн ерөнхий байдал

Орчны байдал. Бидний Хүннү гүрний үед холбогдох болов уу хэмээн үзэж буй эртний нэгэн хотын туурь Завхан аймгийн Улиастай хотод, хотын төвийн хэсгээс баруун этгээдэд Богд, Чигэстэй хоёр голын хооронд оршино. Тус газар 1733 онд Манж Чин гүрний эрх баригчдын байгуулсан “Сангийн хот”-ын туурь орших бөгөөд бидний үзэж байгаагаар тус хотыг Хүннү гүрний үед байсан хотын үлдэгдэл дээр байгуулсан бололтой байна.

Туурийн зүүн этгээдээр Чигэстэйн гол, баруун этгээдээр Богдын гол урсана. Зүүн хойд этгээдэд Жинс хайрхан уул оршино. Хойд талаас Чигэстэйн голын сав байна. Туурийн хойд этгээдэд Жинс уулаас өмнө зүг түрсэн жижиг толгой тулна. Тус толгойг Шивээ толгой хэмээнэ. Эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн, зөвхөн баруун өмнө талд Чигэстэй, Богдын гол нийлэн урсах голын сав байна.

Хотын туурийн ерөнхий байдал. Энэ хотын туурь Улаанбаатар хотоос зүүн тийш 1104 зайтай, хойд өргөрөгийн 47°44'50,75, зүүн уртрагийн 96°52'29,71 хэмийн солбицолд далайн түвшнээс дээс 177 метр өндөрт оршино. Баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон байдалтай. Энэхүү туурь нь хэмжээний хувьд 1725х750 метр хэмжээтэй. Үүнээс зүүн талруу шахсан байдалтайгаар 925х750 метрт нь Манж нар Сангийн хотыг байгуулсан.

Хуучин хотын туурийг баруун хойноос зүүн өмнө зүг сунаж тогтсон байдлаар байгуулсан нь тал бүрээс нар тусаж байхаар тооцож хийсэн ажээ. Туурийн хэрмийг шороо дагтаршуулан үйлдсэн. Шороон далангийн өндөр 0,5 метр, өргөн нь 2 метр орчим, эргэн тойрон усны шуудуутай, шуудууны өргөн метр. Чигэстэйн голын нэгэн салаанаас ус татан оруулсан байдалтай. Харин Сангийн хотын туурь нь 410х335 метр хэмжээтэй, ийн шороон далан нь харьцангуй өндөр метр хэмжээтэй, усан далангийн өргөн нь ... метр, гүн нь 4-6 метр байна.

Сайн уу хө сангийн хот зүүн тийш арай урт юм байна лэ, зүүн тийм урт нь 410 метр, өргөн нь 335 метр, ханын өргөн нь 8 метр ч байна нуруулт үүсээд өргөссөн байх, усан шуудууны гүн нь 4-6 метр.


Хуучин хотын туурь дээр хожим Сангийн хотыг байгуулсан учир аль талдаа хэдэн хаалгатай байсныг тодруулах боломжгүй. Харин хотын ерөнхий байдлыг ажвал баруун зүүн өмнөд гэсэн 3 талдаа хаалгатай байсан болов уу гэсэн сэтгэгдэл төрнө.

Хотын туурийн хажуугийн толгой дээрх байгууламж. Улиастайн эртний хотын туурийн зүүн талд Жинс хайрхан уулаас баруун тийш үргэлжлэн

тогтсон 4 жижиг толгой бий. Тэдгээрийг Шивээ толгой хэмээнэ. Энэхүү 4 толгойг дамнуулан тусгайлан зассан зам байх бөгөөд хамгийн баруун талын толгой дээр түүдэг гарган дохио өгч байсан ул мөр, мөн тусгайлан зассан дэвсэг байна.



Зураг 1. Дурсгалын байршлын зураг.



Зураг 2. Дурсгалын агаарын зураг.



Зураг 3. Дурсгалын гэрэл зураг.



Зураг 4. Шивээ толгой дээрх байгууламж

2. Холбогдох он цаг

Бид Улиастайд орших энэхүү хуучин хотын туурийг Хүннү гүрний үед холбогдох болов уу хэмээн урьдчилсан таамаг дэвшүүлсэн бөгөөд энэ саналаа баримтжуулахын тулд Хүннү гүрний үед хамаарах хотын туурь, балгасуудыг судлан үзэж харьцуулсан судалгаа хийх шаардлага урган гарсан юм.

Монгол улсын нутагт буй хот суурингийн түүх анхны төрт улс болох Хүннү гүрний үеэс эхлэлтэй. Монголын түүхийн судалгааны суурь бүтээлүүд [4; 12], тэрчлэн хот суурингийн түүхийн судалгааны бүтээлүүд [21; 7; 23; 18; 14; 2; 22; 25; 27; 31], Хүннүгийн түүхийг судалсан эрдэмтдийн хэвлүүлсэн нэгэн сэдэвт зохиол [21; 7; 23] -д мөнхүү улсын үед холбогдох хот суурингийн талаар судлан бичсэн байна.

Эрдэмтэн А.Дамдинсүрэн бүтээлдээ Хүннүгийн үед Монгол газар нутагт Лун Ци, Жао Синь Чэнь, Фань Фу Жэнь Чэнь, Ту Сэн зэрэг хотууд байсан [6, 22] хэмээн бичжээ.

Археологич Ц.Доржсүрэн “Умард Хүннү” бүтээлдээ Хүннү гүрний үед холбогдох, Иволгийн суурин, Бүрхийн дөрвөлжин газар, Гуа дов, Тэрэлжийн дөрвөлжин газар, Дөрөөгийн хэрэм зэргийн талаар судлан бичжээ [7, 19].

“Хүннүгийн түүх, соёл” хэмээх бүтээлд Хүннүгийн үед холбогдол бүхий Иволгийн суурин, Тэрэлжийн дөрвөлжин, Луут хот, Өндөр дов, Хүрээн дов, Цэнхэрийн голын хэрэм, Дөрөөгийн хэрэм буюу Барс хот -2, Хэрмэн тал, Бүрхийн дөрвөлжин, Жао Синь Чэн, Фань Фу Жэнь зэрэг бий хэмээгээд Жао Синь хотыг Баянбулагийн туурь мөн хэмээн бичив [26, 219].

Археологич Д.Цэвээндорж, Д.Баяр, У.Эрдэнэбат нар, Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Хүрээн дов, Бороогийн суурин, Өндөр дов, Гуа дов, Цэнхэрийн голын хэрэм, Шувуутайн голын хэрэм, Баруун дөрөөгийн хэрэм буюу Барс хот-II, Баянбулагийн туурь зэрэг хот сууриныг их бага аль нэгэн хэмжээгээр судалсны үндсэнд он цагийг Хүннүгийн үед холбогдуулан үзсэн [28] байна.

Хүннү гүрний үед холбогдуулан үзсэн, мөн хайгуул малтлага судалгаа хийсэн хотуудын талаар товчхон байдлаар судлан үзвэл дараах дүр зураг тодорно.

Гуа дов. Төв аймгийн Баянжаргалан сум Хэрлэн голын эрэг Цагаан арлын орчим. Хэрлэнгийн Цагаан арлын Гуа дов хэмээх нэлээд том суурин байжээ. 367х360 метр хэмжээтэй. Хэрмийн өндөр нь 0,5-0,7 метр. Урд, хойд талдаа нэг нэг хаалгатай байсан [7, 54]. Хэрэмний өргөн нь 3,5 метр. Хүннүгийн үед хамаарах дээврийн ваарын хагархай, ширмэл ширдэгний хээтэй дөрвөлжин тосгоны хэлтэрхий, олон тооны шатсан тоосго, хятад үсгийн хээтэй төмөр товч, шаазан савны хагархай зэрэг олдворыг олж илрүүлсэн байна. Дээрх бүх олдворт тулгуурлан уг хэрмийг хүннү нарын мандсан үед холбогдох тахилгын дурсгал гэж үзсэн.

Тэрэлжийн дөрвөлжин газар. Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Тэрэлжийн зүүн голын эрэгт бий. Хэрмийн тал болгон 235 метр. Өндөр нь 05,-0,8 метр. өргөн нь 10-15 метр байна. Хэрмийн гадна талаар нь татсан сувгийн өргөн нь 3-6 м, гүн нь 0,5-0,7 м ажээ. 1952 онд Х.Пэрлээ хоёр барилгын орыг малтан шинжилсэн бөгөөд малтлагаас гарсан барилгын тосгуур ваар, нөмрөг ваар, хээтэй тоосго зэрэг олдвор хэрэглэгдэхүүн нь Гуа довоос олдсон олдворуудтай адил байсан байна. Х.Пэрлээ нь Тэрэлжийн дөрвөлжинг Хүннүгийн үеийн шүтлэгийн чанартай суурин байсан гэж үзжээ.

Баянбулагийн туурь. Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг, сумын төвөөс урагш 30 орчим км-т Баянбулаг голын зүүн эрэг, Борзонгийн говийн хойд зах, Хөрхийн нурууны урд хэсэгт оршино. Шороо дагтаршуулан хийсэн хэрэмтэй, хэрмийн хэмжээ хойд тал нь 180 м, баруун тал 110 м, ханын өргөн 10-16 м болно. Дөрвөлжин хэрмийн ихэнх хэсэг нь эвдэрч, зөвхөн хойд талын хана бүтнээрээ, баруун ханын тал хэсэг нь хадгалагдан үлджээ. Хойд талд нь 2 м орчим өндөртэй хоёр овгор байх бөгөөд үүнийг харуул хамгаалалтын газар байсан гэж үзжээ. Археологич Х.Пэрлээ, Д.Наваан, Д.Цэвээндорж нар малтан судалж, Хүннү улсын үеийн хээтэй шавар ваарны хагархай, төмөр шилбэтэй хүрэл зэв зэргийг олж, эндээс шавар сав шатаасны үлдэц, төмрийн баас, Хан улсын үеийн у-шу зоос, зориулалт нь тодорхойгүй хүр-

эл эдлэл, ваар савны хагархай, хүрэл зэв, мутрын хүрэл тамга, элдэв төмөр эдлэлийн үлдэгдэл, хүрэл толины хагархай, зэргийг үндэслэн мөн улсын үед хамааруулан үзжээ.

Иволгийн суурин. Буриадын нийслэл Улаан-Үүдээс 16 км-ийн зайд Сэлэнгэ мөрний хуучин голтригийн хөвөөн дээр “Иволгийн балгас” хэмээх Хүннү суурин байсан байна. Энэ суурингийн баруун хэрмийн урт нь 348х216 метр. Шуудууны гүн нь 2-2,5 метр, өргөн нь 35-38 метр. Шороон хэрэмний одоогийн өндөр нь 0,5 метр. Хүннүгийн хамгийн умард хэсгийн бэхлэлт хот. Язгууртны сууцыг тойруулан жирийн иргэдийн сууцыг байгуулсан зохион байгуулалттай [7, 52].

Барс хот 2. Дорнод аймгийн Цагаан овоо сум, Хэрлэн голын зүүн эрэгт, Барс хот 1-с 7 км зайтай [11, 17]. Баруун дөрөөгийн хэрэм хэмээдэг. 345х335 метр хэмжээтэй. Өргөн нь 4-5 метр, өндөр нь 1-2 метр байна [7, 56].

Шувуутын голын хэрэм. Хэнтий аймгийн Орхон сумын нутаг, Орхон голын цутгал Шар шувуутын голын баруун эрэгт бий. Хэрмийн хэмжээ нь өмнөд тал нь 225 метр, хойд тал нь 265 метр, баруун тал нь 193 метр, зүүн тал нь 187 метр, дөрвөн талдаа хаалга байсан оромтой.

Хэрэмт талын гурван хэрэм. Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг, сумын төвөөс хойш 20 орчим км-т Тамирын голын хойд хөвөө Хэрмэн тал хэмээх газар оршдог. Баруунаас зүүн тийш цуварсан 3 хэрэмнээс тогтоно. Баруун талын хэрэмний өндөр нь 1,5 метр, 400х452 метр хэмжээтэй. Баруун зүүн урд талдаа хаалгатай, Хаалганы өндөр 10 метр. Дунд хэрэм нь баруун хэрэмнээс 160 метр зайтай оршино. 430х290 метр хэмжээтэй. Хаалганы өргөн 10 метр. Зүүн хэрэм намхан хэсэгтээ үл мэдэгдэм болсон, дунд хэрэмнээс 270 метрт оршино. Археологич З.Батсайхан судлан шинжсэн.

Сантын ширээний балгас. Төв аймгийн Баян сумын нутаг Сантын ширээт хэмээх газар оршдог. Балгасны хэмжээ тодорхойгүй.

Бороогийн суурин. Сэлэнгэ аймгийн Мандал сум, Төв аймгийн Борнуур сумын нутгийн зааг, Цагаанчулуутын амны адагт Бороо голын хойд дэнж дээр оршино. Эргэн тойрон 100 м хэмжээтэй. Хэрмийн үлдэгдлийн одоогийн өндөр нь 20 см өндөртэй байна. Энэхүү сууринд малтан шинжилсэн орон сууцны хийц, зохион байгуулалт нь Иволгийн суурингийнхтай адил байгаа, мөн эндхийн болон Ноён уулын вааран савны найрлага нь спектр задлан шинжилгээний дүнд яг ижил байсан зэрэг Хүннү гүрний үед холбогдуулан үзэхэд нөлөө үзүүлжээ.

Луут хот. Хархорин орчмоор байх ёстой хэмээн үздэг. Хүннүгийн шаньюйн орд хэмээдэг. Хайн илрүүлж хараахан амжаагүй.

Бүрхийн дөрвөлжин. Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг, Зүүн Бүрх голын баруун эрэгт сумын төвөөс зүүн тийш бий. 180х180 метр хэмжээ бүхий хэрэмтэй.

Фань хатны суурин. Халхад Хүннүгийн Фань хатны суурин гэж байжээ.

Хүрээт дов. Төв аймгийн Баяндэлгэр сум, Баруун байдрагийн голын зүүн эрэгт бий.

Өндөр дов. Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг Их Бага Гүн нууруудын орчим.

Цэнхэрийн голын хэрэм. Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутаг Цэнхэрийн голын зүүн эрэгт бий. Хэрмийн хэмжээ нь 300х300 метр

Баян-Өндөрийн суурин. Зэд голын баруун эрэгт оршдог. 70х70 метр хэмжээтэй. Хэрэмний өндөр нь 1 метр орчим. 1,6-1,7 метр гүн шуудуутай.

Доод Мангиртайн суурин. Хялга голын баруун эрэгт бий.

Дөрөөгийн суурин. Хиагтаас зүүн тийш 35 км-т, Цөх голын хөвөөнд Дурен хэмээх тосгоны хажууд оршино.

Жао Син Чэнь. Хангайн нуруунд Хүннүгийн тариа будааны нөөцийг хадгалдаг Чжаосинь хэмээх суурин байжээ.

№	Туурийн нэр	Орших газар	Хэрэмний талбайн хэмжээ	Хэрэмний өндөр / Метр/	Усан шуудууны гүн / Метр/	Тайлбар
1.	Гуа дов	Төв аймгийн Баян-жаргалан сум Хэрлэн голын эрэг Цагаан арл	367х360	0,5-0,7		
2.	Тэрэлжийн дөрвөлжин	Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Тэрэлжийн зүүн голын эрэг	235х235	05,-0,8	0,5-0,7	Хүннүгийн үеийн барилгын тосгуур ваар, нөмрөг ваар, хээтэй тоосго гарсан
3.	Бүрхийн дөрвөлжин	Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг, Зүүн Бүрх голын баруун эрэг	180х180 метр			
4.	Баянбулагийн туурь	Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг, сумын төвөөс урагш 30 орчим км-т Баянбулаг голын зүүн эрэг, Борзонгийн говийн хойд зах, Хөрхийн нурууны урд хэсэг	180х110			

5.	Иволжийн суурин	Буриадын нийслэл Улаан-Үүдээс 16 км-ийн зайд Сэлэнгэ мөрний хуучин гол-тригийн хөвөө	348x216	0,5	2-2,5	
6.	Барс хот 2	Дорнод аймгийн Цагаан овоо сум, Хэрлэн голын зүүн эрэгт	345x335	1-2		
7.	Цэнхэрийн голын хэрэм	Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутаг Цэнхэрийн голын зүүн эрэгт	300x300			
8.	Шувуутын голын хэрэм	Хэнтий аймгийн Орхон сумын нутаг, Орхон голын цутгал Шар шувуутын голын баруун эрэгт	225x265 x193x187			
9.	Хэрэмт талын гурван хэрэм	Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг, сумын төвөөс хойш 20 орчим км-т Тамирын голын хойд хөвөө	400x452 430x290	1,5		
10.	Баян-Өндөрийн суурин	Зэд голын баруун эрэгт оршдог	70x70	1 метр	1,6-1,7	
11.	Бороогийн суурин	Сэлэнгэ аймгийн Мандал сум, Төв аймгийн Борнуур сумын нутгийн зааг, Цагаанчулуутын амны адагт Бороо голын хойд дэнж	100x100	0,2		Хүннүгийн аж ахуйн төв байсан
12.	Улиастайн суурин	Завхан аймгийн Улиастай хот Богдын гол, Чигэстэй голын бэлчирт	1725x750	0,5		

Дээр өгүүлсэн судалгааны хэрэглэгдэхүүнээс харахад Улиастайн суурин нь эдүгээ илрээд байгаа Хүннүгийн үеийн хотын тууриудаас талбайн хувьд хамгийн том хэмжээтэй болох нь харагдана. Эдүгээ мэдэгдээд байгаа Хүннүгийн үеийн хот сууриний тууриас хамгийн том гэгдэж байсан нь, Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг, сумын төвөөс хойш 20 орчим км-т Тамирын голын хойд хөвөөнд орших Хэрэмт талын гурван хэрэм бөгөөд түүний 2 хэрэм нь 400x452 болон 430x290 хэмжээтэй юм. Монгол нутгаас илэрсэн хот суурингийн дурсгал дунд хэмжээний хувьд Улиастайн сууринтай ойролцоо хэмжээ бүхий суурин хэд хэд бий. Тухайлбал, Булган аймгийн Дашинчилэн

сумын нутагт орших Чинтолгой балгас хэмээх Хятан гүрэн (903-1125 он)-ий үед хамаарах хотын туурь 1260х680 метр хэмжээтэй байна [17, 7].

- **Хэрэмний далан.** Хүннүгийн үеийн хотуудын хэрмийг их төлөв шороо дагтаршуулан хийжээ. Улиастайн суурин мөн адил тэр уламжлалаар хийгджээ. Шороон хэрэм нь 1725х750 метр хэмжээтэй, өндөр нь дунджаар 0,5 метр байна. Монгол улсын нутгаас илэрсэн Хүннүгийн үеийн хотын тууриудыг ажиглахад 0,5-2 метрийн хооронд байна. Харин хуучин хотын туурь дээр 1733 онд байгуулсан Сангийн хотын туурь нь хэмжээний хувьд 1-2 метрийн өндөртэй байгаа нь хуучин хотын туурь нэлээн эртнийх болохыг харуулж байна.

- **Усан шуудуу.** Хотын туурийн хэрмний гадуур усан шуудуу байсан нь тодорхой мэдэгдэнэ. Усан шуудууны гүн нь дунджаар 0,2-0,5 метр, зарим газар мэдэгдэхгүй бол эдгэжээ. Харин хойд талын хэрэмний усан шуудуугаар Чигэстэй голын нэгэн салаа урсаж бараг мэдэгдэхгүй болтлоо эдгэсэн байна. Сайтар ажиглан харвал нэгэн шугмын дагуу хуучин усан шуудууны сувгаар урсаж байгаа нь мэдэгдэнэ. Хүннүгийн үед холбогдох хотын тууриудыг ажиглавал дийлэнхийг нь гол мөрний сав дагуу байгуулж, хамгаалалтын усан шуудуу хийж байжээ. Харин ихэнх нь мэдэгдэхгүй болж эдгэсэн байна. Тэрэлжийн дөрвөлжингийн туурийн усан шуудууны гүн 0,5-0,7 метр байгаа бол, Иволгийн суурин 2-2,5 метр хэмээн бичсэн байна. Сангийн хотыг хожим байгуулахдаа мөн усан шуудуутай байгуулсан бөгөөд түүний гүн нь 2-2,5 метр байна.



Хуучин хотын туурийн шороон далан ба усан шуудуу

Сангийн хотын туурийн далан ба усан шуудуу

Зураг 5. Хотын туурийн далан ба усан шуудууны харьцуулсан зураг.

- **Түүвэр олдвор, ваар савны хагархай.** Улиастайд орших энэхүү хотын тууриас түүхийн харилцан адилгүй үед холбогдох дурсгал багагүй олддог. Их төлөв XVIII-XX зууны эхэн хагаст хамаарах түүхийн дурсгал илрэх авч Хүннү гүрний үед хамаарах дурсгал мөн илрээд байна.

Улиастайд орших энэхүү хотын туурийн талаар манай эрдэмтэд өмнө мэдээлж байсан бөгөөд доктор, профессор Д.Эрдэнэбаатар хайгуул судалгааныхаа явцад тус бүс нутгаас Хүннүгийн үеийн ваар илрүүлж байсан бол доктор Л.Эрдэнэболд мөнхүү дурсгалыг судлан үзээд хуучин хотын туурийг Уйгурын үед холбогдох болов уу хэмээн үзэж байжээ.

Хүннүгийн үеийн түүхийн судалгаанаас харахад Монгол орны төв болон зүүн бүс нутагт Хүннүгийн хот суурингийн судалгаа сайн хийгдэж харин баруун бүс нутагт бага хийгдсэн нь харагдана. Мөн түүхийн судалгааны бүтээлд, Хархорумын байгаа газарт юмуу түүний ойр орчинд Хүннү гүрний шаньюйн өргөө ордон байсан Луут хот буюу Хүннүгийн нийслэл нэгэн хот байсан нь тодорхой боловч чухам ямар хот байсан тухай баримт мэдээ үлдсэнгүй. Мэдээжийн хэрэг тэрхүү хот нь Хүннүгийн хотуудын хамгийн том бөгөөд бат бэх, илүү сүрлэг нь байсан байх ёстой. Тэр хотод шаньюйн өргөө ордны дэргэд тусгай сүм дуган байсан тухай сурвалжийн дотор тэмдэглэгдэн үлдсэн байдаг [12, 233] хэмээн бичсээр иржээ.

Мөн доктор Г.Сүхбаатар нэгэн сэдэвт зохиолдоо, Онгийн голын тэнд Лүнци (Лууны сүм) хэмээх мөргөлийн нэгэн жижиг суурин байсан бололтой

байгаа юм. Өмнөд Хүннү нар Хятадын Зүүн Хань улсад дагаар орсныхоо дараа говийн өмнө өөрсдийн байрлаж байсан газарт Онгийн голынхтой адил төсөө бүхий бас нэгэн Лүнцы сүм барьсан байна. Гэвч тэрхүү сүм чухам хана байсан тухай сурвалжид тодорхой тэмдэглэгдэн үлдсэнгүй. Хүннүгийн хамгийн эртний суурин нь Газал хэмээх Иншань уулын хойно байсан Түмэн шаньюйн анхны өргөө ордны нэгэн бэсрэгхэн суурин байсан ажээ [23, 36] хэмээсэн нь ч буй.

3. Сурвалжийн мэдээ

Бид өмнө хэвлүүлсэн бүтээлдээ Улиастайд Хүннү гүрний үед хот байсан тухай бичиж, тэрхүү хотыг Жао Синь хэмээдэг байсан [3] тухай бичиж байсан билээ. Хүннүгийн үед хамаарах хот суурин хэмээн эрдэмтдийн судлан гаргасан жагсаалт дунд Жао Синь хэмээх нэгэн хотын тухай судалгаа бий. Энэхүү хотыг академич Х.Пэрлээ [20, 21], Оросын эрдэмтэн В.С.Таскин [24, 148], Японы эрдэмтэн Т.Морохаси [13, 233] нар Хангай уулын ар биед байсан хэмээн үзжээ. “Монгол улсын түүх” тэргүүн ботид,

“... Хангайн нуруунд Хүннүгийн тариа будааны нөөцийг хадгалдаг Жао Синь хэмээх суурин байжээ” [12, 233]

гэсэн нь бий.

Харин Монгол улсын эрдэмтэн Д.Цэвээндорж [29, 163], З.Батсайхан [1, 75] нар, мөн “Хүннүгийн түүх, соёл” [26, 219] хэмээх бүтээлд тус тус Жао Синь хотыг Баянбулагийн туурь мөн хэмээн бичив.

Сыма Цяний “Түүхэн тэмдэглэл” зохиолын 110-р бүлэг “Хүннүгийн шаштир”-т Жао Синь хотын тухай мэдээ гарч буй. Тус сурвалжид Жоа Синь хэмээх хотын тухай мэдээ гарч байна. Эхний мэдээ нь, МЭӨ 123 онд Жао хэмээх ноён Хүннүд дагаар орсон тухай юм. Энэ тухай тус сурвалжид,

“... Дараа жил-ийн хавар нь Хан улсын эзэн хаан ерөнхий жанжсин Вэй Цинд зургаан жанжсин зуу гаруй мянган морьт цэргээ удирдан хөдлөхийг тушаав. Тэр хоёр удаа Динсян тойргоос гарч хэдэн зуун ли газар туулан Хүннүчүүдийг довтолсон бөгөөд энэ хугацаанд нийт арван есөн мянга гаруй хүнийг хороохыг нь хороож, олзлохыг нь олзолжээ. Гэвч Хангийн цэрэг мөн л хохирол амсч хоёр жанжсин, гурван мянга гаруй морьтноо алдав. Баруун жигүүрийн жанжсин Су Цянь зугтаан амь мултарсан бол толгой ангийн жанжсин болох Си Хоу цолтой Жао Синь Хүннүчүүдэд ялагдан бууж өгчээ.” [32, 7-8] хэмээжээ.

Энэхүү Жао Синь хэмээх ноён нь урьд Хүннүгийн жижиг тушаалын ноён байсан бөгөөд Хан улсад дагаар орсон байжээ. Улмаар Хүннүд буун өгч дагасан байна.

Дараагийн нэг чухал мэдээ бол тэрхүү Жао Синь хэмээх ноёны сууж байсан хотын ойр Чигүчүкү хэмээх гол байсан тухай мэдээ юм. Жао Синь ноён

МЭӨ 110 онд таалал болоход тус хотод Хүннү гүрний шаньюй сууж байгаад, МЭӨ 90 онд хятадаас умрыг дайлах их цэрэг мордсоныг сонсоод хүнд ачаа бараагаа Чигүчүкү голын чигт умар зүг явуулж байсан аж. Энэ тухай “Түүхэн тэмдэглэл”-д,

“... Үүний дараа сайтар тэжээсэн агт бүхий зуун мянган цэргийг бэлтгэж, мөн хүнс ачих морьдоос гадна цэргүүд хувийн эд зүйлсээ ачих зуун дөчин мянган морьдыг тэжээн бэлтгэсэн байна. Ахлах жанжин Вэй Цин болон шилмэл морьт цэргийн жанжин Хо Цюй Бин хоёрт цэргийг хоёр тэнцүү хуваах тушаал өгчээ. Динсян тойргоос хөдлөх ахлах жанжин, Дай тойргоос хөдлөх Хо Цюй Бин хоёр говийг гатлан Хүннүчүүдийг довтлохоор тохиролцсон байна. Үүнийг дуулсан Шаньюй бээр Жао Синь хотоос ачаа хөсгөө Чигүчүкү голын чигт хойш татаад өөрөө шилдэг дайчдаа удирдан говийн хойд талд Хангийн ахлах жанжны цэрэгтэй тулалдав.” [32, 8]

гэжээ.

Жао Синь хэмээх хотоос умар зүгт Чигүчүкү хэмээх гол байгаа тухай мэдээ нь хамгийн чухал байна. Дээрэхээс харахад Улиастай дахь эртний хотод сууж байсан Хүннүгийн шаньюй Чигэстэй голыг өгсүүлэн умар зүг хүнд ачаагаа явуулсан болох нь тодорхой. Энд дан ганц Жоа овогтын ордноос гадна Хүннүгийн хааны орд бас бус барилга байсан [20, 22] гэж академич Х.Пэрлээ бичив.

Энэхүү Чигүчүкү хэмээх голыг өнөөгийн Чигэстэй гол мөн хэмээн үзэж байна. Хангай уулын ар биед орших Чигэстэй голын эртний нэр нь Чигүчүкү бололтой. Хүннү гүрний үед Чигүчүкү хэмээн нэрлэгдэж байсан бол түүнээс хойш бараг 1700 жилийн дараа буюу XVIII зууны сүүл үед бичигдсэн Манжийн төрийн түүхийн зохиол “Илтгэл шаштир”-т “Чигисүн” [9, 73-74] хэмээн гарна. Мөн 1841 онд Халхын түүхч Галдан туслагчийн бичсэн “Эрдэнийн эрих” зохиолд “Чигүрсүн” [5, 191] гэж гардаг.

Сыма Цяний “Түүхэн тэмдэглэл” дэх сүүлийн нэг мэдээ бол мөнхүү Жао Синь хэмээх хот нь Тяньянь хэмээх уулын ойролцоо оршиж байсан хэмээх мэдээ юм. Энэ тухай,

“... Нэгэн орой хүчтэй салхи дэгдэж шуурга тавьжээ. Хангийн цэрэг зүүн, баруун жигүүрээ хүмин Шаньюйг бүслэв. Түүний дайны эрдэм Хангийн цэргийнхээс дутуу байна хэмээн бодсон Шаньюй хэдэн зуун шилдэг эрсийн хамтаар Хангийн цэргийн бүслэлтийг сэт цохин баруун хойд зүгт зугтаан одов. Хангийн цэрэг түүнийг нэхэн хөөсөн боловч харанхуй болсны улмаас барьж чадсангүй. Шаньюйг нэхэх явцад тэд арван есөн мянган хүнийг хороох юмуу олзолсон байна. Хангийн цэрэг умард зүг давшин Тяньянь уулын ойролцоох Жао Синь хотыг хүрээд буцав.” [32, 9] хэмээсэн байна.

Зарим эрдэмтэд энд гарч буй Тянь Янь уулыг Хангай уул хэмээн үзэхгүй харин Говь-Алтайн нурууны зүүн үзүүрийн олон нуруудын нэг байж болно, тухайлбал, Хөрхийн нуруу байж болно хэмээн үзэж байгаа тул Баянбулагийн туурь бол Жоа Синь хот мөн байж болно [1, 78] хэмээжээ.

Жао Синь хэмээх хот нь Хангай уулын орчим байсан, мөн Чигүчүкү голын өгсүүлэн ачаа бараагаа илгээж байсан зэрэг нь өнөөгийн Улиастай хот орчим байсан болохыг шууд заахын дээр бидний өгүүлэн буй туурийг хэлж байгаа нь илхэн байна.

Хангай уулын орчим Хүнүгийн хот байсан тухай бас нэгэн баримт бий. МЭӨ 90 онд Хятадын Хан улсын Уди хаан Хүннү гүрнийг бут цохихоор шийдэж Ли Гуан Ли жанжинд 70 мянган морьт цэрэг, 100 мянган явган цэрэг захируулан умар зүг 3 зам хуваан давшуулжээ. Хүннүгийн шинэ шаньюй Хулугу ч Хан улсын довтолгоог сөрөн зогсохоор улс гүрнийхээ өнцөг булан бүрээс цэрэг татан цуглуулж, дайнд бэлджээ. Хятадын цэрэг амжилт олсонгүй, Хүннү нарт цохигдоод ухран зугтжээ. Энэ үед Ли Гуан Лигийн гэр бүл хараал хийсэн хэрэгт холбогдон баригдаад цаазаар авахуулах болж байгаа тухай мэдээ жанжны цэргийн хороонд хүрч иржээ. Үүний улмаас Ли Гуан Ли өөрөө ч бас алагдах, цөлөгдөх мэтийн хүнд ялд холбогдон шийтгүүлэх болсон учир Хүннү нарыг бут цохин гавьяа байгуулах замаар ялаас мултрахын тулд Туул голын орчим Ли Гуан Ли бүх цэргээ хөдөлгөн Хүннүгийн 20 мянган цэрэгтэй байлдаж, давуу хүчээр ялж ухраасан байна. Цааш давшин Янь Жань Шань буюу Хангайн нуруунд хүрч очтол түүний цэргийн жанжин нар нь Ли Гуан Лиг барьж хааны ордонд хүргүүлэхээр шийдсэн байдаг [12, 351]. Ингэснээр энэ удаагийн довтолгоон бүтэлтгүйтжээ.

Хятадын их цэрэг Хангайн уулын зүг зүгээр нэг давшаагүй нь мэдээж бөгөөд Хүннүгийн чухал түшиц газрын нэг мөн тул тийнхүү довтлохыг хичээсэн байж таарна. Энэ мэдээ Монгол орны баруун бүс нутагт Хүннүгийн нэгэн хот байж тэр нь цэрэг, улс төр, эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой газар байсан болохыг илтгэж байна.

Түүнчлэн археологич Д.Эрдэнэбаатар Хангайн нурууны баруун бие Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул сумдын нутгийн зааг Гол мод хэмээх газар Хүннүгийн язгууртны булш байх магадлал тун өндөр болох тухай өгүүлсэн нь бий [33, 25].

Хожмын түүхийн улбаанаас авч үзвэл, Сяньби улсын Үсэн аймгийн толгойлогчийн өргөө Хангай уулын хавьд байсан тухай бичсэн зүйл бий боловч чухам хаана гэдэг нь тун тодохойгүй.

Харин 1225 онд Монгол нутгаар аялан явж Чингис хаантай уулзсан Чан Чунь бомбо Улиастай хотод саатсан мэдээ бий. Тус тэмдэглэлд,

“... Хангай уулын хавилцаа нэгэн эртний үлдэгдэл хот байх нь Улиас хэмээн нэрийдмүй. Хотоос баруун урагш хорь гаруй газар элсэн манхан буй. Улиас хот орчмоос урагш, тав зургаан өдрийн газар нэгэн цаст уулын ард Чингай балгас байна.” [32, 9]

хэмээн бичжээ.

Энд гарч буй Хангай уулын хавилцаа, түүнээс урагш элсэн манхан хэмээх нь монгол элсний зүүн биеийг хэлсэн байж магадгүй хэмээн [34, 52] доктор Ж.Гэрэлбадрах бичжээ. Мөн энд гарч буй Чингай балгасан нь одоогийн

Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутаг Завхан голын өмнөд эрэг дээр буй тариалангийн үлдэц бүхий туурь, цаст уул нь Хасаг жаргалант уул болно.

Чан Чунь бомбо юуны учир тэрхүү “Улиас” нэртэй эртний үлдэгдэл хото-ор дайран гарах болов, мөн түүгээр баримжаалан тэр бүс нутгийн байдлыг тодорхойлон бичив гэдэг нь бас сонин. Бидний санахад монголын төв нутгаас баруун бүс нутагт зорчиход заавал дайран өнгөрөх нэгэн суурин нь “Улиас” суурин байж, тэр газар хэсэг зуур үдлэн замын тэмдэглэл бичсэн учир тэрхүү газраар баримжаалсан хэрэг гэж үзнэ.

Нөгөөтэйгүүр 1225 онд Чан Чунь бомбо “Улиас нэртэй хотын үлдэгдэл” гэж бичсэнээс харахад нэлээд эрт үүсгэгдсэн болох нь илхэн.

Рашид-ад-дин фузуллах “Судрын чуулган” хэмээх бүтээлд мөн XIV зууны эхэн үед Улиастайн газар суурин байсныг илтгэх мэдээ гарч байна. Үүнд,

“... Аригбөх Хубилай хаан ахдаа очин, өршөөлийг эрэн, улмаар үймээн самууны түймэр унтрахад тэрбээр бүх эхнэр, Ябуган, Малигтөмөр, Найрбуха, Тамачи гэсэн дөрвөн хөвгүүнээ орхиод, нутагтаа иржүхүй. Зуслан нь Улиастай, өвөлжөө нь нь Урианхат, Хиргисийн нутагт байдаг. Эдгээрийн хоорондох зай нь гурван өдөрчийн газар бөлгөө. Сорхагтани бэхич энд байвай.” [32, 10] гэсэн байна.

Энэ мэдээнээс хойш буюу XIII зууны дунд үеэс XVI зууны сүүл үе хүртэлх түүхийн судалгаанд Хангай уулын ар бие, Чигэстэй голын сав газар хот, суурин байсан тухай мэдээ одоогийн байдлаар тааралдахгүй байна.

Батмөнх Даян хааны отгон хөвгүүн Гэрсэнз жалайрын хунтайж, түүний 7 хөвгүүний ахмад нь болох Ашихайн орд өргөө Хангай ууланд байсан нь тодорхой мэдэгдэнэ. Чухам хаана байсныг нь тодорхойлоход бэрхтэй. Гэвч хожмын үйл явдлаас харахад өнөөгийн Улиастай хотын орчим байсан нь мэдэгдэнэ. Ашихайн ахмад хөвгүүн Баяндара, түүний хөвгүүн Лайхур хан цол хүртсэн анхны Засагт хан. Түүний удмын Засагт хангуудын өргөө нь мөн л Хангай уулын ар биед байж. “Илтгэл шаштир”-т үүнтэй холбоотой 2 мэдээ байна. Эхнийх нь, 1689 онд Ойрадын Галдан бошгот Халхад довтлон орохдоо Хангай уулын газар хүрсний дараа Засагт хан Цэнгүнжав, Сартуул Сэцэн засаг Саран ахай нар харьяат аймгийг аван өмнөд монголын Урад аймгийн нутгийн захад орсон мэдээ буй. Харин нөгөө нь, Галдангийн тэмцэл дарагдсаны дараа 1696 онд уул нутагтаа ирж Хангайн ууланд өргөөлөх үед тус өргөөтэй нь холбоотойгоор Чигисүн хэмээх голын нэр гарч буй [9, 73-74].

Энэ хоёр мэдээг харгуулан үзвэл, Засагт хангууд өргөөгөө Улиас нэрт эртний суурин газрын орчим байгуулж түүгээр төвлөрч байсан нь мэдэгдэж байна.

Харин 1725 оны үест, Засагт ханд харьяалагдаж байсан Хангайн уулын ар бие, Чигистэй голын сав газар шинэ тутам байгуулагдсан Сайн ноён аймгийн нутагт багтах болж, харин Засагт ханы орд өргөө өнөөгийн Говь-Алтай аймгийн нутаг Тайширын газар шилжжээ.

Бид энэхүү судалгааныхаа төгсгөлд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд,

1. Завхан аймгийн нийгэм, улс төрийн төв Улиастай хот бол эртний түүхтэй цөөн хэдэн хотын нэг мөн болно. Өмнөх түүх бичлэгт Улиастай хотын түүхийг 1733 онд Манж Чин гүрний эрх баригсадын байгуулсан Сангийн хотоор эхлүүлэн үздэг байсан. Гэтэл түүхэн сурвалжийн мэдээ болох археологийн тандалт судалгаа нь XIII зуунд Улиастайд суурин байсныг гэрчлэхийн дээр хятад сурвалжийн мэдээ Хүннү гүрний үед Жао Синь хэмээх хот Улиастайд байсныг гэрчилж байна. Чингэхээр Улиастайд Хүннү гүрний үеэс хот байгуулж түүхэн үе тус бүр суурин хот байсан нь мэдэгдэнэ.

2. Бидний хийсэн археологийн гүймэг судалгаа болон, түүхэн сурвалжийн мэдээ нь Улиастай хотын түүхийг Хүннү гүрний үеэс эхлүүлэн үзэхэд хүргэж байна. Энэхүү судалгаагаа улам бүр баримтжуулахын тулд Улиастайн хуучин хотын туурьд археологийн суурин судалгааны ажил зохион байгуулж, малтлага хийх нь тун чухал байна.

Монгол улсын түүхнээ нэгэн цагт нийслэл хот хэмээн бичигдэж асан Улиастай нь археологи, угсаатан судлал, түүх судлалын хувьд асар баялаг түүхтэй эртнээс уламжлан ирсэн цөөн тоот хотын нэг юм. Энэ утгаараа тус хотын түүхийг олон талаас нь нарийвчлан судлах шаардлага улам бүр урган гарч байна.

НОМ ЗҮЙ

[1] Батсайхан.З “Хүннү” УБ., 2002.

[2] Батсайхан.З, Цэвээндорж.Д, Төрбат.Ц “Хүннүгийн хот суурины асуудалд” УБ., 1994. -//”ШУА-ийн мэдээ” сэтгүүл № 3-4. Тал 77-85.

[3] Бат-Эрдэнэ.О, Баярсайхан.Д нар “Улиастай хот” (Зурагт түүх) УБ., 2013.

[4] “БНМАУ-ын түүх” УБ., 1966. Тэргүүн боть.

[5] Галдан туслагч “Эрдэнийн эрих хэмээх түүх болой” УБ., 2010. Эрдэм шинжилгээний удиртгал, хөрвүүлэг, тайлбар бичсэн Дуутан Ж.Гэрэлбадрах.

[6] Дамдинсүрэн.А “Монгол мөнгө” УБ., 1975.

[7] Доржсүрэн.Ц “Умард Хүннү” УБ., 1955.

[8] Доржсүрэн.Ц “Хүннүгийн шинэ суурин” УБ., 1966. -//”ШУА-ийн мэдээ” № 1.

[9] “Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шаштир” УБ., 2009. Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Д.Баржав, Н.Ганбат. II боть.

[10] Идшинноров.С “Хүннүгийн нийслэл хаана байсан бэ?” УБ., 2000. -//”Зууны мэдээ сонин” 10-р сарын 17-ны дугаар.

[11] Майдар.Д “Монголын хот тосгоны гурван зураг” (Эрт, дундад үе, XX зууны эх) УБ., 1970.

- [12] “Монгол улсын түүх” УБ., 2003. Тэргүүн боть.
- [13] Морохаси.Т “Большой китайско-японский словарь в 12 томах и приложения в одном томе” Токио, 1955 – 1960.
- [14] Наваан.Д “Хүннүгийн өв соёл” УБ., 1999.
- [15] Намжил.Т “Хүннүгийн үеийн хот барилгын конструкцийн зарим асуудал” УБ., 1977. -//”Археологийн судлал” сэтгүүл.
- [16] Очир.А нар “Хар бух балгас ба Туул голын сав дахь Хятаны үеийн хот суурингууд” УБ., 2005.
- [17] Очир.А нар “Чинтолгой балгасны судалгаа” УБ., 2008.
- [18] Пүрэв.О, Дамба.С “Хүннү улс” УБ., 1994.
- [19] Пэрлээ.Х “Хүн нарын гурван хэрмийн үлдэц” УБ., 1957.
- [20] Пэрлээ.Х “Монгол ард улсын эрт дундад үеийн хот суурины товчоон” УБ., 1961.
- [21] Пэрлээ.Х “Хүн улсын тухай” УБ., 1957.
- [22] Саруул.И “Хүннү улсын нутаг дэвсгэр, хил хязгаар, харуул хамгаалалт” УБ., 2004.
- [23] Сүхбаатар.Г “Монголчуудын эртний өвөг” УБ., 1981.
- [24] Таскин.В.С “Материалы по истории Сюнну” М., 1968.
- [25] Төрбат.Ц “Хүннүгийн жирийн иргэдийн булш” УБ., 2004.
- [26] “Хүннүгийн түүх, соёл” УБ., 2011.
XX зууны эхэн үе дэх шинэ дэг журам бүхий нийгэмт Монгол улсад шинжлэх ухааны нэгдсэн зохион байгуулалт бүхий байгууллага болох «Судар бичгийн хүрээлэн»-г үүсгэн байгуулсан нь Монголчуудын сэтгэлгээ, оюун санаанд томоохон хувьсал хийсэн үйл явдал болов. Нийгэм тэр чигтээ уламжлалт буддын шашны үзэл суртахуунаар хүмүүжиж, олон зууныг өнгөрүүлсэн Монголчуудын хувьд орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгийг таниулах зорилго бүхий энэхүү нэгдсэн зохион байгуулалт буюу өнөөгийн институтын үүслийг тавьсан нь шинэ үзэгдэл болов. Энэхүү Судар бичгийн хүрээлэн байгуулагдсанаар өнөөгийн Шинжлэх ухааны академийн суурь тавигдсан бөгөөд түүнийг дагалдан Монгол улсад угсаатан судлалын шинжлэх ухаан үүсэж, хөгжих эхлэл тавигдсан гэж хэлж болно. Монгол улсад угсаатан судлалын ухааныг анхлан хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн хүн бол Судар бичгийн хүрээлэнг байгуулах санаачлагыг гаргаж, өөрөө анхны Эрдэмтэн нарийн бичгийн даргыг 1921-1932 онд хийж байсан Жамсрангийн Цэвээн (Цэвээн Жамсрано) юм. Тэрээр 1910-аад оноос эхлэн Монгол болон Оросын зарим бүс нутгуудад хээрийн судалгаа хийж, угсаатны зүйн баримт сэлтүүд цуглуулж байсан нь хожмын Монголын угсаатан судлаач болон бусад мэргэжлийн судлаачдад чухал гарын авлага, эх хэрэглэгдэхүүн болжээ.

XX зууны дунд үеэс Монгол улсад эрчимжиж эхэлсэн “Шинэ соёл бүтээх” нийгмийн их аян хийгээд тухайн үеийн улс төр, нам засгийн бодлогоор тус улсад угсаатны зүйн судалгаа эрчимжиж, гадаадын олон арван судлаачдаас

бүрдсэн судалгааны баг ирж хээрийн судалгаа хийж тодорхой нэг асуудлын талаар системтэйгээр судалгаа хийж байв. Энэ мэт асуудлууд нь Монгол улсад Угсаатан судлалын шинжлэх ухааныг тодорхой зорилго, үүргийн хүрээнд хөгжүүлэхэд ихээхэн түлхэц үзүүлж байсан хүч болж байсан нь мэдээж. Тийм ч учраас 1950-аад он гэхэд ШУА-ийн Түүхийн хүрээлэнд Археологи-Угсаатны зүйн секторыг байгуулж, гадаад улсад энэ мэргэжлийн чиглэлээр эрдмийн цол зэрэгтэй болоод ирсэн шинэ залуу судлаачид өөрсдөө бие даан монголчуудын угсаа гарвал, соёлын өвийн уламжлал, шинэчлэлийн судалгаа хийж эхэлсэн нь Монгол дахь угсаатан судлалын шинжлэх ухааны хөгжлийн нэгэн шинэ үеийг нээсэн чухал үйл явдал болсон байна.

Өгүүлэн буй 1950-аад оны сүүл үед Монголд угсаатан судлалын мэргэжлээр үндэсний судлаачид шинээр төрөн гарах болж, энэ хирээр судалгааны арга зүй улам бүр нарийвчлагдан боловсруулагдаж, судалгаа, эрдэм шинжилгээний чадвар, чадамжийн хувьд томоохон дэвшил болохуйц түвшинд хүрсэн явдал нь Угсаатан судлалын шинжлэх ухаан цаашид улам бүр хөгжих үндэс суурь нь болсон гэж хэлж болох юм. Энэ үеэс монгол угсаатны бүлгүүдийн судалгааг эрчимтэй хийх болж, тэдний эд өлгийн болон оюун сэтгэлгээний түүхэн уламжлалыг аль болох угсаа гарвал, ураг төрлийн талаас нь анхааран судалж, зохих үр дүнгүүдийг гаргасаар байв. Жишээ нь С.Бадамхатан Дархад, Түрэг хэлтэн Уйгар-цаатангуудын талаар нэгэн сэдэвт бүтээлүүдийг [2; 3] хэвлүүлэн олны хүртээл болгосон нь түүний дараа их сургууль төгсөж ирсэн мэргэжлийн угсаатан судлаач, эрдэмтдийн судалгааны чиглэлд ч багагүй нөлөө үзүүлж байв. Монголын угсаатан судлаачдын судалгааны үндсэн нэг чиглэл нь Монгол улсын Монголчуудын угсаа гарал, өв соёлын тухай асуудлыг угсаатны зүйн үүднээс хэрхэн томьёолж судалдаг аргачлалын хэмжээнд авч үзсэн эрдэм шинжилгээний ач холбогдлоос нь үүдэн монгол овогтны угсаа гарвалын тухай асуудалд гадаад, дотоодын бусад судлаачид анхаарлаа хандуулах явдал өргөжиж байжээ.

1950-аад оноос хойш Монгол улс социалист дэглэмд шилжсэн нь Монголын угсаатан судлаачдын судалгааны чиглэл, үзэл баримтлал, судалгааны үр дүнд багагүй нөлөө үзүүлж байв. Тухайн үеийн нийгэм-эдийн засгийн шинэ тутам боловсруулагдаж байсан томоохон зорилт, зорилгын хүрээнд тухайн үеийн Монголын нийгэм, угсаатны үйл явц, «социалист аж төрөх ёс» буюу орчин үеийн «социалист Монгол үндэстэн»-г судлах нь Монголын угсаатан судлаачдын томоохон зорилт болж байв. Энэхүү зорилгын хүрээнд Монгол дахь нэгдэлжих хөдөлгөөн, түүний дараах нэгдэлчдийн амьдрал ахуй, эдийн засгийн талаарх судалгааг эрчимтэй явуулж, зохих үр дүнгүүд ч гарсаар байв [4; 5].

Тухайн үед нүүдэл соёл, зан заншлыг улируулан авч үзэхээсээ илүү тухайн үеийн малчдын амьдралын бодит нөхцөл байдалд тулгуурлан тэмдэглэж түүхэн цаг үеийг тодотгож байсан явдал, соёлын хүн судлалын эхлэл байжээ хэмээн ойлгох боломжтой ба судалгааны арга зүйн хувьд амьдралын

бодит байдлыг эх материалд тулгуурлах хандлага зонхилж, хэзээ ч үнэ цэнээ алдахгүй угсаа-соёлын баримт болон үлдэж байгаа нь судалгааны бүтээлүүдээс тодорхой байна. Монголын угсаатны судалгааны үндсэн чиглэл нь нэгд, монгол угсаатны “нийтлэг” бүлгүүдийн ахуй байдал, аж амьдралын хэв маягийг судалж, түүнээсээ улируулан уламжлалыг олж мэдэх, хоёрт, ард түмний дунд өрнөж байгаа соёлын өөрчлөлт, ялангуяа үндэсний агуулгатай соёлын үүсэн тогтож буй учир шалтгааныг тодруулахыг чухалчилж, тухайлбал мал аж ахуй, нүүдэллэх журам, хот айл, орон сууц, хоол унд, цагаан идээ, хувцас болон гэрлэлт, сүсэг бишрэл, гар урлал, ардын мэдлэг зэрэг асуудлаар угсаатны зүйн системтэй судалгаа явагдаж байв. Энэ нь 1976 онд хуралдсан МАХН-ын XVII их хурлаас дэвшүүлсэн социалист аж төрөх ёсыг хэвшүүлэх талын заалттай уялдуулан нийгмийн хөгжил нэгдэлч малчдын аж амьдралд хэрхэн нөлөөлж, шинэ үеийн ахуй бүрэлдэн тогтож буй үйл явцыг судлах оролдлого хийгдэж хэд хэдэн нэгэн сэдэвт бүтээлүүд нийтлэгдэж [4; 5; 6], малчдын мал маллагааны уламжлалт арга, нүүдлийн хэлбэрийг хангай, тал хээр, говийн бүсээр судалж, нийтлэг болон өвөрмөц онцлогийг тодруулж харьцуулан дүгнэх, тэрчлэн өрх гэр, гэр бүлийн асуудал бол угсаатны зүйн ухааны үндсэн сэдвийн нэг болох учир түүний шинж төрхөөр тухайн хөгжлийн түвшин илэрхийлэгддэг хэмээн ойлгож, тухайн хөгжлийн тусгал болохуйц аж төрөх ёсыг хэвшүүлэх, шинэ хүнийг төлөвшүүлэх гэх мэт үзэл суртал хүмүүжлийн асуудлыг хэрэгжүүлэх ач холбогдолтойг харгалзан монгол гэр ахуйн хүрээнд хамрагдах гол гол сэдвийг хөндөж, урьд өмнө төдийлөн судлагдаж шийдэгдээгүй сэдвүүдийг судалгааны хэрэглэгдэхүүнд үндэслэн сэдэж тавьж байв. Мөн тухайн үеийн нийгмийн амьдралд шинэ баяр ёслол төлөвшиж, улмаар хэв заншил бүрэлдэн тогтож буй явцыг түүхчлэн угсаанйгэм судлалын талаас эрдэм шинжилгээний нэлээд өгүүлэл, нэгэн сэдэвт бүтээлүүд хэвлэгдсэн нь Монголын угсаатны зүйн ухааны салбарт гарсан шинэлэг судалгаа болж байсан нь мэдээж [7].

«Социалист аж төрөх ёс» гэх судалгааны шинэ чиглэл, зорилготой ажиллах болсон нь үндсэндээ Монголын нийгмийн бүтэц, малчдын амьдралын орчин нөхцлийг шинээр бүтээх, нэг ёсондоо шинэ нийгмийг дахин бүтээхэд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Тийм ч учраас Монголд XX зууны дунд үеэс өрнөж асан нийгэм-соёлын томоохон өөрчлөн байгуулалт, хөдөөгийн малчдыг «Нэгдэл» гэх нэгдсэн зохион байгуулалтад оруулж, шинэ цагийн «соёлжсон» монгол малчин өрх, малчин иргэнийг бий болгоход тухайн үеийн угсаатан судлаачдын үүрэг үлэмжхэн байв. Монголд 1960-аад оноос хойш нийгэм-улс төрийн «шинэ эргэлт» бий болж эхэлсэн бөгөөд энэхүү улс төрийн их өөрчлөлтийн эхлэл угсаатан судлалын шинжлэх ухааны хөгжилд ч багагүй нөлөө үзүүлж байсан нь дээрх он жилүүд дэх угсаатны зүйн хээрийн судалгааны үр дүнгүүдээс харагдана. XX зууны хагас хүртэлх хугацаанд Монголын угсаатны зүй, угсаа-соёлын асуудлыг ихэвчлэн Монголын түүхчид болон Монгол хэл-соёлын салбарын эрдэмтдийн үндсэн судалгаанд хавсарга шинжтэй явж

ирсэн нь ажиглагддаг. Тухайн үед угсаатны мэргэжлийн судлаачдыг зөвхөн ЗХУ-д бэлтгэдэг байсан нь судлаачдын тоо харьцангуй цөөн байхад нөлөөлж байжээ. 1960-аад оны эхэн үеэс эхлэн Монгол улсаас ЗХУ-ын томоохон их дээд сургуулиудад угсаатны зүйч мэргэжлээр хэд хэдэн хүн суралцаж төгсөн Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнд угсаатны зүйч мэргэжлээр ажиллах болсон нь Монгол улсад энэ чиглэлийн судалгааг эрчимжүүлэх гол түлхэх хүч нь болжээ. Мөн Монгол улсад мэргэжлийн угсаатан судлалын ухааны үндэс суурь тавигдахад Монголчуудын удам угсаа буюу ураг төрлийн систем, сурвалж бичгүүд, XX зууны эхэн ер хүртэлх Монголчуудын ахуй амьдрал, ёс заншил зэрэгт хамаарах үнэт мэдээ баримтуудыг агуулж асан гадны улсуудын жуулчид, аялагчдын тэмдэглэлүүд, судлаачдын бичиж, тэмдэглэж үлдээсэн зүйлс, гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээлүүд ихээхэн үүрэгтэй байсныг өгүүлэх нь зүйн хэрэг. XX зууны дунд үед зөвхөн Монголд гэлтгүй дэлхий дахинаа нийгмийн шинжлэх ухааны салбарт хүч түрэн орж ирсэн нэгэн салбар бол яах аргагүй угсаатан судлалын шинжлэх ухааны салбар байсан бөгөөд өөрийн гэсэн судалгааны арга зүй, судлагдахуун болсон объект, онол үзэл баримтлалаа тодорхойлж чадсан юм. Хэдийгээр тухайн үеийн угсаатан судлалын шинжлэх ухааны салбарын онол үзэл баримтлал дийлэнхдээ формацийн онол, арга зүйн хүрээнд багтаж байсан хэдий боловч судалгааны чиглэл нь аливаа угсаатан-ард түмэн, түүний өнгөрсөн түүхэнд бий болгож чадсан соёлын олон асуудлыг анхаарч байсан нь өрнө, дорны олон эрдэмтдийн онол арга, зүй, үзэл баримтлалыг чиглүүлж байв. Энэхүү үзэл баримтлал, онол арга зүйн чиг баримжаа Монголын угсаатан судлалын судалгаанд ч өөрийн нөлөөг үзүүлж байсан нь гарцаагүй. Хэдий тийм боловч шинэ тутам шинжлэх ухаанжсан орчин үеийн нийгмийг бүтээн байгуулж асан Монгол улсын хувьд энэ асуудал тийм ч ноцтой гэж хэлэх асуудал биш байсан нь мэдээж хэрэг биз ээ.

Монгол улсад угсаатан судлалын салбар мэргэжлийн судлаачдын хүч, оролцоотойгоор 1950-аад оны дунд үеэс илүү системтэйгээр хөгжиж эхэлсэн билээ. Бидний харж буйгаар Монгол дахь угсаатан судлалын салбар мэргэжлийн түвшинд хөгжихдөө дор дурдсан үндсэн чиглэлүүдийг үндсэн чиглэл болгон хөгжсөн мэт.

Монголчуудын угсаа гарвалын судалгааг овог (ястан буюу угсаатны бүлэг)-ийн судалгаагаар дамжуулан судлах буюу нэг үгээр хэлбэл Монголчууд гэж хэн болох тал дээр угсаатан судлалын судалгааны нэгдсэн үр дүнд хүрэх

Шинэ Монгол улс буюу социалист монгол үндэстний амьдралын хэв маяг, дэг ёсыг бүрдүүлэхийн тулд хөдөөгийн нэгдлийн системийн жишээг сонгон авч, түүнд хийсэн судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх

Үүнд тухайн үеийн төрийн бодлого, чиглэл ч багагүй нөлөө үзүүлсэн нь дамжиггүй.

1959 онд МАХН-аас нэгдэлжих хөдөлгөөний бүрэн ялалт болоод нийгмийн өөрчлөлт нь улс оронд хэрхэн нөлөөлж байгааг социалист хүн, шинэ

нийгмийн хүн болж буйг судлах даалгаврыг Шинжлэх ухааны Академийн угсаатны зүйч, эрдэмтдэд өгсөн байдаг. Тийм ч учраас Монголын угсаатны зүйчид 1960-1980-аад он хүртэлх 10 гаруй жилийн хугацаанд Монголын хөдөөгийн малчид, тэр дундаа нэгдэлч малчдын амьдралын хэв маяг, шинэ дэг ёсыг судлах ажлыг голлон хийсэн ажээ. Монголын угсаатны зүйчдийн эдгээр он жилүүдэд хийсэн угсаатны зүйн судалгаа нь зөвхөн тухайн үеийн нам засгийн шийдвэрийг «ёсчлон» биелүүлж, намын захиалгаар нийгэм журмыг магтан дуулж судалгаа хийсэнгүй. Тэд нэг ёсондоо Монголын нийгмийн үйл явцыг судалж байсан нь өнөө үед давтагдашгүй өв болжээ [8, 218].

XX зууны дунд үеэс эрчимтэй хөгжсөн Монголын угсаатан судлалын салбарын судлаачид Монголы Халх угсаатны бүлгийг голлон судалж, халхуудын дунд хээрийн судалгаагаа ч хийж байв. Жишээ нь Г.Цэрэнханд Монголын төв хэсэг болох Архангай, Өвөрхангай аймгуудад, С.Бадамхатан 1960-аад оны эхэн үеэс Халхад хээрийн судалгаа хийж, Төв, Дундговь, Дорноговь аймгуудад хээрийн судалгаа хийж байв. Мөн түүнээс гадна зөвхөн угсаатны зүйчид ч бус Монголын түүх судлаачид ч энэ асуудалд анхаарал хандуулж, хэд хэдэн томоохон бүтээлүүдийг олны хүртээл болгосон байдаг. Монголын угсаатан судлаачид ийн халхуудын дунд угсаатны судалгаа хийх болсоноор социалист Монгол буюу шинэ цагийн социалист үндэстэнг бүтээн байгуулах томоохон ажлын нэг хэсэг нь болж байсан гэлтэй. Өөрөөр хэлбэл ЗХУ-ын томоохон эрдэмтдийн үзэл, онолын чиг баримтлалыг иш болгон Монгол дахь «угсаатны үйл явц»-ыг халхуудын дунд хийсэн судалгааны үр дүнгээр тодруулах ажлыг хийж байв [8, 218]. 1980-аад оны эхэн үед ШУА-ийн Түүхийн хүрээлэнд шинээр сургуулиа төгсөж ирсэн угсаатны зүйчид ч энэ ажлын хүрээнд Монголын угсаатны зүй 3-н боть бүтээлд оролцож, хамгийн эхэлж 1987 онд Халхын угсаатны зүйн бүтээлийг хэвлэн нийтлүүлжээ. С. Бадамхатан ч нэгдүгээр ботийн удиртгал хэсэгт өөрийн санааг өгүүлэхдээ «Халх ястан нь Монгол олон овогтон, угсаатны нэг гол хэсэг, Монголын ард түмний түүхэнд, ялангуяа XIV зууны хоёрдугаар хагас үеэс феодалын нийгмийн үеийн олон монгол ястан бүрэлдэн тогтох үйл явцад онцгой байр суурь гүйцэтгэж ирсэн ба Халх ястны соёл нь нийт монгол овогтны соёлын цогцолборын нийллэг, гол мөхлөг нь тул Халх угсаатны зүйг судлах учир холбогдол үүнд оршино» гэж үзсэн байна [9, 35].

Монгол дахь угсаатан судлалын салбарын шинжлэх ухааны түүхээс харахад XX зууны бараг төгсгөл үе хүртэл дотооддоо үндэсний мэргэжилтэн бэлтгэж гаргаагүй байдаг. Магадгүй энэ нь түүхэн цаг хугацаа болоод бусад олон янзын шалтгаанаас хамаардаг байсан биз ээ. XX зууны бараг ихэнх хугацаанд Монголын угсаатан судлалын мэргэжлийн судлаачдыг зөвхөн ЗХУ-д (тухайн үеийн нэрээр) бэлтгэдэг байсан нь судлаачдын тоо харьцангуй цөөн байхад нөлөөлж байжээ. “Шинэ хийгээд хуучин соёлын харьцаа, ардын соёлын уламжлал шинэчлэл, ардын ёс, зан заншлын талаарх боловсролыг зөвхөн МУИС-ийн хүрээнд жишээлэхэд Нийгэм, улс төрийн ажлын

факультетын /НУТАФ/ сургалтын хүрээнд олгож байв. 1989 онд МУИС-ийн Хэл Бичгийн Факультетэд МУИС-д суралцаж байгаад гадаадын оюутан судлаачдад Монголын соёл, ёс заншлыг танилцуулах, судалгаа хийх зорилгоор “Монгол судлалын лаборатори” хэмээх эрдэм шинжилгээний байгууллага байгуулжээ. Энэ лабораторид Монголын нэрт угсаатны зүйч эрдэмтэн Х. Нямбуу ажиллаж байлаа.

1990-ээд оны эхэн үеэс МУИС-д тодорхой хэмжээний бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орж, түүнд хамааралтай зарим сургууль, тэнхимийн бүтэц ч мөн өөрчлөгдөж эхэлжээ. Түүний нэг жишээ болох “Монгол судлалын лаборатори”-ийг тухайн үеийн Нийгмийн ухааны факультетэд шилжүүлж 1991 оноос “Нийгмийн судалгааны төв”, 1993 оноос “Угсаатны зүйн судалгааны төв” хэмээн нэрлэжээ. Энэ төвийн үйл ажиллагаа, судалгаа нь монголчуудын нийгэм-соёлын өөрчлөлт, угсаатны гарвал, соёлын асуудлаар судалгаа шинжилгээ хийх явдал байлаа. Тус төвийн эрхлэгчээр Монгол хэл уран зохиолын үндсэн мэргэжилтэй доктор Хандын Нямбуу захирлаар ажиллаж байв. 1992 оноос доктор Х.Нямбуугийн удирдлагын дор эх орондоо угсаатны зүйн үндэсний мэргэжилтэн бэлтгэх бэлтгэл ажилд орж 1994 оны 01-р сарын 18-ны өдрийн 32 тоот тушаалаар “Эртний судлал-Угсаатны зүйн тэнхим” болон өргөжжээ. Тэнхим байгуулагдсанаар 1995 оны хичээлийн жилээс “угсаатны зүйч-түүхийн багш” мэргэжлээр элсэлт аван (түүхийн ангиас сонгон авч) сургалт явуулан 1997 онд анхны угсаатны зүйч үндэсний анхын мэргэжилтнүүдийг төгсгөж эхэлжээ” [10, 35]. Хэдийгээр уг тэнхимын үндсэн төлөвлөгөө, үйл ажиллагаа Оросын их дээд сургуулийн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу явагдаж байсан хэдий боловч Монголчуудын уламжлалт соёл, угсаа гарвал, аж ахуйн чиглэлээр хичээлүүдийг шинээр нэмж оруулсанаараа ач холбогдолтой болсон ажээ.

1998 оноос дэлхий дахины шинжлэх ухааны болон сургалтын чиг хандлагатай уялдуулан доктор Г.Цэрэнхандын удирдлагаар тэнхимийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж тэнхимийг “Угсаатан судлалын тэнхим” болгон өөрчилж “угсаатан судлаач” мэргэжлээр үндэсний мэргэжилтэн бэлтгэн гаргах болжээ. Энэ үеийн онцлог нь цаашид нийгэм-соёлын хүн судлаач бэлтгэх бэлтгэл үе болсон гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, “Угсаатан судлаач” бэлтгэх хөтөлбөрт тухайн үеийн Оросын шинжлэх ухаанд хийгдэж байсан өөрчлөлтүүдийг харгалзан тусгаж нийгэм-соёлын хүн судлалын чиг баримжаатайгаар боловсруулснаараа онцлогтой юм. XX зууны төгсгөл үед Монгол улсад угсаатан судлалын шинжлэх ухаан хөгжлийн шинэ шатанд гарсаныг МУИС-д үндэсний мэргэжилтнүүдийг бэлтгэж, түүний зэрэгцээ МУИС-ийн харъяа Ховд сургуульд угсаатан судлалын чиглэлээр тусгайлан хичээл зааж эхэлсэн зэрэг үйл явдлуудаас харж болно. Хэдийгээр Монгол улс нийгэм журамт улс төрийн дэглэмээс ардчилсан нийгэмд шилжих үеийн улс төр, эдийн засаг, нийгмийн эддрээт үед шинжлэх ухааны салбарт томоохон сорилт тулгарч байсан хэдий боловч энэ нөхцөл байдлыг даван туулж чадсан

цөөн шинжлэх ухааны салбарын нэг нь угсаатан судлалын шинжлэх ухаан байв. Монгол дахь Угсаатан судлалын ухааны түүхэн хөгжлийн үйл явцыг эгэн харахул дор дурдсан хөгжлийн зүй тогтол харагдана.

Монгол дахь угсаатан судлалын салбарын үүслийг Монгол нутгийн талаар, Монгол хүмүүсийн талаарх эрт үеийн түүхэн сурвалжууд үүн дотор Хүннү эзэнт гүрний үеийн төв азийн нүүдэлчдийн талаар бичиж тэмдэглэсэн Сыма Цяны “Түүхэн тэмдэглэл” түүний дараах XIII зууны Монголчуудын амьдралын орчин, нийгэм соёлын хэв шинж зэргийг хамгийн тодоор бичиж тэмдэглэсэн “Монголын нууц товчоон”, Рашид Ад Дины “Судрын чуулган” зэрэг сурвалжуудад гарч буй Монголчуудын амьдралын орчин нөхцөл, нийгмийн дэг журам уламжлалт соёлын элементүүдийн талаарх мэдээлэл нь үндсэндээ угсаатан судлалын ухааны томоохон эх сурвалж, баримт сэлтүүд болно. Энэ нь Монгол дахь угсаатан судлалын ухааны эхлэлийг тавьсан үндсэн суурь болно.

Монгол дахь угсаатан судлалын ухааны хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсэн, шинжлэх ухаан болгон хөгжүүлэх эхлэлийг тавьсан үе болох XX зууны эхэн үе буюу Монголын шинжлэх ухааны байгууллагын үүсэл болсон Судар бичгийн хүрээлэнд ажиллаж асан Ж.Цэвээн нарын үйл ажиллагаа болно. Энэ үеэс Монголчуудын дунд тусгайлан угсаатны зүйн хээрийн судалгааг тодорхой зорилго, системтэйгээр хийж зохих үр дүнгүүд гарч эхэлсэн нь цаашдын хөгжилд том үүрэг гүйцэтгэсэн үйл явдал болжээ.

XX зууны дунд үе, 1950-аад оны сүүл үеэс Монгол улсад угсаатан судлалын мэргэжлийн анхны судлаачид судалгаа хийж эхэлсэн нь угсаатан судлалын ухааны шинэ дэгийг бий болгох гол хөдөлгөгч хүч нь болж эхлэв. Энэ үед ЗСБНХУ-д угсаатан судлалын ухаанаар суралцан төгсөж ирсэн С.Бадамхатан, Г.Цэрэнханд, Г.Батнасан зэрэг мэргэжлийн судлаачид ажиллах болсон нь тус шинжлэх ухааны судалгааны чиг хандлага, онол үзэл баримтлалд томоохон өөрчлөлт орох үндэс болж, өнөөгийн Монголын угсаатан судлалын ухааны чиг хандлага бүрэлдэн тогтоход гол хөшүүрэг нь болжээ. Монгол улсын бараг бүх бүс нутгуудад хээрийн судалгааг системтэйгээр хийж, судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, бие даасан бүтээлүүд ар араасаа олны хүртээл болж эхэлсэн нь түүний үр дүн болов.

1990-ээд оноос өнөөг хүртэл угсаатан судлалын ухааны хөгжлийн чиг хандлага, судалгааны үндсэн чиглэл, үзэл баримтлалд барууны орнуудын судалгааны арга барилыг нэвтрүүлж, дэлхийн угсаатан судлал, нийгэм-соёлын хүн судлалын чиглэлээр суурь болон бусад судалгааг тогтмол хийж, Монгол улсад үндэсний мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах болов. Ингэснээр дэлхийн томоохон улс орнуудын судлаач, судалгааны байгууллага, их сургуулиудтай хамтарсан судалгааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн үндэсний болоод олон улсын бодлогын түвшинд судалгааны үр дүнгээ гаргах боломжийг бүрдүүлэх болжээ.

НОМ ЗҮЙ

- [1] Бадамхатан С. Халхын угсаатны зүй I. -Улаанбаатар, Улсын хэвлэлийн газар., 1987.
- [2] Бадамхатан С. Цаатан ардын аж байдал. -Улаанбаатар., 1962.
- [3] Бадамхатан С. Хөвсгөлийн Дархад ястан. -Улаанбаатар., 1965.
- [4] Батнасан Г. БНМАУ дахь нэгдэлчдийн аж ахуйгаа хөтлөх арга ажиллагаа. Этнографийн судалгаа. -Улаанбаатар., 1978.
- [5] Булаг Э. Монголын угсаатны зүйн үндэс. // Угсаатан судлал Tomus XX, Fasc-1-23. -Улаанбаатар, 2016.
- [6] Булаг Э. Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн (1960-1971). -Улаанбаатар: Admon printing., Уб., 2011.
- [7] Бямбадорж С. Монгол улсад угсаатан судлалын шинжлэх ухааны үндэсний мэргэжилтэн бэлдэж эхэлсэн нь. // Угсаатан судлал. Tomus XIII, Fasc-1-17. -Улаанбаатар , 2015.
- [8] Нямбуу Х. Өнөөгийн монгол ёс. -Улаанбаатар, 1976
- [9] Цэрэнханд Г. Нэгдэлч малчдын аж байдал. -Улаанбаатар, 1981.
- [10] Цэрэнханд Г. Хөдөө аж ахуйн нэгдэлч малчдын өрх гэр, гэр ахуй. -Улаанбаатар, 1972.

REFERENCES

- [1] Badamhatan S. Halhyn ugsaatny zyj I. -Ulaanbaatar, Ulsyn hjevljelijn gazar., 1987.
- [2] Badamhatan S. Caatan ardyn azh baïdal. -Ulaanbaatar., 1962.
- [3] Badamhatan S. Hөvsgөliin Darhad jastan. -Ulaanbaatar., 1965.
- [4] Batnasan G. BNMAU dah' njegdjelchdiin azh ahuigaa hөtlөh arga azhillagaa. Jetnografiin sudalgaa. -Ulaanbaatar., 1978.
- [5] Bulag Je. Mongolyn ugsaatny zьjn yndjes. // Ugsaatan sudlal Tomus XX, Fasc-1-23. -Ulaanbaatar, 2016.
- [6] Bulag Je. Mongolyn ugsaatny zьjn hjejerijn sudalgaany jeh hjerjegljejdjehьyn (1960-1971). -Ulaanbaatar: Admon printing., Ub., 2011.
- [7] Bjambadorzh S. Mongol ulsad ugsaatan sudlalyn shinzhljeh uhaany yndjesnii mjergjezhiltjen bjeldjezh jehjelsjen n'. // Ugsaatan sudlal. Tomus XIII, Fasc-1-17. -Ulaanbaatar , 2015.
- [8] Njambuu H. Өнөөгийн mongol ёс. -Ulaanbaatar, 1976
- [9] Cjerjenhand G. Njegdjelch malchdyn azh bajdal. -Ulaanbaatar, 1981.
- [10] Cjerjenhand G. Hөдөө azh ahuin njegdjelch malchdyn орh gjer, gjer ahuï. -Ulaanbaatar, 1972.

МРНТИ 03.91

УДК 39

УГСАА ЗАЛГАМЖИЛСАН ЗАСАГ НОЁДЫГ ЗАСАГ ДАРГА БОЛГОСОН НЬ

Н.Батболд

Улаанбаатар Их Сургуулийн докторант

E-mail: Batbold.onolt@gmail.com

Товчлол: Монгол дахь засаг захиргааны зохион байгуулалт нь өмнөх нийгмийн бэлгэдэл болж байсан язгууртан ноёдын нийгмийн байр суурийг ч өөрчлөх шалтгаан болж байв. Түүний нэг жишээ нь угсаа залгамжилсан ноёдыг дарга гэсэн байр суурьтай болгох үйл явц байв. Энэ нь нэг талаараа тэдний улс төрийн нөлөөг бууруулах ажлын эхлэл болж байв. Энэхүү үйл ажиллагааг явуулсанаар тэдний хөрөнгийг хураах, хэлмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлжээ.

Түлхүүр үг: Засаг ноёд, хошуу дарга, засаг дарга, засаг захиргааны өөрчлөлт

ҒТАМР 03.91

ЭОЖ 39

МҮРАГЕРЛІК ЗАСАГ НОЯНДАРЫН ӘКІМ БАСШЫ ЕТКЕНДІГІ

Н.Батболд

Ұлан-батыр университетінің докторанты

E-mail: Batbold.onolt@gmail.com

Түйін: Моңғолияның әкімшілік құрылымын жаңғыртуу бұрынғы қоғамның символы болған ақсүйек нояндардың әлеуметтік жағдайын да өзгертуге себеп болды. Оның бірі айғағы, мұрагерлік нояндардың бастық дәрежеге көтерілу процестері болды. Бір жағынан, бұл олардың саяси ықпалын төмендетуге бағытталған күш-жігерінің бастауы болды. Осылайша олардың мүлкін тәркілеуге және репрессияға ұшыратудың алғышарттары жасалған болатын.

Кілт сөздер: Засаг нояндар, хошуын бастығы, әкімдер, әкімшілік өзгерістер

IRSTI 03.91

UDC 39

APPOINTING PRINCES ARISTOCRATS AS LOCAL GOVERNERS

N. Batbold

Doctorant of University of Ulaanbaatar

E-mail: Batbold.onolt@gmail.com

Abstract: The changes of administrative system in Mongolia was also a reason to change the social position of the aristocracy, which had been a symbol of society in the past. One example was the process by which hereditary princes were promoted to the position of governor. On the one hand, this was the beginning of their efforts to reduce their political influence. This led to the confiscation and repression of their property.

It was changing the administration system that transformed hereditary nobles of the banner to elected governors. The process put the aristocrats of Golden lineage far away from their political and economic powers. It also created an unfavourable condition of blurring the Mongol origin. The nobles supported the People Government; therefore, they accepted the radical change and co-organized the new administration system. Due to their policy was to the continuous action of Mongol State. However, the reducing of aristocrats' power influenced their economic power badly and confiscated their property. Ultimately, the change made the hereditary nobles a victim of political persecution.

Keywords: governors, administrative change

1923 оны 1 дүгээр сарын байдлаар Монгол Улсад 120 хошуу, тэдгээрийг захирсан засаг ноёд хийгээд бүгдийн дарга нар байв. Монгол оронд Үндэсний ардчилсан хувьсгал явагдах үйл хэрэг, Ардын засгийн газар бэхжин тогтох, Ардын нам өргөжин тэлэхэд Сэцэн хан Д.Навааннэрэн, Хатанбаатар С.Магсаржав, Л.Сумъяа бэйс, Дөрвөд далай хан Г.Түмэндэлгэржав, Үнэн зоригт хан Н.Содномжамцой, Чин ачит ван Гончигдамба нарын олон засаг ноёд гар бие оролцсон байдаг.

Угсаа залгамжилсан засаг ноёдын эрх хэмжээг хязгаарлах үүднээс Ардын засгийн газраас 1923 оны 1 дүгээр сарын 5-нд “Монголын олон засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”-ийг батлан гаргажээ.

Энэхүү дүрэмд: “Халхын олон засаг ба засаг бус ван гүн, тайж нарыг энэхүү дүрмийн ёсоор тус бүр батлан агуулахаас гадна, олон засгийг цөм засаг дарга”¹ хэмээн нэрлээд аль нэгэн засаг дарга нь, ард олны санаанд үл нийлэлцэх буй аваас, харьяат хошууны хурлаар шүүмжлэн хэлэлцээд хууч-

¹ ТЕГ-ын Тусгай архив. Х-1, Д-1, ХН-149, т.4.

ныг устган, засаг дарга буюу хошууны даргыг сонгож, Засгийн газар мэдүүлэн батлуулахаар болгожээ.

Энэхүү дүрэм ёсоор угсаа залгамжилсан засаг ноёд засаг дарга болж, үе улиран сонгогдох асуудал нь хошууны хурлаар шийдвэрлэгдэх болсон байна. Энэ тухай мөн дүрэмд: “олон засаг дарга нарын дотроос, нас өтөлсөн буюу бие эмгэглэсэн учир, гуйн мэдүүлж, засаг даргын тушаалаас огцрох буюу бие барах аваас уул хэргэм зэргийг тухай бүр түүний үр хүүхдэд, болох зохихыг үзэж залгамжлуулахаас гадна, хэрэв насанд хүрсэн буюу хүрмэгц эрдэм чадал бий агаад, харьяат хошууны хурлаар зөвшөөрөн батлах бол засаг даргын тушаалыг мөн хамтатгаж болохоос гадна, гагцхүү засаг даргад батлахын нана ... хүнс хэрэглэлийг /хангамж/ хэнд ч олгож үл болно. Засаг дарга нар, орон гарсан хойно, хэрэв залгамжилбал зохих үр хүүхэдгүй нь буй аваас, түүний уул хэргэм зэргийг ойр төрлийн тайж нарт залгамжлуулж болно. Гагцхүү засаг даргын орыг харьяат хошууны хурлаар шүүмжлэн хэлэлцэж тайж ард гэж ялгаварлахгүй, насанд хүрсэн бөгөөд бичиг хэрэгт боловсронгуй, ард олны тусыг бодох шударга цэгц хүнийг сонгож, Засгийн газар батлуулан хошууны дарга тавивал зохино” гэж зааснаар тэдгээрийн эрх хэмжээг бүрэн хязгаарлаж, хошууны хурал буюу жирийн ардын мэдэлд шилжүүлсэн байна.

Улмаар 1923 оны 3 дугаар сард “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”-ийг баталж: “Бидний Монгол Улс нэгэнт ардын эрхтэй хэмжээт цаазат улсын засгийг байгуулсны тул, арван гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг, улсын засгийн газар хүртэл тус тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхын саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино” хэмээн тогтоосноор засаг дарга нарыг үе улируулан сонгуулахгүй байх арга хэмжээг бүрэн бататгажээ.

Гэвч нутгийн захиргааны дүрэм ёсоор хошуудын хурлыг байгуулах хүртэл засаг ноёд засаг дарга хэвээр байсан тул Ардын засгийн газраас орон нутгуудад нутгийн захиргааг шинээр байгуулах ажлыг явуулахаар Засгийн газрын төлөөлөгчийг явуулж, хошуудын хурлыг байгуулж, засаг дарга нарыг сонгох, Засгийн газраар батлуулах ажлыг гүйцэтгүүлжээ. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд “Хошуу, шавийн газар түр цагийн хурал байгуулах тухай”¹ дүрмийг батлан гаргаж, хошуудад төлөөлөгчдийг томилохдоо, хошуудын хуралд энгийн ардыг оруулах, тайж, ноёдыг оруулахгүй байх заавар өгчээ. Энэ нь засаг дарга болсон ноёдын эрх мэдлийг хязгаарлаж, улс төрийн хүрээллээс халахад чиглэгдэж байв.

Ингээд хошуудад Засгийн газрын төлөөлөгч нарыг томилон явуулжээ.

Үүнд: “Хан Хэнтий уулын аймгийн зүүн захын хошууд:

Манлай ван, Пунцагравдан, Ачит ван, Ялгуусны шавьд Чадрабал, Дуламсүрэн, Аюурзана нар,

¹ УТНОНББТ. Ф-4, Д-1. ХН-196. Т.1-10.

Эрхэмсэг бэйс, Илдэн хошуу, Үйзэн бэйсэд Сэвжид, Чойжинжав нар,
 Саруул гүн, Эрдэнэ гүн, Дархан хошой чин ваны хошуунд Гомбосүрэн,
 Банзрагч нар,

Хурц ван, Егүзэрийн шавь, Ёст бэйсэд Балжинням, Түдэв нар,
 Хантайшир уулын аймгийн хошууд:

Засагт хан, Номун хан хутагтын шавь, Жонон ванд түшмэл Эринжавыг
 туслахын хамт,

Илдэн засаг, Итгэмжит бэйл, Ёст засагт Ламжав, Товуудорж нар,
 Бишрэлт гүн, Үйзэн бэйс, Сүжигт гүнд Жамсранжав, Гунаажав нар,
 Дайчин ван, Дархан бэйл, Эрдэнэ бэйсд Мичиддорж, Ишванжил нар,
 Баатар ван, Сэцэн ванд Луузанжав, Сандуйжав нар,
 Ялгуусан хутагтын шавь, Цогтой ван, Жалханз хутагтын шавьд Дүгэржав,

Дагвацэнз нар,

Далай гүн, Ахай бэйл, Мэргэн засагт Цэсэнжав, Дожообаасум нар,
 Ачит ван, Зоригт ван, Дүүрэгч ванд Чимэд-Очир, Дамбалжир нар,
 Цэцэрлэг Мандалын аймгийн хошууд:

- Илдэн ван, Ахай бэйл, Үйзэн ванд Лхамсүрэн, Гиваанжав нар,

- Сайн ноён хан, Эрдэнэбандида хутагт, Дайчин ванд Гомбо, Цоодол, Лув-
 санцэрэн нар,

- Ёст бэйл, Эрдэнэ мэргэн ноён хутагт, Дархан гүнд Хорлоо, Даваасамбуу
 нар,

- Цогтой гүн, Чин сүжигт номун хан, Эрдэнэ ванд Санжаажав, Задрэгзэнэ
 нар,

- Жонон бэйл, Наран хутагт, Нар банчин хутагтад Содном, Гомбо нар,

- Хошууч бэйл, Дашпунцаглан хийдийн хошуу, Хамба номун ханд Доржпа-
 лам, Балган нар,

- Баатар бэйл, Далай ван, Эетэй гүнд Дэлджав, Бэхи нар,

- Сэцэн ван, Шива ширээт хутагт, Хатанбаатарт Очир, Нацагдорж нар,

- Мэргэн засаг, Сүжигт бэйс, Ачит гүнд төлөөний түшмэл Батсугар тусла-
 хын хамт,

- Зая бандида хутагт, Зоригт гүн, Түшээт гүнд төлөөний түшмэл Чойжил-
 сүрэн туслахын хамт,

- Бишрэлт бэйл, Саруул гүн, Эрх бэйсд Данзан, Чогчин нар”¹-ыг томилсон
 байна. Гэвч хошуудад түр цагийн хурал байгуулахад засаг ноёд, тайж нарыг
 оролцуулахгүй байх үүрэгтэй томилогдсон төлөөлөгчид хошууны засаг но-
 ёдтой хамтран хурлыг зохион байгуулах, зарим тохиолдолд засаг дарга удир-
 дан гүйцэтгэж байжээ.

Засагт хан аймгийн олон хошуудад нутгийн захиргаа байгуулах төлөөний
 түшмэлээр томилогдсон Эринжав: “Эдүгээ Монгол Улсын ардын Засгийн
 газраас олон аймаг шавьд томилогдсон төлөөний түшмэл өөр өөрийн аймаг
 хошуу шавь зэрэг газар одоо нутгийн захиргааг идэвхийлэн шаардан гүйцэ-

¹ УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-309. Тал 87-88а.

тгэхэд ... харьяат аймгийн хошуу шавьд түшмэл миний бие дараагаар одож уг хэргийг гүйцэтгэвээс зохих нь мөн тийм бөгөөд энэ хэрэг болвоос хүнд чухал хойш яашаар аваачиж үл болох учир миний бие зүүн этгээд захын Ахай бэйл Цэрэндорж, Далай гүн Содномваанчиг нарын хошуунаас үүсгэн дараалан одож гүйцэтгэн шийтгэхээр мордсон учир томилогдсон аймгийн 23 засаг, Шанздубын газар хуваан тушааж явуулан хүрмэгц байцаан үзэж өөр өөрийн харьяат хошуу шавьд нутгийн захиргаа байгуулах хэргийг тогтоосон дүрэм хэмжээний ёсоор тус тус түргэн үүсгэн шийтгэж цаг тухайд өчүүхэн төдий ч саатал дутагдал үгүй болгон бэлтгүүлж гүйцэтгэн шийтгэж уламжлан мэдүүлээд дав даруй шударга болгосугай. Үүнийг Хантайшир чуулганы дарга Цогтой ван, жанжин Сэцэн ван танд мэдэгдэн явуулаад байцаан томилж нэгэн адил шаардан гүйцэтгүүлмүй”¹ хэмээн Засагт хан аймгийн хошуудад хурлыг зохион байгуулахыг мэдэгдэж байжээ.

Мөн Сэцэн хан аймгийн Чин Ачит ван Тогтохын хошуунд төлөөний түшмэлээр Бат-Очирын бичигт: “Сэцэн хан аймгийн чуулган даргын газраас бидний эдүгээ сууж буй Чин Ачит ван Тогтохын хошууны бүх өрхийг 13 сум, 38 баг болгон зохиож, сум ба баг арван гэрийн хурал нээж тус тусын занги дарга нарыг сонгон баталж басхүү хошууны хуралд сум бүрээс дүрмийн ёсоор 5 төлөөлөгч ирүүлэн хошууны хурлыг байгуулан эдүгээ засаг Чин ачит ван Тогтохыг засаг даргад хэвээр баталжээ”² хэмээн тэмдэглэжээ.

Хошууны ард иргэдээс угсаа залгамжилсан засаг ноёдыг засаг даргад улируулан сонгох явдал ихээхэн гарч байв. Сэцэн хан аймгийн Манлай вангийн хошууны ардуудаас Хан Хэнтий уулын аймгийн яаманд өргөсөн бичигт: “Хошууны ард олон бүгдээр хуралдаж үүнд мэхийн хянаваас үзсэн бид нар угаас газар газрын хачин ядуу хүмүүст автономит Засгийн үед анх хошуу болон тохиносноос нааш улс төрийн гэгээн соёлд шүтэж энэхүү дарга Долсон өөрийн хөрөнгөөр хүмүүжүүлэн тэжээв. Ийнхүү дансанд албыг залгамжлуулан зүтгэж дорогш аж төрөн амьдарсаар эдүгээд хүрэв. Энэ хооронд харгислан дарласан хашраан зовоосон зүйлгүй учирт хошууны даргад хэвээр баталсан бөлгөө. Эдүгээ болбоос ардын гэгээн Засгийн зорилтод нийлүүлэн урагш дэвшиж, хойчийг сайжруулахыг удирдан оролдсоор бүхий”³ хэмээн хошууны дарга М.Долсонгийн чин зүтгэлийг үнэлэн засаг даргад сонгосноо илтгэж байжээ. Мөн Сайн ноён хан аймгийн Эрх гүний хошууны ардын хурал 29 гишүүнтэй хуралдаж “Эрх бэйс Содномбигмэддоржийг элдэвт тэнцэнэ. Олны зовлон зүдгүүрийг мэдэх бөгөөд эрдэм үсэгт боловсронгуй, үнэнч шударга”⁴ хэмээн 23 гишүүн сонгосноор засаг даргад сонгогджээ. Засгийн газраас “Эрх бэйс Содномбигмэддоржийн хошуунд нутгийн захиргаа байгуулж

¹ УТТА. Ф-1. Д-1. Хн-166

² УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-216а. Т.11.

³ ТЕГ-ын Тусгай архив. Сан-1. ДХГ. У. Хн-127

⁴ УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-306. Т.19-20.

засаг даргыг хэвээр баталсан нь дүрэм хэмжээ заавар тушаалд нийлэлцсэн”¹ хэмээн баталжээ. Энэ мэтчилэн эрдэм мэдлэг, ард олондоо нэр хүнд бүхий засаг ноёдыг засаг даргад сонгож, Монгол Улсад Засаг захиргааны өөрчлөлтийг явуулахад засаг ноёд гар бие оролцсоор байв.

Ардын Засгийн газраас явуулсан засаг ноёдыг улс төр, эдийн засгийн эрх мэдлээс нь холдуулах, улмаар нийгмийн өөрчлөлтийг хийх зорилтод хошууны ард олон нь бичиг үсгийн боловсролгүй, хошууны албан хэрэг хөтлөлт, үйл ажиллагааг явуулах чадамжгүй байдал нь саад болж байв. Дотоод Явдлын Яамны 1925 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн нэгэн бичигт: “Гишүүн Баттөмөрөөс харьяат хороонд өргөх бичгийн дотор өчүүхэн хүнийг манай хошуу харьяат хошууны даргад сонгож зохих газар мэдүүлэв хэмээнэ. Үүнд Баттөмөр би монгол үсэг огт танихгүй, мөн ер сурсан төсөөлсөн эрдэм чадалгүй дан ганц ардын хувьсгалт намын хэрэгт бат тангаргийг баримтлан сахиж мэтгэн зүтгэн явааг журмын нөхөд бэлхнээ толилцгоох ба хошууны даргын тушаал болбоос бичиг хэрэгт боловсронгуй эрдмийг сонгож тавих хэрэг мөн бөгөөд ... гишүүн миний эл үнэн учир байдлыг толилж тэрхүү тэнцэхгүй тушаалыг шилжүүлэх”²-ийг гуйж байжээ.

Нөгөөтээгүүр Ардын Засгийн газраас гаргасан эрх зүйн баримт бичгийн хүрээнд засаг дарга болж, эрх ямбаа хасуулсан засаг ноёд өөрийн саналаар засаг даргаас бууж байв. Тухайлбал: “Саруул гүн Дамдинжав бие өвчтэй учрыг гаргаж тушаалаас чөлөө гуйсныг ёсоор болгож”³ байжээ.

Засаг дарга нарыг сонгох асуудал нь хошуудад түр цагийн хурал байгуулахаар томилогдсон Засгийн газрын төлөөлөгчдийн үзэл бодол, хандлагаас хамаарч байсан байна. “Хан Хэнтий уулын аймгийн зүүн захын хошуу шавийн хурлыг удирдан нээлгэхээр тушаал гаргасан түшмэл Гомбосүрэн, Банзрагч, засаг дарга дархан хошой чин ван Намжилдэндэввандуйдоржийн тамгын хэрэг шийтгэгчдээс тус хошууны хурлыг нээлгэж хурлын тогтоол зэргийг зохих газар хүргүүлэн мэдүүлж батлуулах зэргийг учрыг гаргаж ... тушаасаар бүхий нь энэхүү ван Намжилдэндэввандуйдоржийн хошууны даргад чухам хэнийг сонгосон ба хуучин засгийг юу хэмээн огцруулсан зэрэг учрыг огт тодорхойлсонгүй”⁴ явуулж байсныг нь Засгийн газраас буцааж байсан байна.

Мөн засаг даргыг сонгох тухай асуудал дээр Монгол Улсын Ерөнхий сайд Б.Цэрэндорж Монгол ардын намын Төв хороонд: “Эдүгээ манай ардын Засгийн газраас Хан Хэнтий уулын аймгийн баруун захад суулгасан төлөөний түшмэл Одсэрээс, тус аймгийн Сэргэлэн гүн Дугарсүрэнгийн хошуунд одож хүн ам хөрөнгө малыг байцаан тодорхойлж нутгийн захиргаа байгуулан тодорхойлж нутгийн захиргаа байгуулан хошууны хурлыг удирдан нээлгэж хошууны даргад олонхын саналаар захирагч Уртнасанг сонгосон зэрэг учрыг

¹ УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-309. Т.121-122.

² УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-296. Т.1-8.

³ УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-309. Т.125-127.

⁴ УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-309. Т.119-120.

гаргаж Ардын Засгийн газар ба Ардын Намын Төв Хороо, Дотоод Явдлын Яам, Хан Хэнтий Уулын аймгийн яамдад арван тоот бичгээр өргөн мэдүүлж ирсэн нь манай Засгийн газар хүлээн авч байцааваас төлөөний түшмэл Одсэр Сэргэлэн гүн Дугарсүрэнгийн хошуунд нутгийн захиргаа байгуулсан зэрэг явдал цөм хэмжээ заавар тушаалд төлөв нийлэлцэхүй. ... засаг гүн Дугарсүрэн ард олныг харгислан дарласан ба албадан татварласан эсвэл тэр өөрөө эрдэм бичиг үл төсөөлөх, үхээнц дорой тушаалын хэргийг бүтээн чадахгүй болж засгаас огцруулахыг ирсэн зэргийн явдал буй аваас дүрмийн ёсоор учрыг тодорхойлон гаргаж хошууны даргад сонговоос зохихыг төлөөний түшмэл Одсэр мэдэхгүй хэмээвээс болохгүй. Одоо Дугарсүрэн тэр аль газраас ямар хэргийн учир хэрхэн чингэж засгаас огцруулсан болох нь тодорхойгүй битүүлэг. Энэ төдийгээр батлан тогтооход дүрэм хэмжээнд үл нийлэлцэх бөгөөд учир дутагдах зүйл буй тул зүй нь эгүүлэн тушааж байцаан тодорхойлвоос зохино”¹ хэмээн илгээснийг үзэхэд Монгол Улсын Ерөнхий сайдын зүгээс засаг ноёдыг засаг дарга болгон улмаар хошууны түр цагийн хурлыг байгуулж, засаг даргыг ард иргэдээс сонгохоор болгосон асуудал дээр туйлшралгүй дүрэм хэмжээг даган шийдвэрлэхийг эрмэлзэж байжээ.

Нөгөө талаар Засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэмтэй зэрэгцэн гарсан “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”-д: “Улсын ба аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн дарга хүртэл аливаа албан тушаалтан буюу тус бүрийн хурлын төлөөлөгчдийг сонгоход цөм эрхбиш ард олны зовлон зүдгүүрийг нэвтэрхий мэдэх олны тусыг бодох бөгөөд цэвэр, шударга ... хүнийг сонговол зохино” хэмээн заасан нь засаг ноёдыг улируулан сонгох шалтгаан болж байв. Энэхүү заалт ёсоор Чин ачит ван Тогтох, Манлай ван М.Долсон, Цогтой ван Дамдин-Абшаа зэрэг олон засаг ноёдын эрдэм мэдлэг, чадвар, шударгыг үнэлэн хошууны даргад сонгож байжээ.

Засаг дарга нараас хууч өвчтэй хэмээн Үйзэн бэйл Цэвэгжэв² засаг даргаас татгалзаж, Засагт хан аймгийн Жонон гүн Наваандорж³ сонгуульд нэр дэвшин ялагдаж, “Ёст бэйл Ширбазар”⁴, “Дайчин ван Жалцангомбодорж”⁵ нарын ноёд засаг даргын тушаалаас өөрийн сайн дураар огцорч, хэргэм зэргээсээ татгалзах болжээ.

Хошуу ноёдыг засаг дарга болгож, засаг захиргааны өөрчлөлтийг явуулсан нь Монгол улсын угсаа залгамжилсан алтан ургийн ноёдыг улс төр, эдийн засгийн хүрээллээс холдуулах, монголчуудын угсаа гарвалыг балартуулах нөхцөлийг бүрдүүлжээ. Энэхүү өөрчлөлтийг засаг ноёд хүлээн зөв-

¹ УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-309. Т.99-101.

² Засагт хан аймгийн Үйзэн бэйлийн хошууны сүүлчийн засаг ноёд Дамдинсүрэнгийн Цэвэгжав. 1915-1923 онд хошуун засаг ноён байсан.

³ Засагт хан аймгийн Жонон гүн хошууны сүүлчийн засаг ноён Юндэндоржийн Наваандорж. 1910-1923 онд хошууны засаг ноён байсан.

⁴ УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-309. Т.130-131.

⁵ УТНОНББТ. Ф-4, д-1. Хн-309. Т.150-151.

шөөрч хамтран зохион байгуулсан нь Ардын засгийг дэмжсэн хэрэг бөгөөд төрийн үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах бодлогыг баримталсан ажээ.

Засаг захиргааны өөрчлөлт явагдаж засаг ноёдын эрх мэдэл хязгаарлагдсанаар тэдгээрийн эдийн засгийн эрх мэдэлд халдах, хөрөнгийг хураахад дөхөм болж, улмаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэх нөхцлийг бүрэлдүүлж, хожим нь Монгол Улс ЗХУ-ын харьяанд орох хүртэл асуудал гарахад хүрч байжээ.

НОМ ЗҮЙ

Ашигласан эх сурвалж.

- [1] УТА. УТНОНББТ. Х-4, Д-1, ХН-196.
- [2] ТЕГ-ын Тусгай архив. Х-1, Д-1, ХН-127.
- [3] УТА. Х-1, Д-1, ХН-166.
- [4] УТА. УТНОНББТ. Х-4, Д-1, ХН-216а.
- [5] УТА. УТНОНББТ. Х-4, Д-1, ХН-296.
- [6] УТА. УТНОНББТ. Х-4, Д-1, ХН-306.
- [7] УТА. УТНОНББТ. Х-4, Д-1, ХН-309.

Судалгааны бүтээл.

- [1] Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. Улаанбаатар хот: [Ардын хэвлэлийн хороо, 1954.
- [2] Бат-Очир, Л. Халхын хаадын төгсгөл. Улаанбаатар хот: Согоо нуур хэвлэлийн газар, 2001.
- [3] Бауден, Ч.Р. Монголын орчин үеийн түүх. Улаанбаатар хот: Судар өргөө хэвлэлийн газар. 2018.
- [4] Бүгд Найрамдах Монгол Улсын Их, Бага хурлын тогтоо, үндсэн хууль, тунхгууд. Улаанбаатар хот: Улсын хэвлэл. 1956.
- [5] Бишрэлт гүн Сундуй: амьдрал, өв. Улаанбаатар хот: Эрдэм мэдээлэл хэвлэлийн газар. 2018.
- [6] Дашням, А. Халхын сайн ноён хан Намнансүрэн, Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. 1990.
- [7] Дангаасүрэн, Н. БНМАУ-ын капиталист бус хөгжилт ба хөдөө дэх нийгэм-эдийн засгийн өөрчлөлт. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. 1971.
- [5] Дөрвөд далай хан Г.Түмэндэлгэржав. /1874-1938/. Улаанбаатар хот: Соёмбо принтинг хэвлэлийн үйлдвэр. 2009.
- [6] Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. 1985.
- [7] Монгол Ардын Хувьсгалт Намын 3 дугаар их хурал. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. 1966.

[8] Монгол Ардын Хувьсгалт Намын 4 дүгээр их хурал. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. 1978.

[9] Монгол Ардын Хувьсгалт Намын 5 дугаар их хурал. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. 1981.

[10] МАХН-ын Их бага хурал, Төв Хорооны Бүгд хурлуудын тогтоол шийдвэр. /1921-1939/. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. 1956.

[] Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. 1966.

[11] Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974. Улаанбаатар хот. Улсын хэвлэлийн газар. 1976.

[12] Монгол Улсын Түүх. 5 дугаар боть. Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар. Адмон хэвлэлийн үйлдвэр. 2004.

[13] Монгол Улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсгал, өөрчлөлт. /XX зуун/ Улаанбаатар хот: Соёмбо принтинг хэвлэлийн газар. 2008.

[14] Монгол Улсын санхүү эдийн засгийн албаны 100 жил, Сангийн анхны сайд Г.Чагдаржавын мэндэлсний 140 жил. Эмхэтгэл. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг хэвлэлийн газар. 2011.

[15] Мөнх-Очир, Д. Азаяа, Д. Монгол Улсын аймаг, хошуу, сумын товчоо. Улаанбаатар хот: Соёмбо принтинг хэвлэлийн газар. 2014.

[16] Насанбалжир, Ц. Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1954.

[17] Хошуудын дарга сонгох ба аймгийн хаадын тамгын хураах тухай тогтоол. Улаанбаатар, 1924.

REFERENCES

Ashiglasan jeh survalzh.

[1] YTA. UTNONBBT. H-4, D-1. HN-19b.

[2] TEG-yn Tusgaj arhiv. H-1, D-1, HN-127.

[3] YTA. H-1, D-1, HN-166.

[4] YTA. UTNONBBT. H-4, D-1, HN-216a.

[5] YTA. UTNONBBT. H-4, D-1, HN-296.

[6] YTA. UTNONBBT. H-4, D-1, HN-306.

[7] YTA. UTNONBBT. H-4, D-1, HN-309.

Sudalgaany bytjejel.

[1] Ardyn zasgaas 1921-1924 onuudad avsan huv'sgalt arga hemzheenyd. Ulaanbaatar hot: []Ardyn hevlelijn horoo, 1954.

[2] Bat-Ochir, L. Halhyn haadyn tegsgel. Ulaanbaatar hot: Sogoo nuur hevlelijn gazar, 2001.

- [3] Bauden, CH, R. Mongolyn orchin yeijn tyyh. Ulaanbaatar hot: Sudar örgөө heвлелйн газар. 2018.
- [4] Bygd Najramdah Mongol Ulsyn Ih, Baga hurlyn togtoo, yndsen huul', tunhguud. Ulaanbaatar hot: Ulsyn hevlel. 1956.
- [5] Bishreлт гын Sunduj: am'dral, өв. Ulaanbaatar hot: Erdem medeelel heвлелйн газар. 2018.
- [6] Dashnyam, A. Halhyn sajn noyon han Namnansyren, Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. 1990.
- [7] Dangaasyren, N. BNMAU-yn kapitalist bus hөгzhilt ba hөдөө dekh nijgem-edijn zasgijn өөрчлөлт. Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. 1971.
- [5] Derved dalaj han G.Tymendelgerzhav. /1874-1938/. Ulaanbaatar hot: Soyombo printing heвлелйн yjldver. 2009.
- [6] Mongol Ardyn Huv'sgalt Namyn товч тyyh. Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. 1985.
- [7] Mongol Ardyn Huv'sgalt Namyn 3 dugaar ih hural. Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. 1966.
- [8] Mongol Ardyn Huv'sgalt Namyn 4 dygeer ih hural. Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. 1978.
- [9] Mongol Ardyn Huv'sgalt Namyn 5 dugaar ih hural. Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. 1981.
- [10] MAHN-yn Ih бага hural, Төв Horoony Bygd hurлуудын togtool shijdver. /1921-1939/. Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. 1956.
- [11] Mongol Ardyn Huv'sgalt Namyn тyyhend holbogdoh barimt bichgyyd. Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. 1966.
- [12] Mongol-Zөvlөлтйн harilcaa. 1921-1974. Ulaanbaatar hot. Ulsyn heвлелйн газар. 1976.
- [13] Mongol Ulsyn Tyyh. 5 dugaar bot'. Ulaanbaatar hot: Ulsyn heвлелйн газар. Admon heвлелйн yjldver. 2004.
- [14] Mongol Ulsyn hөгzhlijн bodlogo, yzel barimtlal: huv'sgal, өөрчлөлт. / HKH zuun/ Ulaanbaatar hot: Soyombo printing heвлелйн газар. 2008.
- [15] Mongol Ulsyn sanhyy edijn zasgijn albany 100 zhil, Sangijn anhny sajd G.CHagdarzhavyn mendelsnij 140 zhil. Emhetgel. Ulaanbaatar hot: Mөnhijn yseg heвлелйн газар. 2011.
- [16] Menh-Ochir, D. Azzayaa, D. Mongol Ulsyn ajmag, hoshuu, sumyn товchoo. Ulaanbaatar hot: Soyombo printing heвлелйн газар. 2014.
- [17] Nasanbalzhir, C. Ardyn zasgaas 1921-1924 onuudad avsan huv'sgalt arga hemzheenyyd. Ulaanbaatar: Ulsyn heвлелйн газар, 1954.
- [18] Hoshuudyn darga songoh ba ajmgijn haadyn tamgyn huraah tuhaj togtool. Ulaanbaatar, 1924